



ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2022 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он



ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2022 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Хянасан: Б.Энхгэрэл – ЗУХАГ-ын дарга
С.Энх-Эрдэнэ – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Эмхэтгэсэн: Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн

Тайлан гаргасан: А.Энхбаатар - КХ-ийн ахлах мэргэжилтэн
Х.Энхжаргал – КХ-ийн ахлах мэргэжилтэн
С.Ганцэцэг – ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн
Б.Мөнхзул - ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн
Р.Отгончимэг – ГЗБХ-ийн ахлах мэргэжилтэн
Ж.Баянмөнх – КХ-ийн мэргэжилтэн
Т.Нямжаргал - КХ-ийн мэргэжилтэн
Б.Урантөгс - КХ-ийн мэргэжилтэн
Д.Түмэндэмбэрэл- ЗУХАГ-ын мэргэжилтэн
Д.Мөнхцэцэг – ССМХ-ийн мэргэжилтэн
Ц.Ламзав - КХ-ийн мэргэжилтэн

АГУУЛГА

ОРШИЛ	4
1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН.....	5
1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэгжүүлсэн томоохон ажлууд	5
1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр.....	5
1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр.....	14
1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.....	18
1.1.4. Орон зайн мэдээлэл, технологийн чиглэлээр.....	39
1.2. Газрын харилцааны салбарын хүний нөөц	42
1.3. Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт	44
1.4. Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа	46
1.5. Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал	50
1.6. Газар эзэмших эрх болон өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байдлын тайлан	53
1.7. Газрын зах зээлийн тойм.....	56
1.8. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан.....	63
1.9. Сууц өмчлөгчдийн холбоонд ашиглаулж буй газрын тайлан.....	69
1.10. Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөө.....	70
1.10.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилт.....	70
1.10.2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилт, төлөвлөгөө боловсруулах чиглэлээр.....	73
1.10.3. Газар зохион байгуулалтын 2022 оны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөө.....	77
1.10.4. 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	95
2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН.....	101
2.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ-1, 5/	101
2.1.1.Хөдөө аж ахуйн газар.....	103
2.1.2.Хот, тосгон, бусад суурины газар.....	106
2.1.3.Зам, шугам сүлжээний газар.....	107
2.1.4.Ойн сан бүхий газар	107
2.1.5.Усны сан бүхий газар	108
2.2. Улсын тусгай хэрэгцээний газар /МАЯГТ ГТ-4/	109
2.3. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ-2/	113
2.4. Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ-3/.....	117
2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/	121
2.6. Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ-7/.....	126
2.7. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН /Маягт ГТ-8/	131
2.8. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /Маягт ГТ-9/	138
3. ДҮГНЭЛТ.....	141

ОРШИЛ

Монгол Улсын Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах, нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган Улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар Монгол Улсын Газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2.6-д заасан байдаг.

Дээрх заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас аймаг, нийслэлийн 2022 оны газрын нэгдмэл сангийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1-ГТ9 маягтуудын дагуу нэгтгэн улсын нэгдсэн тайланг гаргалаа.

Газрын нэгдмэл сангийн Улсын нэгдсэн тайлан нь тайлангийн хугацаанд газрын нэгдмэл сангийн ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрийн өөрчлөлтийг гаргах, өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой юм.




ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1.1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖЛУУД

1.1.1. Газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийг 2020 онд хөгжүүлж, [www.egazar.gov.mn](http://egazar.gov.mn) дамжуулан бүхий л салбарууд газар зохион байгуулалт, хот байгуулалт болон бусад орон зайн төлөвлөлтийг боловсруулах ажлыг хоорондоо харилцан уялдаатайгаар хийх боломж бүрдсэн. Мөн энэхүү систем нэвтэрснээр нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын мэргэжилтэн, сумын газрын даамлууд заавал байгууллагын дотоод сүлжээнд нэвтрэх, сүлжээний тохиргоо хийх зэрэг нэмэлт ажил, дэд бүтэц шаардахгүйгээр дурын операторын интернет ашиглан хэдийд ч хаанаас ч төлөвлөгөөгөө хялбар, энгийн байдлаар боловсруулах, хэрэгжилтийг гаргах бүрэн боломж нээгдлээ /Зураг 1.1.1.1/.



Зураг 1.1.1.1. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 2022 онд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн ГХБХБГ, сумдын газрын даамлууд улсын хэмжээнд нийт 1003 төлөвлөгөөний төсөл үүсгэж, 107949 арга хэмжээ төлөвлөж бүртгэнээс 51966 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Улсын хэмжээнд Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 8838 санал өгсөн байна.

Улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас авч нэгтгэлээ.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нийт 11 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Орхон аймгуудын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2022 онд хийгдэж дууссан, Архангай, Говь-Алтай, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Ховд аймгуудын ерөнхий төлөвлөгөө шинэчлэгдэн хийгдэж байна.

2022 онд хэрэгжсэн томоохон ажлуудаас дурьдвал салбарын хэмжээнд Газрын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн, мөн Газрын удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагаа тогтвортжуулах, ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн хил зааг, дэглэм тогтоох, сумын төв, хөдөөгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх, цэвэрлэх байгууламж шинээр барих, ойжуулалт, ойн зурvas байгуулах зорилтын хэрэгжилт сайн байна.

Харин хөв цөөрөм байгуулах газрын судалгаа хийх, газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах, рашаан сувиллын газрыг тохижуулах, Халх голын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх, их дээд сургуулиудын хоткон байгуулах, нүүлгэн шилжүүлэх, усан цахилгаан станцуудыг байгуулах судалгааны ажлыг эхлүүлэх, усны эх орчмын газар, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, гүний усны тэжээгдлийн муж, ангийн бүс, тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн газруудтай давхцалтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газруудын давхцалыг арилгах зэрэг ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Дорноговь аймгийн Сайншанд суманд “Дезерт солар повер вуан” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 30 МВт-ын хүчин чадалтай “Говь” нарны цахилгаан станц, Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 15 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц, Архангай аймагт “Ашид бэхи” ХХК цагт 60 м3 зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай бетон зуурмагийн үйлдвэр, Хөвсгөл аймагт “Хүслэнт бүтээмж” ХХК, “Өсөх бетон” ХХК-иуд бетон зуурмагийн үйлдвэр, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд “Дэлхийн хүнс” ХХК өдөрт 15 тн мах боловсруулах хүчин чадал бүхий дулааны аргаар боловсруулалт хийх 4 шат дамжлагатай махны үйлдвэр, “Дээжийн өргөө” ХХК мал нядалгааны үйлдвэрийг тус тус шинээр ашиглалтад оруулсан байна. Мөн Сүхбаатар аймаг нь “Махны үйлдвэр болон хорио цээрийн байгууламжийн цогцолбор” төслийн хүрээнд “Малын эрүүл бүс, хорио цээрийн байгууламж” баригдах газрыг Асгат сумын 3-р багийн нутагт 3114 га газрыг шийдвэрлэсэн, Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт “Талын таван өндөр” ХХК хоногт 100 бог, 60 бод төхөөрөх хүчин чадалтай мах боловсруулах, махыг чанах чиглэлийн үйлдвэр 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулан 20 хүнийг ажлын байраар хангаж, 1000 тн махыг Хятад улсад экспортлосон. Дундговь аймгийн

Өндөршил сумын “Азтай маамнууд” ХХК мал төхөөрч, мах ангилах үйлдвэрийн байрыг ашиглалтад оруулж, 50 тн мах бэлтгэсэн байна.


Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-ын 4-т нийт 8 /Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Архангай, Ховд, Говь-Алтай/ аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар тусгагдсан.

2021-2022 онд орон нутгийн төсвөөр нийслэл, Булган, Баянхонгор, Баян-Өлгий, Орхон аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэж оруулсан.

2022-2023 онд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Архангай, Говь-Алтай, Ховд буюу нийт 7 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө олон улсын төсөл, хөтөлбөр болон орон нутгийн санхүүжилтээр тус тус хийгдэж байна.

Цаашид Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Хөвсгөл, Увс аймгуудын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, тодотгох шаардлага тулгараад байна.




Зураг 1.1.1.2. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байдал

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-ын 5-т 54 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахаар тусгагдсаны дагуу Хэнтий аймгийн Галшар, Дархан, Баянмөнх, Хэрлэн, Хөвсгөл аймгийн Тариалан, Түнэл, Ховд аймгийн Буянт, Баянхонгор аймгийн Богд, Баянбулаг, Дорноговь аймгийн Алтанширээ нийт 10 сумын сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг 2022 онд боловсруулах ажил хийгдсэн байна.

2023 онд 7 аймгийн 88 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг олон улсын төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна.



Зураг 1.1.1.3. Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдсэн байдал

Хүснэгт 1.1.1.1. Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдсэн байдал.

Д/д	Аймгийн нэр	Төлөвлөгөө хийгдсэн сумдын тоо	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ		Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу 2022 онд хэрэгжсэн арга хэмжээ	
			Байршлын тоо	Газрын хэмжээ /га/	Байршлын тоо	Газрын хэмжээ /га/
1	Архангай	4	5528	944671.18	25	90193.99
3	Баянхонгор	6	3541	1442833.86	45	438747.32
4	Булган	15	17619	6301533.41	98	1176530.09
5	Говь-Алтай	4	3337	2801161.09	58	2116597.69
6	Говьсүмбэр	3	449	466705.03	134	456156.93
7	Дорноговь	3	84	844826.5	27	279465.08
8	Дундговь	15	24550	17231288.72	108	396269.71


9	Завхан	3	903	1831283.66	18	320294.11
10	Өвөрхангай	3	13941	1656896.38	12	14989.63
11	Өмнөговь	15	5929	8497941.6	137	429683.47
12	Увс	6	1227	90610.63	82	10562.44
Нийт		77	77108	42109752.06	744	5729490.46

"Монгол Улсын иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай" Засгийн газрын 121 дүгээр тогтоолын хэрэгжилт


Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 121 дүгээр тогтоолоор Улсын хэмжээнд нийт **32392** иргэнд **3967.8** га газрыг өмчлүүлэхээр баталснаас **18448** иргэнд **2102.52** га газрыг өмчлүүлсэн байна. Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй нийт **4431** иргэнд эзэмшиж байгаа **319.52** га, **14009** иргэнд шинээр **1781.02** га, **8** иргэнд аж ахуйн зориулалтаар үнээр нь **1.98** га газрыг тус тус өмчлүүлсэн байна.

Нийслэлийн хэмжээнд нийт **3244** иргэнд эзэмшиж байгаа **179** га газрыг өмчлүүлсэн байна.

Улсын хэмжээнд Засгийн газрын 121 дүгээр тогтоолын хэрэгжилт **52.9** хувьтай байна.



Зураг 1.1.1.4. 2022 онд иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн болон
өмчлүүлсэн газрын хэрэгжилт, байршилаар




*Зураг 1.1.1.5. 2022 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар болон
аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн газрын хэмжээ /га-аар/*

*“Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай”
Засгийн газрын тогтоолын төсөл:*

Монгол Улсын хэмжээнд **2022** онд нийт **29693** иргэнд **3593.20** га газрыг өмчлүүлэхээс **29679** иргэнд **3591.61** га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, **14** иргэнд **1.59** га газрыг аж ахуйн зориулалтаар тус тус өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэхээр төлөвлөсөн нийт **3591.61** га газрын 24 хувийг эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, 76 хувийг шинээр өмчлүүлэх газар тус тус эзэлж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт **4386** иргэний эзэмшиж буй **255.23** га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.



*Зураг 1.1.1.6. 2023 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар болон
аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн газрын хэмжээ /га-аар/*


Хөшигийн хөндийн газар чөлөөлөлт:

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 140 дүгээр, 2016 оны 154 дүгээр, 2021 оны 307 дугаар тогтооцуудаар нийт 31475.3 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авсан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 240 дугаар тушаалаар газар чөлөөлөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулан батлуулсан, мөн 1:500-ны масштабтай байрзүйн зураг ортофото зургийг тус тус хийлгүүлсэн.

Эдийн засгийн чөлөөт бүс, ложистикийн бүс, оюутны хоткон, худалдаа, олон нийтийн бүсүүдийн төлөвлөлттэй шилжүүлэх ажил хийгдэж байна. Үүнээс Төв аймгийн Алтанбулаг суманд 672 нэгж талбар байршил шилжүүлсэн, Сэргэлэн суманд 359 нэгж талбар хүчингүй болсон, одоо 2023 нэгж талбар үлдсэн.

Нийт 3054 нэгж талбар нөлөөлөлд өртөж, бүртгэл судалгааг хийсэн.



Зураг 1.1.1.7. Хөшигийн хөндийн тусгай хэрэгцээний газрын газар ашиглалтын өнөөгийн байдал

Мэргэн Тоньюкукийн цогцолбор музей баригдах газрын газар чөлөөлөлт

Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 35 дугаар тушаалаар нийслэлийн Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ сум хоорондын хилийн цэс орчмын газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах, Мэргэн Тоньюкукийн цогцолбор музей баригдах 20 га газрыг чөлөөлөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Тус музей баригдах газарт 13 иргэний газар өртсөн бөгөөд өмчлөх эрхтэй 11 иргэнтэй байршил, шилжүүлэхээр зөвшилцэж, эзэмших эрхтэй 2 иргэний газрыг Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар хүчингүй болгосон. Зөвшөөрөлгүй газар эзэмшсэн иргэн өөрөө газраа чөлөөлөх хүсэлт ирүүлснээр нөлөөлөлд өртсөн иргэдээс гомдол, маргаан нөхөн олговорын зардал гаргахгүйгээр ажлыг зохион байгуулж газрыг чөлөөлсөн.



Зураг 1.1.1.8. Мэргэн Тоньюкукийн цогцолбор музейн газрын газар чөлөөлөлт

Газар зохион байгуулалтын чиглэлээр зохион байгуулсан сургалт:

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн хэрэглээний чиглэлээр танхимаар нийт 13 удаагийн сургалт зохион байгуулж, 352 орчим мэргэжилтнийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан.

21 аймгийн газар зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах мэргэжилтнүүдэд 2 удаагийн сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, мэргэжилтнүүдийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих ур чадваруудыг тус тус эзэмшүүлсэн.

Мөн цахимаар нийт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 130 орчим мэргэжилтэн, шинээр томилогдсон газрын даамлуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан.

Газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Газрын багц хуулийн ажлын хэсэгт хуулийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж, хууль сурталчлах аяныг 21 аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын албандаа зохион байгуулж ажиллаж байна.

Газрын ерөнхий хуулийн төсөлтэй уялдуулан дараах эрхзүйн баримт бичгүүдийн төслийг боловсруулаад байна. Үүнд:

- "Газар зохион байгуулалт хийх журам"-ын төслийг боловсруулан 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/2235 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн.
- "Улсын тусгай хэрэгцээний газрыг төлөвлөх, ашиглах, хамгаалах журам"-ын төслийг боловсруулсан.
- Аймаг, сумын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачлалын төслийг "Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлыг хамгаалах төсөл" "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь төсөл"-үүдтэй хамтран боловсруулж, тухайн төслийг салбарын мэргэжилтэн, мэргэжлийн эрх бүхий байгууллагын төлөөлүүдийг оролцуулан МУИС-ийн Номын сангийн хурлын танхимд 2022 оны 10 сарын 28-ны өдөр хэллцүүлэг зохион байгуулсан.

1.1.2. Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажил

Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтсон хугацаанд тогтмол хянах, өөрчлөлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ашиглалтыг тохишуулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох мэдээллийн санг үүсгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, бэлчээрийн газрын хөрсийг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах суурь мэдээлэл болгох зорилгоор бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг Улсын хэмжээнд 7 дахь жилдээ зохион байгуулан ажиллаж байна.

Хэрэглээний давуу тал: Бэлчээрийн газарт фото мониторинг хийх аргын давуу тал нь богино хугацаанд нэг дор олон мэдээллийг цуглуулах, хэрэглэхэд энгийн, зардал багатай, сэргэн ургалт, доройтлын урт, богино хугацааны өөрчлөлтийг харуулдагт оршино.

Үр дүн: 2022 оны байдлаар бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 322 сумын хэмжээнд 109.4 сая га бэлчээрийн газрын 5166 мониторингийн цэгт зохион байгуулан ажилласан байна /Хүснэгт 1.1.2.1/.

Хүснэгт 1.1.2.1. Бэлчээрийн мониторингийг төлөөлж буй талбайн хэмжээ.


№	Аймаг/нийслэл	Сум/дүүргийн тоо	Мониторингийн нийт цэгийн тоо	Төлөөлж буй талбайн хэмжээ /га/
1	Архангай	18	328	3,742,769
2	Баянхонгор	19	314	8,638,195
3	Баян-Өлгий	13	328	3,057,235
4	Булган	16	208	2,195,675
5	Говь-Алтай	18	347	8,170,169
6	Говьсүмбэр	3	48	468,768
7	Дархан-Ул	3	27	146,962
8	Дорнод	13	243	8,797,690
9	Дорноговь	14	228	8,957,448
10	Дундговь	15	233	6,908,383
11	Хэнтий	17	353	5,695,197

12	Ховд	17	203	5,564,012
13	Хөвсгөл	23	366	3,625,479
14	Сэлэнгэ	17	100	1,607,452
15	Сүхбаатар	13	250	7,823,886
16	Төв	26	264	5,229,240.4
17	Өмнөговь	15	197	10,138,303
18	Увс	19	348	6,153,257
19	Завхан	23	440	6,919,912
20	Орхон	2	8	28,009
21	Өвөрхангай	18	293	5,655,104
22	Улаанбаатар	6	40	244,195
ДҮН		328	5166	109,767,340.7

Бэлчээрийн газрын төлөв байдлын өөрчлөлт: 2017 оны бэлчээрийн газрын төлөв байдал, мониторингийн үр дүнг 2022 он хүртэлх үр дүнтэй харьцуулахад бэлчээрийн төлөв байдлын доройтлын хэмжээ жил бүр нэмэгдсэн байна /Хүснэгт 1.1.2.2/.

Хүснэгт 1.1.2.2. Бэлчээрийн доройтлын ангиллын хувь

№	Бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	I-Байгалийн унаган төрхөө алдаагүй	30%	19%	17%	11.5%	13.5%	12.4%
2	II - бага зэрэг доройтсон	54%	38%	35%	46.6%	45.6%	52.3%
3	III - Дунд зэрэг доройтсон	12%	19%	22%	19.6%	19.3%	15.8%
4	IV- Хүчтэй доройтсон	4%	20%	21%	16.6%	14.9%	14.4%
5	V - Маш хүчтэй доройтсон	0%	4%	5%	5.7%	6.7%	5.1%
Нийт хувь		100	100	100	100	100	100



Зураг 1.1.2.1. 2022 оны бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зураг

Бэлчээрийн доройтлын байдал: 2022 оны байдлаар нийт бэлчээрийн газрын 13'627'365.1 га талбай буюу 12.4% нь байгалийн унаган төрхөө алдаагүй, 57'276'553.9 га талбай буюу 52.3% нь бага зэрэг доройтсон, 17'285'023.6 га талбай буюу 15.8% нь дунд зэрэг доройтсон, 15'716'436.7 га талбай буюу 14.4% нь хүчтэй доройтсон, 5'580'597.8 га талбай буюу 5.1% нь маш хүчтэй доройтсон байна.

Бэлчээрийн даац: 2022 оны байдлаар бэлчээрийн мониторингийн үр дүнгээр хонин толгойд шилжүүлснээр аймгуудын бэлчээрийн даацыг гаргасан байна /Хүснэгт 1.1.2.3/.

Хүснэгт 1.1.2.3. Бэлчээрийн даац, аймгуудаар

№	Аймаг	Бэлчээрийн талбай (га)	Тэжээлийн нөөц, кг	Өвөл, хаврын бэлчээрийн даац хонин толгой	Малын тоо хонин толгой, 2021 он	Зөрүү
1	Архангай	3,737,478	962,026,811	3,435,810	11,528,897	(8,093,087)
2	Баянхонгор	8,821,142	724,039,344	3,697,852	4,938,878	(1,241,026)
3	Баян-Өлгий	3,523,448	350,089,793	2,066,646	3,886,209	(1,819,563)
4	Булган	2,484,150	804,268,404	2,931,007	6,698,327	(3,767,320)
5	Говь-Алтай	8,601,261	557,361,719	2,846,587	4,018,476	(1,171,889)
6	Говьсүмбэр	472,588	65,330,524	303,017	654,159	(351,142)
7	Дархан-Уул	175,306	55,114,040	200,853	731,078	(530,225)
8	Дорнод	8,656,658	2,061,905,492	7,514,233	6,968,903	545,330
9	Дорноговь	9,087,156	1,059,925,841	6,256,941	4,473,731	1,783,211

10	Дундговь	7,145,882	997,107,847	5,886,115	4,471,576	1,414,539
11	Хэнтий	5,008,113	1,346,477,505	4,906,988	8,922,716	(4,015,728)
12	Ховд	5,057,254	830,198,866	4,900,820	5,430,760	(529,940)
13	Хөвсгөл	4,385,355	1,597,672,534	7,032,009	10,347,453	(3,315,444)
14	Сэлэнгэ	1,606,546	358,619,535	1,132,006	3,952,510	(2,820,504)
15	Сүхбаатар	7,668,543	1,034,218,052	6,105,183	7,828,165	(1,722,982)
16	Төв	5,162,131	1,657,547,262	6,040,624	8,348,501	(2,307,877)
17	Өмнөговь	11,426,886	592,369,786	3,496,870	3,765,317	(268,447)
18	Увс	4,108,918	525,415,499	3,101,626	5,852,801	(2,751,175)
19	Завхан	6,515,510	1,567,524,248	5,712,552	6,397,518	(684,966)
20	Орхон	39,308	6,283,023	22,666	365,165	(342,499)
21	Өвөрхангай	5,688,419	1,251,314,148	4,560,183	6,765,373	(2,205,191)
22	Улаанбаатар	212,588	52,978,981	193,072	1,225,578	(1,032,506)

2022 оны байдлаар Улсын хэмжээнд бэлчээрийн мониторингийн үр дүнгээр хонин толгойд шилжүүлснээр 82 сая мал өвөлжиж, хаваржих боломжтой байна. Жилийн эцсийн малын тоо 117 сая хонин толгой байгаа ба энэ нь боломжит даацаасаа 35 сая хонин толгойгоор хэтэрсэн байна.

Бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх ажил: Бэлчээрийн фото мониторингийн ажлын тухайн оны үр дүнг ашиглан бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх үйл ажиллагааг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах боломж бүрдсэн байна.

2022 онд 17 аймгийн хэмжээнд нийт 4'471'228 га талбайд бэлчээрийн хөрс хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулсан байгаа бөгөөд 1'970'265.7 га талбайг чөлөөлсөн, 20'144 га талбайг хашиж хамгаалсан, 319'649 га талбайг бэлчээр усжуулсан, 1'728'714 га талбайг өнжөөж сэлгэсэн, 433'027' га талбайд хортон мэрэгчтэй тэмцэх ажлуудыг тус тус хийсэн байна. Энэ нь өмнөх оны хамгаалах арга хэмжээнээс 2'041'149 га талбайгаар бага байна.



Зураг 1.1.2.1. Бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийсэн ажил

Бэлчээрийн газрыг төлөөлүүлэн фото мониторингийн хээрийн судалгаа хийж, мониторингийн цахим системд мэдээллийг оруулж, 5166 мониторингийн цэгийн мэдээллийг <https://egazar.gov.mn/map> вебээр хэрэглэгчдэд хүргэж байна.

1.1.3. Газрын кадастр, мэдээллийн сангийн чиглэлээр.

Монгол Улсын Засгийн газраас 2021-2024 онд “Цахим үндэстэн” болох зорилт дэвшиүүлсний хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Газрын харилцааны цахим шилжилтийн хүрээнд томоохон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байгаа бөгөөд газрын кадастрын чиглэлээр 2022 онд доор дурдсан томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Газрын кадастрын мэдээллийн системийн гар утасны мессеж үйлчилгээ

Иргэн, хуулийн этгээдэд өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг тухай бүр мэдээлэх гар утасны мессеж үйлчилгээг 152270 тусгай дугаараар дамжуулан олон нийтэд хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд тайлант онд 48547 мессежийг иргэд, олон нийтэд хүргэсэн байна.



Зураг 1.1.3.1. Гар утасны мессеж үйлчилгээ

Газрын харилцааны КИОСК төхөөрөмж

Газрын харилцааны талаарх бүх төрлийн мэдээлэл, үйлчилгээг авах боломжтой цахим машиныг Улсын хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Өмнөговь, Баян-Өлгий, Хэнтий, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Төв, Ховд аймгууд нийт 27 төхөөрөмжийг хэрэглээнд нэвтрүүллээд байна.

Хэрэглэгч үйлчилгээг өөрийн регистрийн дугаар болон системд бүртгэлтэй утасны дугаараа ашиглан нэвтэрч, Газрын харилцааны киоск машинаас нийт 45 орчим төрлийн газрын харилцаатай холбоотой үйлчилгээг авах бөгөөд 32 төрлийн өргөдлийг цахимаар өгөх, 12 төрлийн мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг үнэ төлбөргүй хэвлэн авах, мөн цахим хүсэлт, өргөдлийнхөө шийдвэрлэлтийн явцыг шалгах, цахим гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг, тооцоо нийлсэн акт, нэгж талбарын тодорхойлолт, лавлагааг хэвлэн авах, газрын төлбөртэй холбоотой мэдээллийг авах, газрын төлбөрөө цахимаар төлөх гэх мэт зэрэг үйлчилгээнүүдийг шууд авах боломжтой юм.




Зураг 1.1.3.2. Газрын харилцааны КИОСК төхөөрөмж

Энэхүү киоск машин нэвтэрснээр газрын харилцааны салбарын шаардлагагүй шат дамжлагыг цөөлөх, төрийн байгууллагын хүнд суртал, оочир дарааллыг бууруулах, нээлттэй ил тод байдлыг хангах томоохон дэвшлийг авчирч байна.

Хаягийн мэдээллийн нэгдсэн систем

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 180 дугаар тогтоолоор “Хаягийн мэдээллийн систем”-ийг Улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн.



Зураг 1.1.3.3. Хаягийн нэгдсэн цахим систем



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

**ХАЯГИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ХЭРЭГЛЭЭНД
НЭВТРҮҮЛЭХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Хаягжуулалтын тухай хуулийн 4.9, Улсын буртгэлийн ерөнхий хуулийн 9.7, 9.11-д заасныг тус тус үндэслэн "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.7.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг орон зайн өгөгдөл, мэдээллийн геопорталаар дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэхээр тогтсугай.
2. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүн, холбогдох албан тушаалтанд даалгасугай:
 - 2.1.хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг ашиглах, мэдээлэл солилцох, хөгжүүлэх, олон нийтэд мэдээлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Улсын буртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай)-т;
 - 2.2.хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт;
 - 2.3.хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийн ноец хувилбарыг "Үндэсний дата төв"-д байршуулах, аюулгүй байдлыг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (А.Энхманлай), "Үндэсний дата төв" УТҮГ (М.Баттулга)-т.
3. Харьялах нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, үл хедлех хөренгийн хаягийн мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хаягжуулах ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шаардагдах хөренгийн эх үүсвэрлийг орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хаягжуулалтын үйл ажиллагааг дэмжих ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Барилга, хот байгуулалтын сайд Б.МӨНХБААТАР

Зураг 1.1.3.4. Хаягийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх тухай Засгийн тогтоол

Хаягийн нэгдсэн цахим систем нэвтэрсэнтэй холбоотойгоор "Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам"-ын төслийг боловсруулсан бөгөөд удирдлагын зүгээс тус журмыг аргачлал хэлбэрээр батлуулахаар шийдвэрлэсний дагуу дахин засварлаж, Газрын даргын 2022 оны А/124 дүгээр тушаалаар батлуулсан.

Хаягийн мэдээллийн системийн хэрэглээнд нэвтрүүлснээр Улсын хэмжээнд 50530 гудамж, 1079711 нэгж талбарын 817826 орц гарц, 689888 барилгын 91267 орц, гарцыг хаягийн мэдээллийн системд бүртгэсэн.

Хүснэгт 1.1.3.1. Хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн мэдээлэл

Д\д	Улсын хэмжээнд	Гудамж	Нэгж талбар			Барилга	
			Нийт	Газар зүйн нэрээс хаяг олгосон	Орц гарц	Нийт	Орц гарц
1	21 аймаг	40036	640010	178041	361517	364919	75885
2	Нийслэл	10494	439701	2986	456309	324969	15382
Нийт	50530	1079711	181027	817826	689888	91267	

Хүснэгт 1.1.3.2. Нийслэл, 9 дүүргийн хэмжээнд Хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн мэдээлэл

Д\д	Дүүргийн нэр	Гудамж	Нэгж талбар			Барилга	
			Нийт	Газар зүйн нэрээс хаяг олгосон	Орц гарц	Нийт	Орц гарц
1	Багануур	757	29149	277	29085	3103	193
2	Багахангай	336	10963	3	10969	407	38
3	Баянгол	340	14409		14646	29205	2555
4	Баянзүрх	2218	71315		71687	65865	3276
5	Налайх	601	22380	2656	22651	6156	200
6	Сонгинохайрхан	2811	155184	9	167420	89308	3451
7	Сүхбаатар	1101	55227	41	55702	39597	2011
8	Хан-Уул	1060	35945		37541	34234	2334
9	Чингэлтэй	1270	45129		46608	57094	1324
НИЙТ		10494	439701	2986	456309	324969	15382

Хүснэгт 1.1.3.3. 21 аймгийн хэмжээнд Хаягийн мэдээллийн санд 21 аймгийн хэмжээнд үүссэн өгөгдөл

Д\д	Аймгийн нэр	Гудамж	Нэгж талбар			Барилга	
			Нийт	Газар зүйн нэрээс хаяг олгосон	Орц гарц	Нийт	Орц гарц
1	Архангай	1843	24393	4845	16755	15786	7038
2	Баян-Өлгий	1542	28014	3084	19240	36002	3130
3	Баянхонгор	1091	24020	9104	13401	10075	6501
4	Булган	2021	32260	15675	13398	17633	1125
5	Говь-Алтай	1259	20028	10169	5770	12112	3267
6	Говьсүмбэр	690	12105	1143	11339	2676	41
7	Дархан-Уул	2115	26190	7682	12730	14766	4631

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

8	Дорноговь	2109	36720	10935	23451	20344	1068
9	Дорнод	3279	44593	7157	42044	14070	3234
10	Дундговь	1181	22385	5436	16661	4787	96
11	Завхан	1473	21502	5254	13945	18199	8566
12	Өвөрхангай	2643	34996	10483	4053	18840	24
13	Өмнөговь	1515	39661	10002	11979	10323	1297
14	Орхон	1261	15211	636	9606	21018	9
15	Сүхбаатар	1138	10079	217	7378	8369	1722
16	Сэлэнгэ	3871	62718	11072	51909	28471	18870
17	Төв	3249	78417	42400	30717	20942	4290
18	Увс	1432	21776	5867	12778	21050	289
19	Ховд	1113	18092	3901	10484	18605	7856
20	Хөвсгөл	2990	39771	6692	26415	37362	56
21	Хэнтий	2221	27079	6287	7464	13489	2775
НИЙТ		40036	640010	178041	361517	364919	75885

Хаягжуулалтын ажлыг Улсын хэмжээнд хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх ажлын хүрээнд:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны А/81 тоот “Хаягжуулалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах тухай” тушаалаар 21 аймгийн хэмжээнд замын уулзвар дахь тэмдэг, тэмдэглэгээ стандартын дагуу хийгдсэн эсэх, хаягийн тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу тэмдэгжүүлсэн эсэх, Сумын ИТХ-аар гудамж, зам талбайн нэршилийг тогтоосон эсэхэд хяналт, шалгалт хийсэн.

Барилга, хот байгуулалтын Сайд, Цахим хөгжил, харилцааны холбооны Сайдын хамтарсан 2022 оны 227/A76 дугаар тушаалаар хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, “Хаягжуулалтын ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан бөгөөд Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлэхэд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, зардлын асуудлыг шийдвэрлэх, өгөгдөл мэдээллийг нэгтгэх, мэдээллийн сангийн бүтэц зохион байгуулалтыг нарийвчлах, дундын мэдээллийн санг байгуулах зэрэг ажлыг зохион байгуулсан.

Хаягийн мэдээллийн цахим системийг байгуулж, Улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд журмын тодорхой заалтуудад өөрчлөлтүүдийг оруулж, Засгийн газрын 2022 оны 181 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

Тус журамд нийт 11 төрлийн өөрчлөлтийг оруулсан бөгөөд өмнөх журамд тодорхойгүй байсан асуудлуудыг нарийвчлан тусгасан.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Хаягжуулалтын тухай хуулийн 4.7, 4.9-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам шинчлэн батлах тухай" Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 325 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ын 5.5, 5.6, 5.7, 6.1, 6.4, 6.6, 6.14, 6.18 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:
 - 1/ "5.5.Аймгийн хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн хэмжээнд нийслэлийн Газар зохион байгуулалтын алба энэхүү журмын 5.2.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгөд байршилын хаяг олгоно."
 - 2/ "5.6.Аймгийн хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн хэмжээнд нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар энэ журмын 5.2.2, 5.2.3-т заасан үл хөдлөх эд хөрөнгөд байршилын хаяг олгоно."
 - 3/ "5.7.Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар нь холбогдох байгууллагын хүснэгтийн дагуу байр зүйн гүйцэтгэлийн зургийг үндэслэн тусгай зориулалтын барилга байгууламжийн байршилын хаягийг олгоно."
 - 4/ "6.1.Гудамж, зам, талбай, газар, үл хөдлөх эд хөрөнгийг энэ журам, холбогдох стандартын шаардлагын дагуу хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэж, хаягжуулна."
 - 5/ "6.4.Энэ журмын 5.2.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгийг дараалсан дугаарлалтын аргаар 1-зэс эхлэн дугаарлана."
 - 6/ "6.6.Гудамжны нэрийн ард зураас татааж үл хөдлөх эд хөрөнгийн дугаарыг бичнэ. Жишээлбэл: Ц.Жигжиджавын гудамж-302 гэх мэт."
 - 7/ "6.14.Үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн орон сууцны зориулалттай барилга байгууламжийг дугаарлахдаа нэгж талбарын хаягийн дугаарын ард ташуу зураас татааж дараалсан хувьсах дугаарлалтын аргаар дугаарлана. Жишээлбэл: нэгж талбарын хаяг 100 бол барилга байгууламжийг 100/1, 100/2."
 - 8/ "6.18.Хот, суурин газар дахь гэр хорооллын амины орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө буюу хашаа, байшин, тусгай зориулалтын үл хөдлөх эд хөрөнгийн дугаар шуудангийн нэгдсэн код дотор давтагдахгүй байна."
2. Мен журмын 4.1 дэх заалтын хүснэгтийн "Шуудангийн бүсчлэлийн код:" гэснийг "Шуудангийн нэгдсэн код:" гэж өөрчилсүгэй.
3. Мен журмын 6.19 дэх заалтыг хассугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Барилга, хот байгуулалтын сайд Б.МӨНХБААТАР

Зураг 1.1.3.5. Засгийн газрын 2022 оны 181 дүгээр тогтоол

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн шийдвэрээр "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавигдах шаардлага MNS 5283:2022"-ыг шинчлэн батлуулсан.


МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ	
Ангилалтын код 01.080.10; 03.240	
Гудамж, зам, талбай, ул хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягин тэмдэгт тавих шаардлага	MNS 5283:2022
General requirements for address sign of street, road, square, immovable properties, organizations and companies	MNS 5283:2014-ийн оронд
Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн С/41 дүгээр тушаагаар батгал.	
Энэ стандарт нь 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс хэтчен хүчинтэй.	
1 Хамрах хурз Энэ стандартадаар гудамж, зам, талбай, тухуу сойлын дурсгалт газар, ул хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэг, хаягийн зурган самбар болон төрийн байгууллагын хаягийн самбарын ногт загвараар ўйлдвэрлэх, байрлуулж, надгэн загвар, аргачланы тодорхийно.	
Энэ стандартын Монгол Улсын нутаг давсгэрийн хэмжээнд сууринсан хэсгийн гудамж, зам, талбай, ул хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын баталгаажсан хаягай тэмдэгжүүлэхад мөрнөн.	
2 Норматив эшэлэг Энэ стандартадаар даврах эш тасны баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшпэлийн хувьд дурдсан хэвлэл, харин хугацаа заагаагаа эшпэлийн хувьд хамгийн суурин хэвэлтийг хөгжнэ. Үүнд:	
MNS ISO 3098-2:2003, Техникийн бичиг баримт. Шрифт. 2-р хэсэг. Латин цагаан толгоог болон бусад төмөнг.	
MNS ISO 3098-6:2003, Техникийн бичиг баримт. Шрифт. 6-р хэсэг. Кирилл цагаан толгоог.	
MNS 5217:2012, Монгол кирилл үсгийн латин хөрөнгүүлэг.	
MNS 4333:1996, Монгол бичигийн цагаан толгоог.	
MNS 6275:2011, Нээсэн хаягуулалт, Хаягийн бичвэрт тавих шаардлага. А, В хөөрчилж.	
3 Нэр томъёо, тодорхойлолт Энэ стандартадаар дараах нэр томъёо, тодорхойлолтыг хөгжнэ.	
3.1	
MNS 5283:2022:2022 стандарт	
3.2	
Хаягийн зурган самбар	
3.3	
Хаягийн тэмдэг	
3.4	
Хаягийн самбар	
3.5	
Хаягийн самбарыг дараах төрөлтэй бичигтэй тодорхойлжин:	
4.1 Энэ стандартадаар аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбарыг дараах төрөлтэй бичигтэй тодорхойлжин:	
4.1.1 Төрийн байгууллагын хаягийн самбар;	
4.1.2 Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн самбар;	
4.1.3 Объектын байрлалыг чиглэгдэж заасан самбар;	
4.1.4 Тухуу сойлын дурсгалт газрын самбар.	
4.2 Энэ стандартадаар хаягийн тэмдэгийн дараах төрөлтэй бичигтэй тодорхойлжин:	
4.2.1 Гудамжийн хаягийн тэмдэг;	
4.2.2 Ул хөдлөх эд хөрөнгийн (байшин, барилга, хаашаа, орцны / хаягийн тэмдэг;	
4.2.3 Байгууллагын нэрний тэмдэг;	
4.2.5 Байшин доторх хаалтын тэмдэг.	
5 Ерөнхий шаардлага	
5.1 Хаягийн зурган самбарт тавих шаардлага	
5.1.1 Заасан захиргааны ногт болон хороолол, хоткон, талбай, төлөвлөлтүүг сууринсан хэсгэг нь хаягийн зурган самбартай байна	

Зураг 1.1.3.6. Шинэчлэн баталсан MNS 5283:2022 стандарт.

Газрын кадастрын мэдээллийн сангийн хөгжүүлэлт


Газрын кадастрын мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, тайлант хугацаанд нийт 12 төрлийн өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Үндсэн мэдээллийн санд орж буй өөрчлөлтийг 4 төрлийн давхартгатай (Кадастрын үндсэн нэгж талбар давхарга, UbGis мэдээллийн сан, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн мэдээллийн сангийн давхарга, Нууцын давхарга,) давхцуулан шалгаж давхцалгүй болон алдаагүй үед мэдээллийн санд бүртгэдэг өөрчлөлтийг хийж гүйцэтгэсэн.




Зураг 1.1.3.7. Газрын кадастрын мэдээллийн сан

Үндсэн нэгж талбар давхаргад өөрчлөлт оруулах үйлдлийг зөвхөн кадастрын асуудал хариуцсан мэргэжилтнүүд гүйцэтгэдэг байх өөрчлөлт, гэрчилгээ хэвлэх хүсэлтийг жагсаалтаар харуулж хүсэлтийг зөвшөөрөх үйлдлийг хялбарчлах, өөрчлөлтийн түүх буюу Лог файл хардаг болгох зэрэг өөрчлөлтүүдийг тухай бүр хийж гүйцэтгэн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.



Зураг 1.1.3.8. Цахим гэрчилгээ хэвлэх хүсэлтийн шийдвэрлэлт

Нууцын болон хаалтын давхаргуудын мэдээллийг админ удирдах боломжийг бүрдүүлсэн бөгөөд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нууц хамгаалах ажилтан нь тухайн давхаргыг харах, хянах боломжтой болсон.



Зураг 1.1.3.9. Веб систем дээрх нууцын давхарга

Мөн нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд болон 330 сумын газрын даамал нартай тогтмол холбогдон Газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулах, иргэдэд газрын үйлчилгээг цахимаар хүргэх болон, ирүүлсэн цахим хүсэлтуүдийг хэрхэн шийдвэрлэх талаар тухай бүрд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч Газрын кадастрын мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй өдөр тутамд /нэг мэргэжилтэн давхцсан тоогоор өдөрт дунджаар 35, сард 650, жилд 6500/ холбогдон ажиллаж, тухай бүр мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.


3D болон 4D хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн систем байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл

“Улсын хэмжээнд 3D болон 4D хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн систем байгуулах ажлын ТЭЗҮ боловсруулах” ажлын даалгаврын төслийг боловсруулан БХБЯ-аар 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан бөгөөд холбогдох хууль, журмын дагуу тендер зарлан гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд Б.Галмандах ахлагчтай “Зөвлөх баг”-тай 2022 оны 04 дүгээр 01-ний өдрийн 2022/96 тоот ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажилласан.

<p>БАТЛАВ: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМЫН ТӨРИЙН НАРИИН БИМГИЙН ДАРГА САННЯЛСҮҮРЭН</p> <p>“УЛСЫН ХЭМЖЭЭНД ГУРАВ БОЛОН ДӨРВЕН /3D, 4D/ ХЭМЖЭЭСТ КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЛЭЭНД ИЗВЕРТҮҮЛЭХ АЖЛЫН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ” ЗӨВЛӨХ БАГ</p> <p>2021 оны 27 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>№ 2021/96</p> <p>Улаанбаатар хот</p>		
д/а	Ажлын нэр, терел	Тайлбар
1.	Ажлын нэр: Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	<ul style="list-style-type: none"> - Газрын тухай хууль; - Геодези, зураг зүйн тухай хууль; - Кадастрын зурагтап байгаа газрын кадастрын тухай хууль; - “Альянс хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичийн зорилт: <ul style="list-style-type: none"> - 3.8. Ухаалаг, иргэн төвтэй газрын ногдамж удирдлага, мөнөжүүлийн тогтолцог хөгжлийн замвар талш байдал, шударга ёс, ундээсний адил засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн хангана; - “Альянс хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хуранд, 2021-2030 онд хөгжлийн улт ажлыглагас: <ul style="list-style-type: none"> - 3.8.2. Ухаалаг газрын кадастрын ногдсан системийг байгуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна; - 3.8.4. Цахим улт ажлыглагастай газрын биржийг газрын асуудал эрхцэсан төрийн захирагыны байгуулалтын эрхийг асуудлын хурзудыг байгуулж, газар, ул хадлах хариге түүхийн ногдсан системийг бий болгоно. - 3.8.12. 3D, 4D газрын кадастрын ногдсан системийг бий болгох хөгжлийн; - 3.8.14. Дэвшилтэд технологид сурчилсан түрөн газар, ул хадлах харигеийн системийг хөгжлийн; - 3.8.18. Олон улсад хулах зөвлөхөрөгжсөн стандартуудыг нутгийн тогтолцогийн хөгжлийн тогтолцогийн хөгжлийн хангахад чиглэсэн үр дүнтэй газрын удирдлага, мөнөжүүлийн хөгжлийн инновацийн түншлэлийн бий болгоно.
2.	Ажлын нэр: Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	<p>Монгол Улсын онцлогтой токирон, олон улсын жижигт нийцсан газар, ул хадлах ад харигеийн ногдсан түрөн болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын бүртгэлийн системийн байгуулалт ажлын зорилт засгийн үндэслэл боловсруулах ба дараах асуудалтуудыг шийдвэрлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Газар болон газар дээрх ул хадлах ад хөвөнгийн гурав

<p>“УЛСЫН ХЭМЖЭЭНД ГУРАВ БОЛОН ДӨРВЕН /3D, 4D/ ХЭМЖЭЭСТ КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЛЭЭНД ИЗВЕРТҮҮЛЭХ АЖЛЫН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ” ЗӨВЛӨХ БАГ</p> <p>2022 оны 01 сарын 01-ны өдөр</p> <p>Дугаар № 2021/96</p> <p>Улаанбаатар хот</p>	
<p>Нэг талаас Барилга, хот байгуулалтын яам (цаашид “захиалагч” гэх), ногое талаас Б.Галмандах ажлыглагас шаардах баг (цаашид “зөвлөх” гэх) харилсан тохиролцоо 2022 оны 01 сарын 01-ний өдөр энхүү ГЭРЭЭГ (цаашид “төөөв” гэх) байгуулав.</p> <ol style="list-style-type: none"> 1. Зөвлөх нь энхүү гарэ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон “Ажлын даалгавар”-т зассан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй. 2. Зөвлөх нь захиалагччай шаардах бий мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон төхөнийн эх усасартай биеед гэрээнд зассан нахцид, болзуйн дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсэн болно. 3. Захиалагч нь “Улсын хэмжээнд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн ногдсан системийн байгуулах, хэргээлэнд извртүүлэх ажлын техникин, эдийн засгийн үндэслэл боловсруулах” зөвлөх хүчинийг (цаашид “ажлы” гэх) 394,667,427.0 /Гурван зуун өрөн дөрөн сая зууван зуун жаран долоон мянган дөрөн зуун хорин долоо/ төгрөгөөр (цаашид “гарзиний үнс” гэх) Зөвлөхийн гарзиний нийтийн хүлээн зөвшөөрсөн болно. 4. Нийт гарзиний дун: 394,667,427.0 /Гурван зуун өрөн сая зууван зуун жаран долоон мянган дөрөн зуун хорин долоо/ төгрөг. Үүнээс 2022 онд санхүүжилд дун: 328,200,000 /Гурван зуун хорин наймдсан сая хобр зуун мянга/ төгрөг. 5. Дор дурдсан бичиг баримт нь гарзиний хэсэг болно (цаашид “гарзиний баримт бичиг” гэх). Үүнд: <ul style="list-style-type: none"> - Гэрзиний өрөхийг нахцид; - Гэрзиний тусгай нахцид; - Хавсралт; - Хавсралт №1 Ажлын даалгавар; - Хавсралт №2 Тайлтан ирүүлэх болон санхүүжилтийн хувьарь; - Хавсралт №3 Ажлын төвлөвлөгөө - Хавсралт №4 Ажлынхан Голлоч мэргэжилтийн ажлын хувьарь. 6. Гэрээ нь энд дурдсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба үрдэх энхүү үйлчилсэн бүх хэлцэлийг орлоно. 	


Зураг 1.1.3.10. Батлагдсан ажлын даалгавар болон байгуулсан гэрээ



Зураг 1.1.3.11. 3D болон 4D хэмжээст кадастр

Төрийн нэгдсэн систем /Emongolia.mn/-ээс гарах лавлагаа, мэдээлэл

Газар эзэмших гэрээний лавлагаа, газар эзэмших гэрчилгээний лавлагаа, газар ашиглах эрхийн лавлагаа, газрын үнэлгээний лавлагаа, газрын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа зэрэг 5 төрлийн лавлагааг E-mongolia системд нэвтрүүлж, 2022 оны 03 сарын 31-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтэрсэн.



Зураг 1.1.3.12. Emongolia системд нэвтрүүлсэн үйлчилгээ

Төрийн байгууллагуудтай хамтарсан дундын мэдээллийн сан байгуулах

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь бусад холбогдох төрийн байгууллагуудтай дундын мэдээллийн сан байгуулж төрийн үйлчилгээг түргэн, шуурхай болгох, байгууллага хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн бодлого зохицуулалтын газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголын үнэлгээчдийн институт зэрэг байгууллагуудтай дундын мэдээллийн санг тус тус байгуулж хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.



Зураг 1.1.3.13. АТГ болон ТӨМБЗГ-ЫН УДИРДЛАГУУДТАЙ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дундын мэдээллийн санг байгуулснаар төрийн байгууллага хоорондын мэдээлэл түргэн шуурхай солилцож, иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөл боломж бүрдэж байна.



Зураг 1.1.3.14. Дундын мэдээллийн сангийн үйл ажиллагаа

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн талаар 2022 онд 21 аймаг, нийслэл, 330 сум, 9 дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдад 4 удаагийн танхимын сургалт, 6 удаагийн цахим сургалтыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 210 гаруй албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж, ажилласан байна.



Зураг 1.1.3.15. Танхимаар болон цахимаар зохион байгуулсан сургалтын явц

Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн талаар дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- 21 аймгийн ГХБХБГ-ын кадастрын мэргэжилтнүүдийг хамруулан Газрын нэгдмэл сангийн цахим систем, Төрийн өмчийн газрын мэдээллийн сан, Хаягжуулалтын мэдээллийн системийн талаар танилцуулга хийх, тэдгээрийг хөтлөх, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дадлагажуулах сургалтыг “Софт мастер”, “Смарт data” ХХК-иудтай хамтран 2022 оны 3 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сургалтанд нийт 21 мэргэжилтэн хамрагдсан.
- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран Газрын биржийн цахим системийн сургалтыг Баянзүрх, Сонгинохайран, Налайх дүүргийн нийт мэргэжилтэн, албан хаагчдад 2022 оны 04 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтанд нийт 36 албан хаагчид хамрагдсан.
- БОАЖЯ-ны тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын 19 албан хаагчдыг хамруулан 2022 оны 08 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд Газрын кадастрын мэдээллийн сангийн системийн сургалтыг зохион байгуулсан. Мөн Говь-Алтай аймгийн 7 сумын даамал, Увс аймгийн Ховд сумын газрын даамлын албан тушаалд шинээр томилогдож байгаа мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан.
- 2022 оны 09 дүгээр сарын 20-ноос 23-ны өдөр Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд болон тус аймгийн 19 сумын Газрын даамлуудыг хамруулсан ‘ЦАХИМ ШИЛЖИЛТ’ сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургалтаар Газрын удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, Газрын кадастрын системээр цахим хүсэлтийг шийдвэрлэх,


нөхөн бүрдүүлэлт ажлыг хийх, Газрын төлбөр, татварын системээр газрын төлбөр, татвар ногдуулалт, нэхэмжлэл үүсгэх, Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах, газар үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх, Газрын нэгдмэл сангийн системээс газрын нэгдмэл сангийн тайлан гаргах, илгээх болон засварлах талаарх сургалтыг зохион байгуулсан. Мөн тус аймгийн хэмжээнд газрын кадастрын чиглэлээр хийж буй ажлын үр дүн, анхаарах асуудлуудыг танилцуулж, тулгамдаж буй асуудлуудын талаар хэлэлцүүлэг хийж санал зөвлөмж солилцсон.

- 2022 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд 21 аймгийн ГХБХБГ-ын үнэлгээ, төлбөр татвар хариуцсан 21 мэргэжилтнүүдэд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр нийслэл дүүргийн газрын үнэлгээ, төлбөр татварын 25 мэргэжилтэнд газрын төлбөр, татварын системийн нэмэлт хөгжүүлэлт болон тулгамдаж буй асуудлын талаар сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Газрын нэгдмэл сангийн цахим систем

“Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн Газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах” ажлын хүрээнд Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллуудын хил зааг, хэмжээ, байршлыг шинэчлэн тогтоож, зураглан Газрын нэгдмэл сангийн цахим системийг байгуулаад байна.

Уг цахим систем байгуулагдсанаар салбар хоорондын уялдааг хангах, газрын нэгдмэл сангийн тайланг тайлагнах, газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал өөрчлөх үйл ажиллагаа бүрэн цахим хэлбэрт шилжиж, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээллээр хангах боломжтой болсон.



Зураг 1.1.3.16. Газрын нэгдмэл сангийн цахим систем

21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын кадастрын мэргэжилтнүүдийг хамруулан Газрын нэгдмэл сангийн цахим систем, Төрийн өмчийн газрын

Мэдээллийн сан тэдгээрийг хөтлөх, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөөр хангах, дадлагажуулах сургалтыг “Софт мастер”, “Смарт дата” ХХК-иудтай хамтран зохион байгууллаа.

Мөн Газрын нэгдмэл сангийн цахим системийн үйл ажиллагааны талаар Газрын шинэтгэлийн хорооны 2022 оны 3 дугаар сарын хуралдаанд танилцуулсан.

Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам”, мөн 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан газрын нэгдмэл сангийн тайлангийн маягтуудыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлагдахаар дэмжигдсэн. Дээр дурдсан тайлангийн маягтуудыг нийцүүлэн Газрын нэгдмэл сангийн цахим системээс тайлан гаргах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Газрын үнэлгээний цахим систем


Газрын үнэлгээний цахим системийг 21 аймаг 330 сум, нийслэл, дүүргийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 онд өссөн дүнгээр инженерийн болон хүрээлэн буй орчны, нийгмийн дэд бүтцийн 10183 үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн мэдээллийг оруулж, нийт 1100476 нэгж талбарт үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн утга бодуулан дүн шинжилгээ хийж, масс үнэлгээ хийсэн.

Газрын үнэлгээний мэдээллийн системд дараах үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн мэдээллийг шинэчлэн сервис үйлчилгээгээр авдаг болсон. Үүнд:

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцээс
 - Бөхир усны шугам
 - Цэвэр усны шугам
 - Дулааны шугам
 - Авто зам
2. Кадастрын мэдээллийн сангаас
 - Эмнэлэг
 - Сургууль
 - Цэцэрлэг
 - Төрийн үйлчилгээний байгууллага
 - Худалдааны төв
 - Ахуйн үйлчилгээний төв

Газрын үнэлгээний мэдээллийн системд дараах үнэд нөлөөлөх хүчин зүйлсийн мэдээллийг шинээр сервис үйлчилгээгээр авдаг болсон. Үүнд:

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцээс
 - Цахилгааны шугам
 - Нийтийн тээврийн буудал
 - Худаг



Зураг 1.1.3.17. Үнэлгээний системд бүртгэсэн нийгмийн дэд бүтцийн мэдээлэл

Газрын үнэлгээний цахим системийг ашиглан улсын хэмжээнд хот, тосгон, бусад суурин газрын нийт 29362 нэгж талбарын газрын зах зээлийн үнийн мэдээг боловсруулан, үр дүнг ашиглан 880504 нэгж талбарт масс үнэлгээ бодуулж, газрын үнэлгээний бүсчлэл болон 1 га газрын суурь үнийг боловсруулсан. Ойн сан бүхий газрын эдийн засгийн үнэлгээ хийх аргачлал боловсруулан газрын үнэлгээний системд оруулж 4 тойрог /муж/ 31 төрлөөр үнэлж ойн сангийн газрын эдийн засгийн үнийг тооцоолон гаргасан. Усны сан бүхий газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулан газрын үнэлгээний системд оруулсан бөгөөд 29 тойроор усны сан бүхий газрын эдийн засгийн үнэлгээг боловсруулсан. Харин Хөдөө аж ахуйн газрын тариалангийн газрын үнэлгээг боловсруулах 482 нэгж талбарын чанарын оноог тооцож 1179 нэгж талбарыг масс үнэлгээгээр үнэлж тариалангийн газрыг 5 тойроор газрын эдийн засгийн үнэлгээг тооцсон.

Хүснэгт 1.1.3.4. Үнэлгээний системийн мэдээлэл /аймаг, нийслэл/

No.	Аймаг, Нийслэл	Зах зээлийн үнийн мэдээ	Нэгж талбарын үнийн мэдээ	Хот суурин газрын масс үнэлгээ	Нийгмийн дэд бүтцийн тоо
1	Улаанбаатар	11825	12834	291433	1981
2	Дорнод	1988	1351	56550	410
3	Сүхбаатар	425	423	15347	45
4	Хэнтий	368	246	37634	90
5	Төв	2298	3854	112460	481
6	Говьсүмбэр	534	368	27057	48
7	Сэлэнгэ	186	287	60130	236
8	Дорнговь	380	1087	47641	462
9	Дархан-Уул	766	1662	39091	154
10	Өмнөговь	154	1340	48914	217
11	Дундговь	597	468	37727	220

12	Орхон	2496	1915	34747	167
13	Өвөрхангай	2348	1855	56257	548
14	Булган	196	746	22640	842
15	Баянхонгор	2153	1434	21874	1425
16	Архангай	238	357	41117	102
17	Хөвсгөл	124	149	31391	1086
18	Завхан	370	725	22881	199
19	Говь-Алтай	218	340	10936	250
20	Баян-Өлгий	1031	1553	30884	67
21	Ховд	190	275	22809	80
22	Увс	477	710	30952	1073
Нийт		29362	33979	1100472	10183

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын "Газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх" жилийн хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх зорилгоор "Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт", "Үл хөдлөх хөрөнгө зуучлалын нэгдсэн холбоо" зэрэг байгууллагатай "Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ" байгуулан гэрээний дагуу хоёр байгууллагын дундын мэдээллийн санг байгуулах шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр солилцож, газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг дундын мэдээллийн сангаар дамжуулан шууд авч газрын үнэлгээний цахим системд ашиглах бүрэн боломжтой болсон.

Газрын биржийн цахим систем

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас хамтран газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн, шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн.

Зураг 1.1.3.18. Газрын биржийн цахим систем /www.mle.mn/

Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдаа;
- Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн төсөл сонгон шалгаруулалт;
- Монгол улсын иргэн газар өмчлөх эрхээ болон иргэн, хуулийн этгээд газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэхтэй холбогдсон арилжаа;
- Монгол улсын иргэн газар өмчлөх эрхээ болон иргэн, хуулийн этгээд газар эзэмших эрхээ бусдад ашиглуулахтай холбогдсон арилжаа;
- Газрын худалдаа, түрээсийн зар мэдээлэл, зуучлалын үйл ажиллагаа;
- Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн санг эрхлэх, олон нийтэд мэдээлэх;

Уг системийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газрын алба, 330 сумын Газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тус систем нь Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтэц, Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн сан, Газрын үнэлгээний мэдээллийн сантай болон бусад байгууллагын мэдээллийн сантай холбогдон ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Иргэд, хуулийн этгээд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтад байршил харгалзахгүй оролцож, олон шат дамжлагагүй, түргэн шуурхай үйлчилгээг авах боломжтой болсон.


2022 онд улсын хэмжээнд 4225 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1585 дуудлага худалдаа хүчинтэй болж, 14911.1 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 1965-ээр, эзэмшүүлсэн газрын хэмжээ 6985.1 га талбайгаар нэмэгдэж, улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ 28 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж байх үед жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт ордог байсан бол газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг ашиглан дуудлага худалдааг цахимаар зохион байгуулдаг болсноор дуудлага худалдаанаас улсын төсөвт орох орлогын хэмжээ 10 дахин нэмэгдэж 2022 оны байдлаар дуудлага худалдааны орлого 42.9 тэр бум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Мөн дуудлага худалдаанд оролцогчийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэхээс өмнөх үетэй харьцуулбал 4 дахин нэмэгдсэн байна.


Хүснэгт 1.1.3.5. Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо, оролцогч, орлого /2016-2022/

Он	Зохион байгуулсан тоо	Үүнээс		Нийт оролцогч	Үүнээс		Нийт орлого	Үүнээс	
		Цахим	Танхим		Цахим	Танхим		Цахим	Танхим
2016	672	32	640	281	68	213	2.4	0.3	2.1

2017	583	118	465	494	204	290	4.3	2.1	2.2
2018	1,179	683	496	1,933	1,531	402	8.5	5.2	3.3
2019	1,801	1367	434	2,136	1,773	363	10.2	6.3	3.9
2020	2,282	1968	314	3,590	3,245	345	10.4	7.6	2.8
2021	2,360	2062	198	4,410	4,120	290	14.7	13.5	1.2
2022	4225	3932	293	7474	7066	408	42.9	29.8	14.1



Зураг 2.1.3.19. 2009-2022 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /сая.төг/



Зураг 3.1.3.20. Газрын биржийн цахим системийг ашиглан дуудлага худалдаа зохион байгуулсан байдал.

2022 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 84888 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд бөгөөд үүнээс тайлант онд 17440 үнийн мэдээг нэмж бүртгэсэн. Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 14475, худалдаа үйлчилгээний зориулалттай 816, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 1627, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 522 үнийн мэдээ тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд цуглуулсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээний 83 хувийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын үнийн мэдээ, 4,7 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай газрын үнийн мэдээ, 9,3 хувийг хөдөө аж ахуйн зориулалттай газрын үнийн, 3 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ эзэлж байгаа юм.

Мөн тус газраас Газрын биржийн хэвийн үйл ажиллагааг хангаж, нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, үнийн мэдээ цуглуулах зэрэг модульд нэмэлт хөгжүүлэлт хийж, бусад мэдээллийн сантай холбогдон ажиллах боломжийг бүрдүүлж үйл ажиллагааг цахимжуулж, иргэн, хуулийн этгээдэд түргэн, шуурхай үйлчилгээ үзүүлэхээр дараах ажлууд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Газрын биржийн цахим системийг "ACH" автомат клиринг хаус системтэй холбож багц гүйлгээ хийх модуль хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх;
- Газрын биржийн цахим системээс газрын эрхийг бусдад шилжүүлэх хүсэлт илгээх боломжтойгоор хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлэх;
- Газрын биржийн цахим системээс архитектор төлөвлөлтийн даалгавартай холбоотой мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх;
- Зарын болон бусад цахим хуудаснаас өгөгдөл мэдээ татах, үнийн мэдээ цуглуулах платформыг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын болон зар түгээгч байгууллагын мэдээллийн сантай холбож үйлчилгээ үзүүлэх модулийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх;
- Холбогдох бусад мэдээллийн системтэй холбож, цахим хуудас болон гар утасны апликеишнаар энгийн, хялбар байдлаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх;

Дээрх цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийг дэлхий дахинь чиг хандлага болж буй технологиудын хамгийн сүүлийн хувилбаруудыг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд ашиглахад хялбар, энгийн ойлгомжтой болгон www.mle.mn/ цахим хаяг болон гар утасны апликеишныг хөгжүүлсэн.

Мөн иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, Монгол Улсын иргэн өмчилсөн газраа бусдад худалдах, худалдан авах үйл ажиллагаанд зуучлах үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. Иргэн, хуулийн этгээд тус системд нэвтэрч Газрын кадастрын мэдээллийн сангаас өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газраа сонгон бусдад худалдах, түрээслэх зар мэдээллээ үнэ, төлбөргүйгээр байршуулж бусдад арилжаалах боломжийг бүрдүүлсэн.

Газрын биржийн цахим системд "хэрэглэгч"-ээр бүртгүүлж www.mle.mn цахим хаягаар болон гар утасны апликеишнаар аймаг, нийслэлийн Газрын албанаас зарласан газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглаулах эрхийн дуудлага худалдаанд оролцох боломжтой юм.

Мөн иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх, Монгол Улсын иргэн өмчилсөн газраа бусдад худалдах, худалдан авах үйл ажиллагаанд зуучлах, дуудлага худалдаагаар бусдад шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газраа дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийг харьяа аймаг, нийслэлийн газрын албандаа хүсэлт гаргаж дуудлага худалдааг зохион байгуулан бусдад шилжүүлэх боломжтой юм.

Тус системээс иргэн, хуулийн этгээд газартай холбоотой бүх төрлийн мэдээ, мэдээллийг авч, өөрийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар бусдад шилжүүлэх болон худалдах, түрээслэх зар мэдээллээ уг системд оруулж бусдад арилжаалах боломжтой бөгөөд 2022 онд нийт 18775 иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авсан байна.

Газрын төлбөр, татварын цахим систем

Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан газрын төлбөрийн хөнгөлөлтийг эдлэхдээ стандартын шаардлагад нийцэгүй нүхэн жорлонгүй байх нөхцөлийг хангасан байна”, 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “Тусгай хамгаалалттай газар нутаг, нийслэлийн ногоон бүсэд аж ахуйн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж барьсан бол газрын төлбөрийг хоёр дахин өсгөж тооцно.” гэж 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой, мөн төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх үүднээс Газрын төлбөр, татварын цахим системд дараах нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т заасан шаардлагыг хангасан бол газрын төлбөрт хөнгөлөлт, чөлөөлөлт тооцож ногдуулах хийх боломжийг бүрдүүлсэн;
- Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 9-д заасан шаардлагыг хангаагүй бол газрын төлбөрийг 2 дахин өсгөж ногдуулах боломжийг бүрдүүлсэн;
- Газрын удирдлагын нэгдсэн цахим систем /E-gazar/-аас газрын төлбөрийн үлдэгдэлгүй нэгж талбарын мэдээлэлд тооцоо нийлсэн акт авахад цахимаар хүсэлт илгээх, улмаар асуудал хариуцсан мэргэжилтэнд автоматаар мэдэгдэл ирж хүсэлтийг шийдвэрлэснээр <https://egazar.gov.mn/>-с иргэн, хуулийн этгээд газрын төлбөрийн тооцоо нийлсэн актаяа цахимаар авах;
- Монгол Улсын 18 нас хүрээгүй иргэний газар, үл хөдлөх хөрөнгийн татварын ногдуулалтыг итгэмжилсэн төлөөлөгчөөр дамжуулан үүсгэх;
- Газрын төлбөр, татварын системээс Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгаврын үүсгэх;

Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т заасан шаардлагыг хангасан бол тус хуулийн 8 дугаар зүйлийн 1.2-т заасан хөнгөлөлт, чөлөөлөлт тооцож ногдуулах хийх боломжийг бүрдүүлсэн.

Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 9-д заасан шаардлагыг хангаагүй бол газрын төлбөрийг 2 дахин өсгөж ногдуулах боломжийг бүрдүүлсэн.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т “Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн энэ зүйлийн 1 дахь хэсгийн 2 дахь заалтад заасан газрын төлбөрийн хөнгөлөлтийг здэхдээ стандартын шаардлагад нийцээгүй нүхэн жорлонгуйг байх нөхцлийн хангасан байна


Хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэсэгт хуулийн заалтыг оруулж өгснөөр тухайн гэрээний төлберийн шинэчлэн бодуулна. Төлбөр бодох хэсэгт алхам 2 дээр тухайн гэрээнд хөнгөлөлт, чөлөөлөлт тооцохгүй байгаа талаар мэдэгдэл харагдана.

Жарсамт		Хайлт			
		Агад	Нэр		
Шаарда кийн				Датгээд 25 Бичиг харуулна	
No	Зүйл, залгын дугаар	Нийтийн нэр	Логотип	Утасны тоо	Чадвалах
1	Гарын төхөөрөмж түүхийн 7/3	Тусгай хэмжлилтэй газр нутаг: ийнслэлийн ногоон бүсд, ал аюулжирхүүлэгтэй газр зоммын, ашиглаг байсан иргэж, күүлийн эзээд стандартын шалдралгаа хөгжлийн ариг чарийн багцуулж барсан бол гарын төхөөрөмжийн хувь дахиан ислийн тооцоо.			
No	Зүйл, залгын дугаар	Нийтийн нэр	Логотип	Утасны тоо	Чадвалах

Тусгай хамгаалалттай газар нутаг, нийслэлийн ногоон бүсэд аж ахуйн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд стандартын шаардлагыг хангагчайг ариун цэврийн байгууламж барьсан бол газрын төлбөрийг хоёр дахин есгэж тооцно

Зураг 4.1.3.21. Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт тооцох

Иргэн, хуулийн этгээд [/egazar.gov.mn/](http://egazar.gov.mn/) цахим системээс газрын төлбөрийн үлдэгдэлгүйн тооцоо нийлсэн акт авахад цахимаар хүсэлт илгээх, улмаар асуудал хариуцсан мэргэжилтэнд автоматаар мэдэгдэл ирж хүсэлтийг шийдвэрлэнээр тооцоо нийлсэн актыг цахимаар авах бүрэн боломж бүрдсэн.



Зураг 5.1.3.22. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт авах

Газрын төлбөр, татварын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийгдсэнээр газрын төлбөрийн орлого нэмэгдэж байгаа бөгөөд иргэн, хуулийн этгээд газрын төлбөрөө цахимаар төлөх боломжийг бурдүүлж холбогдох үйлчилгээг цахимаар авч түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж байна.

Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 5 тэрбум 232 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд сууринсан Газрын төлбөр, татварын системээр эрхзүйн харилцаа үүссэн бүртгэлтэй нэгж талбар

бүрт ногдуулалт хийж Татварын системд илгээсэн бөгөөд цаашид Уул уурхайн ашиглалтын лиценз бүхий газар, Улсын тусгай хамгаалалттай газарт олгогдсон газруудыг тус системд бүрэн бүртгэж баталгаажуулснаар газрын төлбөрийн орлого өсөж цаашид нэмэгдэх хандлагатай байна.

1.1.4. Орон зайн мэдээлэл, технологийн чиглэлээр.

Геопортал цахим систем



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч, хэрэглэгчдийн хамтын ажиллагааг зохицуулах, байрлалд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг төрийн байгууллагуудын хэрэглээнд нэвтрүүлж үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, төсвийн үргүй зардал, давхардсан хөрөнгө оруулалтыг арилгах зорилгоор Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн ГЕОПОРТАЛ системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.

Өгөгдлийн багтаамж




Геопортал цахим системд Орон зайн суурь өгөгдлийн 18 дэд сангийн нийт **35 ТБ** мэдээллийг бүрдүүлсэн. Үүнээс Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийг худалдаанд гаргаж эхлээд байгаа бөгөөд 351 хэрэглэгч 2,800,600Т-ний худалдан авалт хийж, улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Улсын хэмжээний байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл бүхий дэд бүтцийг бий болгон

хөгжүүлснээр иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаанд таатай нөлөө үзүүлж, боломж нөхцөлийг нэмэгдүүлэх төдийгүй төрийн бодлого, шийдвэрийг нэгдсэн байдлаар зөв зүйтэй төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон тулхэц үзүүлнэ.

Геопортал системд төвлөрүүлсэн өгөгдөл

Хэрэглэгчдэд үнэн зөв, орон зайн нарийвчлал сайтай, алдаагүй орон зайн суурь зургаар хангах, үйлчилгээ үзүүлэх бодлогын хүрээнд Улсын хэмжээнд 18 дэд сангийн 20258683 орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж Геопортал системд төвлөрүүлээд байна.



Зураг 1.1.4.1. Геопорталд төвлөрүүлсэн орон зайн өгөгдлийн тоо /дэд сангаар/

Геопортал системийн хэрэглээ

Цахим системд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гэсэн үндсэн 3 эрхийн түвшингээр хандах боломжтой бөгөөд өөрт хэрэгцээтэй мэдээллийг харах, нээлттэй мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, засаг захиргааны нэгжийн хил, нэрэлбэр, байрлал болон төрөл бүрийн ангилаар хайлт хийх боломжтой.

Тус цахим систем нь төрийн мэдээллийн ХҮР систем, танилт нэвтрэлт ДАН систем болон төлбөр тооцооны QPAY системд холбогдсон. Геопортал цахим системд өгөгдөл оруулах 4 түвшинтэй бөгөөд 1 дүгээр түвшинд сумын даамал, 32 аж ахуйн нэгжийн 362 эрх, 2 дугаар түвшинд 21 аймгийн ГХБХБГ-ийн, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны 70 эрх, 3 дугаар түвшинд 31 төрийн байгууллагын яам, агентлаг, судалгааны төвийн 100 эрх, 4 дүгээр түвшинд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 115 эрх байна.

ГЕОПОРТАЛД ХАНДАХ ЭРХ БУХИЙ БАЙГУУЛЛАГУУД:



Зураг 1.1.4.2. Геопорталд хандах эрх бүхий байгууллагууд

Одоогоор Геопортал цахим системд хандсан хандалт давхардсан тоогоор 3,241,226 хүрсэн байна.



Байр зүйн зураг 220618		Хаяг 41860		Газар зүйн нэр 95282		Барилга, суурин газар 131355	
Хүн ам зүйн мэдээлэл 18969		Газар ашиглалт 16120		Газрын бүрхэвч 30529		Ус зүйн мэдээлэл 47234	
Өндөржилт, гүн 107495		Газрын нэгж талбар 37258		Тээврийн сүлжээ 20909		Дэд бүтэц 77602	
Түүх соёл, археологийн өв 267661		Хил зааг 55417		Геодезийн цэг тэмдэгт 167		Ортозураг 167	
Хэрс 27684		Геология 55417					

Зураг 1.1.4.3. Дэд сангийн хандалтын тоо

Батлагдсан баримт бичиг

Орон зайн өгөгдлийн техникийн үзүүлэлтийн MNS 6925-1-18 багц стандартыг 2021 онд батлуулсан бөгөөд энэхүү стандартын дагуу орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлж Геопорталд цахим системд төвлөрүүлж байна.

Дээрх стандартуудын суурь болох MNS-ISO-19131:2022 – Газар зүйн мэдээлэл–Өгөгдөл техникийн үзүүлэлтүүд” стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны С/41 дугаар тушаалаар батлагдсан.

MNS ISO 19131:2022 стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг бий болгоход тавигдах шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм. Нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагага явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэхэд ашиглах үндсэн баримт бичиг юм.

Эдгээрийг Стандарт, хэмжил зүйн газрын <https://estandard.gov.mn/> цахим хуудаснаас худалдан авах боломжтой.



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ЭХЛЭЛ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ТАНИЛЦУУЛГА СТАНДАРТ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ ДХБ.ХТСТ

Стандарт
Стандарт, хэмжил зүйн газар

MNS ISO 19131 : 2022

Газар зүйн мэдээлэл - Өгөгдөл техникийн үзүүлэлтүүд

Хамрах хүрээ

Энэхүү олон улсын Стандарт нь бусад ISO 19100 олон улсын Стандартын ойлголт дээр сууринсан газар зүйн өгогдол бүтээгдхүүний мэдээлэлтэй тавих шаардлагыг тайлбарлах болно. Мен өгогдол техникийн үзүүлэлтэй тодорхойлоход тэдгээрийг ойлгож мэдэхдээ хялбар, зорилгод нийцсэн тохиол байдал үүсгэхэд туслах боломжтой.

Баталсан огноо: 2022-09-15

Мөрдөж эхлсэн огноо: 2022-09-16

Ангилал: | [35.240.70 Шинжлэх ухааны мэдээллийн Технологийг хэрэглэх](#) |

Нээлттэй өгөгдөл

Тус газар нь Геопорталд төвлөрүүлсэн дээрх өгөгдлөөс Засгийн газрын 232 дугаар тогтоолын дагуу төрийн мэдээллийн нээлттэй байдлыг хангах үүднээс орон зайн нийт 64 өгөгдлийг Geojson, wms өргөтгөлтэйгээр Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд байршуулж олон нийтэд ил болгосон.


Орон зайн өгөгдөл, мэдээллээр бусад байгууллагыг хангах

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн мэдээлэл солилцооны системд 13 сервис үйлчилгээг байршуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилж байна.

1.2. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын Сайдын "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэн батлах тухай" 2019 оны 22 дугаар тушаалаар баталсан стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасны дагуу агентлагт 10 нэгж, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад Газрын даамал гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна /Зураг 1.2.1/.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар




21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албад, сумдын газрын даамал

Зураг 1.2.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бүтэц

Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор аймаг, нийслэл дэх Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, газар, геодези, зураг зүй, барилгын чиглэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нарыг эрхэлж байсан ажил, чиг үүргийн дагуу шилжүүлж, "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар"-ын орон тооны хязгаарыг Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолоор газар, геодези, зураг зүйн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн орон тоог нэмэгдүүлэн тогтоож өгсөн.

Газрын харилцааны салбарт нийтдээ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 93, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанад 245, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 436, сумдад Газрын даамал 362, нийт 1136 албан хаагч ажиллаж байна /Зураг 1.2.2/.




Зураг 1.2.2. Улсын хэмжээнд газрын салбарт ажиллаж байгаа албан хаагчдын тоо

1.3. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ


2022 онд 21 аймгийн хэмжээнд Газрын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд давхардсан тоогоор нийт 940 удаагийн хяналт, шалгалт хийснээс Булган, Төв, Сэлэнгэ аймгууд хамгийн олон удаагийн давтамжтай буюу ихэнх сумдаа хамруулж 114-171 удаа хяналт, шалгалт явуулсан байна.

Харин Говьсүмбэр, Орхон зэрэг цөөн сүмтэй аймгууд болон Сүхбаатар, Хэнтий, Архангай аймаг хамгийн бага давтамжтай буюу 1-3 удаа хяналт, шалгалт хийсэн байна /Зураг 1.3.1./.




Зураг 1.3.1. Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо

Тайлант онд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтын тоо улсын хэмжээнд 2019 оныхтой ойролцоо үзүүлэлттэй байна /Зураг 1.3.2./.



Зураг 1.3.2. Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийсэн тоо 2019, 2020, 2021, 2022 он

2022 онд орон нутагт хийгдсэн хяналт, шалгалтаар 22194 зөрчил илэрсэн бөгөөд илэрсэн зөрчлийн тоо аймаг бүрт харилцан адилгүй байна /Зураг 1.3.3./.



Зураг 1.3.3. Газрын харилцааны хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн тоо /аймаг тус бүрээр/

2022 онд Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн 22194 зөрчлийн 20590 буюу 92.8% нь газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 1555 буюу 7% нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан, 49 буюу 0.2% нь төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.4/.




Зураг 1.3.4. Газрын харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл, түүний харьцуулалт

2022 онд Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил болон Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Харин Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй байна.

Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг дотор нь ангилж авч үзвэл 2 жил дараалан ашиглаагүй 3165 /15.4%/ , гэрээнд заасан зориулалт бусаар газар

ашигласан 168 /0.8%/, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан 2209 /10.7%/, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 15048 /73.1%/ зөрчил тус тус эзэлж байна /Зураг 1.3.5/.



Зураг 1.3.5. Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх зөрчил

Зураг 1.3.5-аас харахад 2 жил дараалан газраа ашиглаагүй зөрчил 30.9%-иар, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 81.2%-иар, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил 87.1%-иар өмнөх онтой харьцуулахад өсч, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил өмнөх оныхоос 81.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.

1.4. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА

Газрын кадастрын мэдээллийн санд нийт 277144 хүсэлт бүртгэгдсэнээс шинээр газар өмчлөх 63463, шинээр газар эзэмших хүсэлт 100753, шинээр газар ашиглах 432, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 31823, барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх хүсэлт 13114, газрын зориулалт өөрчлөлх 751, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах 8251, талбайн хэмжээ өөрчлөлх 5782, төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах 44369, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах 1225, эзэмшил газраа хэсэгчлэн шилжүүлэх 3458, газрын эрх дуусгавар болгох 239, шүүхийн шийдвэрээр эрх цуцлах ба сэргээх 491, эзэмшил газраа нэгтгэх 335, газрын байршил өөрчлөх 714, газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүртгүүлэх 234, хамтран эзэмшигч нэмэх, хасах 34 тус тус хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн байна.



Зураг 1.4.1. Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй хүсэлтийн төрөл, тэдгээрийн тоо.

Тайлант онд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 277144 хүсэлт ирүүлснээс 231489 /83.5% / хүсэлтийг шийдвэрлэж, 45655 /16.5% / хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.

Өргөдөл, хүсэлт шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны дүнтэй харьцуулахад 1.8 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт 1.4.1: Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй хүсэлтийн шийдвэрлэгдсэн байдал.

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Нийт хүсэлтийн тоо	Үүнээс	
			Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо	Шийдвэрлэгдээгүй хүсэлтийн тоо
1	Архангай	7588	6797	791
2	Баян-Өлгий	8078	7417	661
3	Баянхонгор	7075	6719	356
4	Булган	7010	6626	384
5	Говь-Алтай	2586	2243	343
6	Говьсүмбэр	1823	1828	-5
7	Дархан-Уул	7020	6329	691
8	Дорноговь	4347	3861	486

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

9	Дорнод	5398	4438	960
10	Дундговь	3503	3320	183
11	Завхан	5709	5178	531
12	Орхон	12691	11943	748
13	Өвөрхангай	7383	6997	386
14	Өмнөговь	10221	8228	1993
15	Сүхбаатар	1756	1501	255
16	Сэлэнгэ	16903	14790	2113
17	Төв	24593	22466	2127
18	Увс	5836	5250	586
19	Ховд	7599	6565	1034
20	Хөвсгөл	8752	8491	261
21	Хэнтий	8423	7320	1103
22	Улаанбаатар	112850	83182	29668
Нийт		277144	231489	45655

Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт шинээр газар эзэмших, өмчлөх хүсэлт гаргасан, бичиг баримтын зөрчилтэй, бичиг баримтын бүрдүүлэлт дутуу, хүсэлт ирүүлсэн газар бусдад олгогдсон газартай давхардсан, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурvas газарт орсон, үерийн аман дээр газар эзэмших, өмчлөх, ашиглах хүсэлт гаргасан, эзэмшиж байгаа газраа өмчлөхөөр хүсэлт гаргасан боловч Газрын кадастрын мэдээллийн санд кадастрын зураг нь бодит хашаалсан газрын хэмжээнээс зөрүүтэй зэрэг шалтгаанаас өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам” шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой өргөдөл, хүсэлтийг цахим системээс хүлээн авч бүртгэн, шийдвэрлэн ажиллаж байна.

Тайлант оны байдлаар Улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн сангаар дамжуулан нийт 33207 хүсэлт ирүүлснээс 21126 хүсэлтийг шийдвэрлэж, 7752 хүсэлтийг цуцалж, буцаасан байна. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хүсэлт гаргах, баримт материалын бүрдэл дутуу байгаагаас шалтгаалан цахим системээр ирүүлсэн хүсэлтийг буцаасан байна.

Хүснэгт 1.4.2. 21 аймгийн хэмжээнд цахимаар ирүүлсэн хүсэлтийн тоо

Д/д	Аймгийн нэр	Нийт цахим хүсэлт	Үүнээс			
			Шийдвэрлэсэн	Хянаагүй хүлээгдэж байгаа	Өргөдөл үссэн боловч шийдээгүй	Цуцалсан
1	Архангай	539	371	24	41	103
2	Баян-Өлгий	1653	1232	33	277	111

3	Баянхонгор	887	640	10	39	198
4	Булган	3632	2751	69	163	649
5	Говь-Алтай	756	656	20	44	36
6	Говьсүмбэр	599	425	3	47	124
7	Дархан-Уул	2670	1963	26	360	321
8	Дорноговь	164	147	0	4	13
9	Дорнод	1050	457	23	63	507
10	Дундговь	204	113	15	48	28
11	Завхан	194	93	37	3	61
12	Орхон	1544	844	7	326	367
13	Өвөрхангай	1024	826	8	42	148
14	Өмнөговь	714	427	42	20	225
15	Сүхбаатар	315	231	7	30	47
16	Сэлэнгэ	5505	3736	237	799	733
17	Төв	2635	1394	82	163	996
18	Увс	536	202	27	269	38
19	Ховд	394	253	38	69	34
20	Хөвсгөл	4224	3595	189	52	388
21	Хэнтий	149	60	36	33	20
Аймгийн хэмжээнд		29388	20416	933	2892	5147

Хүснэгт 1.4.3. Нийслэлийн хэмжээнд цахимаар ирүүлсэн хүсэлтийн тоо

д/д	Дүүргийн нэр	Нийт цахим хүсэлт	Үүнээс			
			Шийдвэрлэсэн	Хянаагүй хүлээгдэж байгаа	Өргөдөл үүссэн боловч шийдээгүй	Цуцалсан
1	Багануур	95	48	0	1	46
2	Багахангай	39	37	0	0	2
3	Баянгол	154	39	0	3	112
4	Баянзүрх	902	100	14	2	786
5	Налайх	127	50	55	0	22
6	Сонгинохайрхан	1190	355	97	0	738
7	Сүхбаатар	570	5	279	2	284
8	Хан-Уул	305	43	42	0	220
9	Чингэлтэй	437	33	1	8	395
Нийслэлийн хэмжээнд		3819	710	488	16	2605

Цаашид Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө зэргийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулж байх шаардлагатай юм.

1.5. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2022 оны газрын зөрчил маргааны шийдвэрлэсэн байдлыг нэгтгэн үзэхэд нийт гарсан маргаан 8420, үүний дотор газар эзэмшихтэй холбоотой 6285 /74%/, газар өмчлөхтэй холбоотой 617 /7%/, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой 1206 /14%/, газар ашиглахтай холбоотой 327 /4%/ маргаан тус тус гарсан байна.


Хүснэгт 1.5.1. Газрын зөрчил, маргааныг шийдвэрлэсэн байдал /аймаг, нийслэлээр/

№	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс				Шийдвэрлэгдээгүй			
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах
1	Архангай	11	0	1	0	9	0	0	0	2	0	1	0
2	Баянхонгор	27	28	12	2	11	18	11	2	16	10	1	0
3	Баян-Өлгий	49	10	1	9	44	9	0	6	5	1	1	3
4	Булган	251	14	4	2	227	9	1	2	24	5	3	0
5	Говь-Алтай	21	2	13	0	13	0	4	0	8	2	9	0
6	Говьсүмбэр	3	0	0	0	1	0	0	0	2	0	0	0
7	Дархан-Уул	30	6	0	0	28	6	0	0	2	0	0	0
8	Дорнод	3	26	0	0	3	20	0	0	0	6	0	0
9	Дорноговь	53	2	15	0	51	2	9	0	2	0	6	0
10	Дундговь	24	9	10	0	24	9	10	0	0	0	0	0
11	Завхан	49	7	337	0	31	5	25	0	18	2	312	0
12	Орхон	36	42	36	0	36	42	0	0	0	0	36	0
13	Өвөрхангай	1	5	4	0	1	4	4	0	0	1	0	0
14	Өмнөговь	43	14	174	0	34	13	51	0	9	1	123	0
15	Сүхбаатар	0	16	15	0	0	16	15	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	65	6	15	56	65	5	11	56	0	1	4	0
17	Төв	434	378	511	228	401	365	497	228	33	13	14	0
18	Увс	43	0	22	0	43	0	21	0	0	1	0	0
19	Ховд	40	2	0	14	35	2	0	12	5	0	0	2
20	Хөвсгөл	85	2	17	0	78	2	11	0	7	6	0	0
21	Хэнтий	62	31	4	10	51	21	4	1	11	10	0	9
22	Улаанбаатар	4947	17	7	7	4602	14	0	0	345	3	7	7
Дүн		6277	617	1198	328	5788	562	674	307	489	62	517	21

2022 онд нийт 8420 зөрчил, маргаан гарсан байх бөгөөд шийдвэрлэсэн болон шийдвэрлэгдээгүй байдлыг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Нийслэлийн хэмжээнд Захиргааны болон Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 118 хэрэг хянагдсанаас 94 хэргийг шийдвэрлэн, 24 хэрэг шийдвэрлэгдээгүй байна.
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжийн хүрээнд нийт 4860 газрын зөрчил арилгахаар төлөвлөсөн байхаас 4522 зөрчлийг арилган, 338 зөрчлийг шийдвэрлэгдээгүй байна.
- 21 аймгийн хэмжээнд Иргэний болон Захиргааны хэргийн шүүхээр нийт хянагдсан 38 хэргийн 28-ыг шийдвэрлэн, 10 хэрэг шийдвэрлэгдээгүй байна.
- Аймгуудад тухайн онд эзэмшил, өмчлөл, ашиглагч, хилийн цэстэй холбоотой асуудлаар нийт 3404 маргаан гарсан байх бөгөөд үүнээс 2663 шийдвэрлэн, 741 газрын зөрчлийг шийдвэрлэгдээгүй байна.

Аймаг, нийслэлийн газрын зөрчил маргааныг нэгтгэж үзэхэд нийт 8420 газрын зөрчил, маргаан гарсанаас 7307 шийдвэрлэн, 1113 хэргийг шийдвэрлэгдээгүй байна.



Зураг 1.5.1. Газрын зөрчил, маргааны шийдвэрлэсэн, шийдвэрлэгдээгүй байдал

Улсын хэмжээнд гарсан 2022 оны газрын зөрчил, маргааны тоог 2021 оны газрын зөрчил, маргааны тоотой харьцуулахад өмчлөх эрхтэй холбоотой үүссэн маргаан 29-өөр, газар ашиглах эрхтэй холбоотой үүссэн маргаан 243-аар тус тус буурсан, газар эзэмших эрхтэй холбоотой үүссэн маргаан 5208, хилийн цэсийн асуудлаар үүссэн маргаан 530-аар тус тус өссөн дүнтэй байна.

Газар эзэмшихтэй холбоотой газрын зөрчил, маргаан өмнөх оныхоос 5 дахин өссөн дүнтэй байгаа нь нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжийн хүрээнд Баянгол дүүрэгт 1146, Баянзүрх дүүрэгт 1112, Чингэлтэй дүүрэгт 168, Сүхбаатар дүүрэгт 551, Хан-Уул дүүрэгт 202, Сонгинохайрхан дүүрэгт 1559, Налайх дүүрэгт 131, Багануур дүүрэгт 10 тус тус обьектуудын зөрчлийг арилгахаар тухайн онд төлөвлөсөн байна.



Зураг 1.5.2. Газрын зөрчил, маргааны өмнөх онтой харьцуулсан байдал

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2022 онд Захиргааны болон Иргэний хэргийн анхан шатны шүүх, байгууллагаас нийт 66 захирамж, тогтоол ирсний дагуу тус Газрын даргын тушаалаар шинжээчийн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан шинжээчийн дүгнэлтийг холбогдох газарт хүргүүлсэн байна. Үүнд:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс – 37
- Иргэний хэргийн анхан шатны шүүхээс – 20
- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн – 9

2022 онд нийт 507 удаагийн нотлох баримтыг Иргэний болон Захиргааны хэргийн анхан шатны шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн байна.

2022 оны шинжээчийн дүгнэлт буюу нотлох баримт хүргүүлсэн байдлыг өмнөх 2021 онтой харьцуулан үзэхэд нотлох баримт гаргуулах өргөдөл, хүсэлт 60-аар, шинжээчийн дүгнэлт 24-өөр тус тус өссөн дүнтэй байна.

Дээрх тайлан, мэдээнээс дүгнэн газрын маргаан гарч буй шалтгааныг ангилж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шалтгаалсан:

Газар эзэмших гэрээний нөхцөл:

- Газар, эзэмших, ашиглах гэрээгээ дүгнүүлээгүй;
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;
- Захирамжаар олгогдсон газрын хэмжээг дур мэдэн нэмэгдүүлсэн;
- Газар дээрээ хил заагаа тэмдэгжүүлж, хашаа бариагүй;
- Гэрээний дагуу газар эзэмшиж, ашигладаггүй;

Холбогдох хууль тогтоомж болон норм дүрэм зөрчсөн:

- Нийтийн эзэмшлийн зам талбайг зөвшөөрөлгүй эзэмших, ашиглах /хашаа хайс, объект барих/
- 1 давхрын барилгын өргөтгөлийг зөвшөөрөлгүй дур мэдэн өргөтгөл хийх;
- Эрх зүйн харилцаа үүсээгүй байхад бусдын эзэмшиж, өмчилж буй газартай давхардуулан хашаа болон барилга байгууламж барих;

- Эрх зүйн харилцаа үүссэн газрынхаа хил, зааг дотор барилга байгууламжийг барьдаггүй, бусдын эзэмшлийн газарт газар доогуур авто гарааш барих;
- Инженерийн шугам сүлжээ, өндөр хүчдэл бүхий газрын хамгаалалтын зурvas газарт буух /хашаа хайс барих/;

2. Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас шалтгаалсан:

Эрх бүхий албан тушаалтны буруугаас:

- Эзэмшиж, өмчилж буй газар дээр давхардуулан газар олголт хийх;
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олголт хийх;
- Нэгж талбарыг дур мэдэн устгаж, эзэмшигчийн мэдээллийг солих;
- Газар олголтыг хийхдээ хээрийн судалгааг хийхгүй байх;
- Газар эзэмших өмчлөх эрхийг шилжүүлэхдээ санаатай болон санамсаргүйгээр нэгж талбарын мэдээллийг судлахгүйгээр эрхийг шилжүүлэн маргаан гаргах;

1.6. ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ БОЛОН ӨМЧИЙН ГАЗРАА БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД БАРЬЦААЛСАН БАЙДЛЫН ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1. дэх хэсэгт “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага улсын бүртгэлд бүртгүүлдэг.


Мөн “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.8-д эрхийн гэрчилгээ барьцаалах болон эзэмшил газраа бусдад ашиглуулах хүсэлтийг тухайн шатны Засаг дарга зөвшөөрсөн тохиолдолд энэ тухай албан бичгийг үндэслэн Газрын кадастрын мэдээллийн сантай бол мэдээллийн санд, байхгүй бол энэ журмын 5 дугаар хавсралт “Газар ашиглуулсан, барьцаалсан тухай бүртгэл”-д бүртгэж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ гэж заасны дагуу Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээр барьцааны бүртгэлийг хийж байгаа бөгөөд 21 аймгийн Газрын-харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, сумын газрын даамал газар ашиглуулсан, барьцаалсан бүртгэлийг бүртгэж, жилийн эцсээр нэгтгэн тайлан гаргаж байна.

Тухайн бүртгэлээс харахад 2022 онд Улсын хэмжээнд 11564 газар эзэмших эрхийг банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан судалгаагаар 30780 Монгол Улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байх ба нийт 42344 нэгж талбар /газар эзэмших эрх, өмчийн газар/ буюу Монгол Улсын нийт нэгж талбарын 3.6 хувийг банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд барьцаалсан нь бүртгэгдсэн байна.

2022 онд газар эзэмших эрх болон өмчийн газраа барьцаалсан байдлыг Улсын хэмжээнд нэгтгэж хүснэгт 1.6.1, зураг 1.6.1-д үзүүлэв.


Хүснэгт 1.6.1. Газар эзэмших эрх болон өмчийн газраа шинээр барьцаалсан байдал

№	Аймаг, нийслэл	Барьцаалсан нэгж талбарын тоо	Үүнээс	
			Эзэмших	Өмчлөх
1	Архангай	696	209	487
2	Баян-Өлгий	1304	387	917
3	Баянхонгор	1368	193	1175
4	Булган	631	361	270
5	Говь-Алтай	671	198	473
6	Говьсүмбэр	394	55	339
7	Дархан-Уул	1631	348	1283
8	Дорнод	738	116	622
9	Дорноговь	722	356	366
10	Дундговь	351	57	294
11	Завхан	522	140	382
12	Орхон	2169	290	1879
13	Өвөрхангай	2161	338	1823
14	Өмнөговь	1266	112	1154
15	Увс	1576	589	987
16	Сүхбаатар	607	93	514
17	Сэлэнгэ	3632	2009	1623
18	Төв	2052	685	1367
19	Ховд	1589	629	960
20	Хөвсгөл	2122	709	1413
21	Хэнтий	1114	206	908
22	Нийслэл	15028	3484	11544
ДҮН		42344	11564	30780




Зураг 1.6.1. Газар эзэмших эрхийн барьцаа бүртгүүлсэн байдал

Тайлант онд бүртгүүлсэн газар эзэмших эрхээ болон өмчийн газраа барьцаалсан байдлаас харахад нийт барьцаанд байгаа газрын 41 хувь нь гэр бүлийн хэрэгцээний газар, 33 хувь нь хөдөө аж ахуйн зориулалттай газрууд тус тус эзэлж байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалтаар эзэмшиж буй газрын банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсныг зураг 1.6.2-д үзүүлэв.



Зураг 1.6.2. Банк, санхүүгийн байгууллагуудад барьцаалсан газрын зориулалт ба төрөл

Мөн 2022 онд газар эзэмших эрхээ барьцаалсан байдлаас харахад 58.2 хувийг банкинд, үлдсэн 41.8 хувийг банк бус санхүүгийн байгууллага, хоршоо болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад барьцаалсан байна. Үүнээс хамгийн их хувь буюу 69.8 хувийг Хаан банкинд, 12.7 хувийг Төрийн банкинд, 7.4 хувийг Хас банкинд, 4.1 хувийг Худалдаа хөгжлийн банк, Голомт банкинд, 6 хувийг бусад банкинд барьцаалсан байна /Зураг 1.6.3/.



Зураг 1.6.3. Газар эзэмших эрхийг банканд барьцаалсан байдал.

Газар эзэмших эрх болон өмчийн газрыг банк, санхүүгийн байгууллагад дунджаар 2.8 жилийн хугацаатайгаар барьцаалсан байна.

1.7. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газрын үнэд байршил, зориулалт, орчин нөхцөл, инженерийн шугам сүлжээ, бичиг баримтын бүрэн эсэх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлөхөөс гадна барилга барих тусгай зөвшөөрөл буюу техникийн нөхцөл, газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, төрийн засгийн бодлого шийдвэрээс ихээхэн хамаардаг.

Мөн үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь инфляцын эсрэг сайн хамгаалалт болдог тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонирхдог бөгөөд газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлуудыг судлан зах зээлийн бүтэц, оролцогч талуудын оролцоо, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалж дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах зорилгоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус системийг ашиглан нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын алба, сумдын газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж газрын зах зээлийн үнийн мэдээг цуглуулж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Газрын биржийн цахим системд нийт 84888 газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээ бүртгэгдээд байгаа бөгөөд үүнээс тайлант онд 17440 үнийн мэдээг нэмж бүртгэсэн.


Бүртгэгдсэн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 14475, худалдаа үйлчилгээний зориулалттай 816, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай 1627, хөдөө аж ахуйн газраас бусад үйлдвэрлэлийн зориулалттай 522 үнийн мэдээ тус тус эзэлж байна.

Нийт цуглуулсан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний дундаж үнийг тодорхойлохдоо гэр бүлийн хэрэгцээ, худалдаа үйлчилгээний газрыг үл хөдлөх хөрөнгөтэй, үл хөдлөх хөрөнгөгүй ангилж тооцож гаргасан бөгөөд үл хөдлөх хөрөнгөгүй газрыг нийт худалсан, худалдахаар санал болгосон нийт үнийн дүнгээс тооцож 1м.кв газрын дундаж үнийг тооцов. Харин үл хөдлөх хөрөнгөтэй газрын үнээс барилгын үнийг хасаж тооцвол 1м.кв газарт ноогдох үнэ харилцан адилгүй бөгөөд үл хөдлөх хөрөнгөгүй газрын дундаж үнээс бага гарч байгаа тул нийт худалсан, худалдахаар санал болгосон нийт үнийн дүнгээс тооцож 1м.кв газрын дундаж үнийг гаргасан бөгөөд барилгын үнийг хамтад нь тооцсон.

Хүснэгт 1.7.1. Газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулсан байдал

№	Аймаг/ нийслэл	Нийт үнийн мэдээ	Гэр бүлийн хэрэгжээний газар	Үүнээс								Үйлдвэрийн газар
				Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй	Худалдаа үйлчилгээний газар	Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй	Хөдөө аж ахуйн газар	Үл хөдлөх хөрөнгөгүй	Хөдөө аж ахуйн газар	
1	Нийслэл	5,749	4,841	29	4,812	245	5	243	208	450		
2	Архангай	251	154	31	123	42	18	24	51	4		
3	Баян-Өлгий	581	495	18	477	24	5	19	62	0		
4	Баянхонгор	771	491	47	444	47	6	41	223	10		
5	Булган	420	282	77	205	47	15	32	90	1		
6	Говь-Алтай	25	12	4	8	3	2	1	9	1		
7	Говьсүмбэр	118	98	3	95	7	0	6	12	1		
8	Дархан-Уул	875	745	58	687	55	12	43	68	7		
9	Дорнговь	291	261	67	194	23	14	9	4	3		
10	Дорнод	502	502	1	501	0	0	0	0	0		
11	Дундговь	204	170	6	164	18	12	6	13	3		
12	Завхан	548	403	152	251	40	19	21	103	2		
13	Орхон	941	935	100	835	5	0	5	1	5		
14	Өвөрхангай	1,023	924	128	796	32	1	31	60	7		
15	Өмнөговь	503	468	1	467	15	0	14	18	2		
16	Сэлэнгэ	1,022	806	59	747	40	15	24	170	6		
17	Сүхбаатар	156	149	32	117	7	6	1	0	0		
18	Төв	2,726	2175	8	2167	101	2	99	437	13		
19	Үвс	110	58	4	54	12	4	8	40	0		
20	Ховд	54	40	0	40	9	0	9	4	1		
21	Хэнтий	108	82	1	81	13	0	13	13	0		
22	Хөвсгөл	462	384	85	299	31	4	27	41	6		
Нийт дүн		17,440	14,475	911	13,564	816	140	676	1,627	522		

Тайлант хугацаанд цуглуулсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнийн мэдээний 83 хувийг гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын, 4,7 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай газрын, 9,3 хувийг хөдөө аж ахуйн зориулалттай газрын, 3 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай газрын үнийн мэдээ тус тус өзөвлөж байна.



Зураг 1.7.1. Газрын зах зээлийн үнийн мэдээний эзлэх хувь.

Мөн нийт цуглуулсан үнийн мэдээг эрхийн төрлөөр нь ангилахад 16939 өмчилсөн газрын, 419 эзэмшил газрын, 82 ашиглаж буй газрын үнийн мэдээ тус тус бүртгэгдсэн байна.


Хүснэгт 1.7.2. 1 метр квадрат газрын зах зээлийн дундаж үнэ.

Аймаг/ нийслэл	1 м.кв газрын дундаж үнэ								
	Гэр бүлийн хэрэгцээний газар	Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй	Худалдаа үйлчилгээний газар	Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй	Хөдөө аж ахуйн газар	Тэжээлийн ургамлын, Үр тарианы Төмс, хүнсний ногооны тариалангийн газар	Үйлдвэрлийн газар
Нийслэл	38,756	53,667	18,715	178,165	206,507	165,507	9,055	4,819	88,204
Архангай	11,981	25,183	9,101	31,459	42,782	19,782	2,043	1,336	33,581
Баян-Өлгий	15,449	10,000	5,439	29,262	35,771	12,305	5,533	5,007	-
Баянхонгор	11,924	27,289	10,754	48,418	66,059	31,678	3,859	1,149	32,585
Булган	9,399	19,372	6,859	70,043	52,256	19,621	1,942	529	2,143
Говь-Алтай	21,564	27,604	10,404	33,440	57,031	10,256	1,868	654	7,788
Говьсүмбэр	3,374		3,374	24,566	30,065	19,065	2,648	242	-
Дархан-Уул	10,110	29,841	9,936	58,479	88,479	28,479	1,153	307	71,788
Дорноговь	20,692	35,582	17,297	61,231	96,003	26,612	1,161	-	4,657
Дорнод	14,897	15,000	4,897	17,619	23,687	12,145	-	-	-
Дундговь	12,127	22,793	11,222	72,118	52,298	12,298	1,891	-	8,534
Завхан	23,934	28,180	11,607	56,103	88,849	23,849	1,058	1,319	4,000
Орхон	18,125	24,494	7,009	122,029	112,029	43,029	4,184	-	-

Өвөрхангай	11,947	29,697	8,364	44,335	59,516	29,865	1,728	1,558	12,571
Өмнөговь	14,371	11,429	14,377	28,749	38,541	18,749	4,156	1,500	9,375
Сүхбаатар	15,499	26,446	11,310	73,515	58,210	38,000	-	-	-
Сэлэнгэ	6,640	22,707	5,604	83,166	92,575	45,575	1,583	171	30,022
Төв	14,299	25,000	4,299	46,477	68,477	24,477	1,589	494	3,526
Увс	9,617	15,257	5,448	35,092	54,092	16,884	1,572	946	-
Ховд	12,597	-	12,597	31,730	48,314	21,730	1,387	-	-
Хэнтий	13,618	24,115	5,163	25,430	34,570	16,282	1,745	442	4,248
Хөвсгөл	17,671	28,612	7,399	76,220	59,172	33,172	1,064	344	-
Дундаж	13,845	27,463	9,144	61,711	84,286	39,551	2,561	2,132	33,573

Гэр булийн хэрэгцээний газар:

Газрын биржийн цахим системд гэр булийн хэрэгцээний газрын 17,440 үнийн мэдээ бүртгэгдсэн бөгөөд уг мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд газрын үнэ нь байршил, орон нутгийн эдийн засаг, нийгмийн байдлаас хамаарч харилцан адилгүй байна. Иймд аймаг тус бүрээр нь газрын дундаж үнийг тооцож гаргасан.



Зураг 1.7.2. Гэр бүлийн хэрэгцээний 1 метр квадрат газрын дундаж үнэ


Тайлант хугацаанд гэр бүлийн хэрэгцээний газрын дундаж үнэ нийслэл Улаанбаатар хотод хамгийн өндөр бөгөөд байршилаасаа хамаарч харилцан адилгүй байна. Нийслэл Улаанбаатар хотын гэр бүлийн хэрэгцээний 4841 газрын зах зээлийн үнийн мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хөрөнгө оруулалт хийгдээгүй 1 метр квадрат газрын дундаж үнэ 18,715 төгрөг, хөрөнгө оруулалт хийгдсэн 1 метр квадрат газрын дундаж үнэ 53,667 төгрөг байна.

Мөн аймгуудын хувьд хөрөнгө оруулалт хийгдсэн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Завхан, Говь-Алтай, Дорноговь, Орхон, Хөвсгөл, Сүхбаатар, Баян-Өлгий, Дорнод, Өмнөговь, Төв, Хэнтий, Ховд, Дундговь, Архангай, Өвөрхангай,

Баянхонгор, Дархан-Уул аймагт 10,110-23,934 төгрөг, Булган, Сэлэнгэ, Говьсүмбэр, Увс аймагт 3,374-9399 төгрөг байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 816 мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна.



Зураг 1.7.3. Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ


Худалдаа, үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ Улаанбаатар хотын хувьд 178,165 төгрөг, Орхон аймагт 122,029 төгрөг, Сэлэнгэ, Хөвсгөл, Сүхбаатар, Дундговь, Булган, Дорноговь, Дархан-Уул, Завхан, Баянхонгор, Төв, Өвөрхангай аймагт 44,335-83,166

төгрөгийн хооронд байна. Харин Увс, Говь-Алтай, Ховд, Архангай, Баян-Өлгий, Өмнөговь, Хэнтий, Говьсүмбэр, Дорнод аймагт 17,619-35,092 төгрөг байна.

Энэ нь өмнөх онтой харьцуулахад худалдаа үйлчилгээний зориулалтай газрын үнэ тайлант онд өссөн үзүүлэлттэй байна.

ХАА-н зориулалттай газар

Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн зориулалттай /Төмс, хүнсний ногоо тариалан, Жимс, жимсгэнийн усалгаагүй тариалан, Үр тарианы усалгаагүй тариалан, Өвөлжөө, хаваржааны гэх мэт/ газрын зах зээлийн үнийн 1627 мэдээг цуглуулсан байна.




Зураг 1.7.4. Хөдөө аж ахуйн 1 метр квадрат газрын газрын дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ нийслэлд 9,055 төгрөг Баян-Өлгий, Орхон, Өмнөговь, Баянхонгор, Говьсүмбэр, Архангай аймагт хамгийн өндөр буюу 2,043-5,533 төгрөг бол бусад аймагт 1,000-2,000 төгрөг байна.

Тэжээлийн ургамлын, үр тарианы төмс, хүнсний ногооны тариалангийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ 200-5000 төгрөг ба улсын хэмжээнд харьцангуй ойролцоо үнэтэй байна. Харин тайлант онд Орхон, Дундговь, Ховд, Дорноговь аймгуудад тэжээлийн ургамлын, үр тарианы төмс, хүнсний ногооны тариалангийн зориулалттай газрын зах зээлийн үнийн мэдээ бүртгэгдээгүй байна.

Үйлдвэрийн газар

Тайлант онд Улсын хэмжээнд үйлдвэрийн зориулалттай газрын зах зээлийн үнийн 522 мэдээ цуглуулсан үүнээс хамгийн өндөр буюу Улаанбаатар хотын үйлдвэрийн зориулалттай 1 метр квадрат газрын дундаж 88,204 төгрөг, Дархан-Уул аймагт 70,000 төгрөг, хамгийн бага нь Булган аймагт 2,143 төгрөг байна. Харин бусад аймгуудын хувь 3500-3300 төгрөгийн хооронд байна.




Зураг 1.7.5. Үйлдвэр үйлчилгээний зориулалттай 1 метр квадрат газрын дундаж үнэ.

2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1'195'331 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бүртгэгдсэн ба үүнээс өмчлөгч 675926, эзэмшигч 517'872, ашиглагч 1'533 байна. 39'181 нь буюу 3.2 хувь нь газрын зах зээлийн эргэлтэнд орсон байна. Энэ өмнөх оны мэдээтэй харьцуулахад 1.2 хувиар багассан дүнтэй байна.

Хүснэгт 1.7.3. Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

Он	Газар эзэмших эрхийн өөрчлөлт	Үүнээс		Газар өмчлөх эрхийн өөрчлөлт	Үүнээс		
		Газар эзэмших эрхээ шилжүүлсэн	Газар эзэмших эрхээ барьцаалсан		Газар өмчлөх эрхээ худалдсан	Газар өмчлөх эрхээ бэлгэлсэн	Газар өмчлөх эрхээ барьцаалсан
2016	19,445	10,848	8,597	42,105	7,284	3,525	31,296
2017	21,968	10,984	10,984	52,402	9,117	3,876	39,409
2018	23,585	11,964	11,621	104,954	12,036	4,007	88,911
2019	21,933	17,398	4,535	62,461	12,902	3,611	45,948
2020	21,221	16,301	4,920	49,477	13,620	3,245	32,612
2021	31,051	16,595	14,456	64,553	20,896	3,461	40,196
2022	39,181	27,598	11,583	56,232	20,944	4,508	30,780



Зураг 1.7.6. Газар өмчлөгч, эзэмшигчийн эрхийн өөрчлөлтөнд орсон байдал

2022 онд **321'154** га газар буюу ойролцоогоор нийт газар нутгийн 0.205 хувь нь эдийн засгийн эргэлтэд орсон байна. Харин газар өмчлөх, эзэмших эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 1.5 их наяд төгрөг болж буурсан судалгаа гарсан байна.

Тухайн тайлант онд Үндэсний статистикийн хорооны гаргасан мэдээгээр ДНБ 35,2 их наяд төгрөг¹ ба үүнийг газрын санхүүгийн эргэлтийн хэмжээтэй харьцуулахад ДНБ-ний **4.6%**-ийг эзэлж газрын үр өгөөж нэмэгдэж байгаа дүн гарч байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хэрэглээнд нэвтрүүлсэн Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-д нэвтэрч Газрын кадастрын мэдээллийн сангаас өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газраа сонгон бусдад худалдах, түрээслэх зар мэдээллээ үнэ, төлбөргүйгээр байршуулж бусдад арилжаалах боломжтой болсон.

¹ <https://www.1212.mn/>

1.8. ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2022 онд дараах тогтоол, журам, аргачлалуудын дагуу Улсын хэмжээнд зохион байгуулан ажиллав. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”;
- Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”.

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа

Улсын хэмжээнд 2022 онд 4225 удаа газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 1585 дуудлага худалдаа хүчинтэй болж, 14911.1 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх оныхтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан тоо 1965-ээр, эзэмшүүлсэн газрын хэмжээ 6985.1 га-гаар нэмэгдэж, Улсын төсөвт оруулсан орлогын хэмжээ 28 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.


Хүснэгт 1.8.1. 2022 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал

№	Аймаг, нийслэл	Дуудлага худалдаа зохион байгуулсан тоо		Талбай /м2/		Төсөвт орсон орлого /мян. төг/	
		2021 он	2022 он	2021 он	2022 он	2021 он	2022 он
1	Архангай	79	194	4,248,015	13,553,098	279,091.0	1,281,810.0
2	Баян-Өлгий	119	160	464,676	1,267,254	176,129.0	319,915.0
3	Баянхонгор	102	112	710,048	1,857,478	231,943.0	267,595.0
4	Булган	147	225	1,683,352	3,940,877	248,278.0	828,668.0
5	Говь-Алтай	43	83	30,687	548,162	71,852.0	171,614.0
6	Говьсүмбэр	17	31	1,568,555	762,363	1,060,822.0	570,623.0
7	Дархан-Уул	53	13	539,370	48,262	221,216.0	
8	Дорноговь	137	264	9,046,006	18,925,630	3,009,684.0	25,443,954.0
9	Дорнод	112	221	21,048,068	2,618,321	1,195,884.0	562,455.0
10	Дундговь	52	82	86,469	513,995	67,033.0	146,481.0

11	Завхан	117	500	2,763,155	49,134,754	98,976.0	501,462.0
12	Орхон	22	26	338,006	1,052,904	700,556.0	106,792.0
13	Өвөрхангай	132	127	4,008,844	11,579,659	664,321.0	308,059.0
14	Өмнөговь	65	132	845,629	6,155,270	1,284,707.0	1,853,796.0
15	Сүхбаатар	133	105	2,058,174	3,351,915	298,072.0	766,419.0
16	Сэлэнгэ	183	538	2,916,721	12,629,840	681,949.0	1,393,229.0
17	Төв	162	305	11,725,964	10,194,033	1,159,728.0	2,633,278.0
18	Увс	37	94	42,570	263,541	5,683.0	743,785.0
19	Ховд	55	345	378,823	1,688,031	189,213.0	328,112.0
20	Хөвсгөл	97	173	775,978	831,947	136,346.0	318,890.0
21	Хэнтий	196	272	12,375,327	5,309,133	947,214.0	1,680,981.0
22	Нийслэл	191	223	1,538,907	2,884,157	1,679,450.0	2,738,642.0
ДҮН		2260	4225	79,259,344	149,110,624	14,732,176.5	42,966,560.0

2022 онд нийслэл, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий, Хөвсгөл, аймгууд хамгийн олон буюу 100-аас дээш газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, бусад аймгууд 13-94-ийн хооронд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсан байна.


2021 он, 2022 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоог аймаг, нийслэлээр харьцуулан дараах зурагт үзүүлэв /Зураг 1.8.1/.



Зураг 1.8.1. 2021 он, 2022 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа явуулсан тоо

2022 онд нийт 4,225 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулснаас 2,595 удаагийн буюу 61.4 хувь нь хүчингүй болсон ба үүнээс 2018 удаагийн буюу 77.7 хувь нь оролцогчгүйн улмаас хүчингүй болж, 467 удаагийн буюу нийт зохион байгуулсан дуудлага худалдааны 11.1 хувь нь дуудлага худалдааны үнийг "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-д заасан хугацаанд төлөөгүй байна.

Мөн дуудлага худалдаанд оролцогч ирээгүй тохиолдол 51.6 хувь болж 11.8 хувиар өссөн, 1 оролцогч оролцсон тохиолдол 10.6 хувь болж 0.8 хувиар өссөн, 2 оролцогч оролцсон тохиолдол 21.3 хувь болж 3.4 хувиар буурсан, 2-оос дээш оролцогч оролцсон тохиолдол 16.5 хувь болж 7.5 хувиар буурсан байна /Зураг 1.8.2/.




Зураг 1.8.2. Дуудлага худалдааны оролцогчийн эзлэх хувь

Шинэчлэн батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-д цахим хэлбэрээр дуудлага худалдааг зохион байгуулахаар тусгагдсаны дагуу 2022 онд Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Увс, Ховд, Хөвсгөл аймгууд дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Харин бусад аймгууд дараах байдлаар цахим болон танхимиын хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулсан байна /Зураг 1.8.3/.




Зураг 1.8.3: 2022 онд цахим хэлбэрээр зохион байгуулсан дуудлага худалдаа

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар Улсын хэмжээнд 2022 онд нийт **42 тэрбум 966 сая 560 мянган** төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс Улаанбаатар хотын хэмжээнд 2 тэрбум 738 сая төгрөг буюу 6.4 хувь, Дорнговь аймгаас 59.2 хувь буюу 25 тэрбум 443 сая төгрөг, Төв аймгаас 6.1 хувь буюу 2 тэрбум 663 сая төгрөг, Сэлэнгэ аймгаас 3.2 хувь буюу 1 тэрбум 393 сая төгрөг, Архангай аймгаас 3.0 хувь буюу 1 тэрбум 281 сая төгрөг, Өмнөговь аймгаас 4.3 хувь буюу 1 тэрбум 853 сая төгрөг, Хэнтий аймгаас 3.9 хувь буюу 1 тэрбум 680 сая төгрөгийг тус тус төвлөрүүлснээр тэргүүлж байна /Зураг 1.8.4/.



Зураг 1.8.4: 2020 он, 2021 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /тэрбум төгрөг/

2021 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт **14.7** тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол уг дун 2022 онд 28.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж **42.9** тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Газрын биржийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлснээс хойш дуудлага худалдааны орлого тогтмол нэмэгдсэн бөгөөд тухайн тайлант онд дуудлага худалдааны орлого 2.9 дахин нэмэгдсэн байна /Зураг 1.8.5./.



Зураг 1.8.5. 2010-2022 онд улсын хэмжээнд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /тэрбум төг/

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг танхимаар зохион байгуулж байх үед жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт ордог байсан бол Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг 2016 оноос эхлэн хэрэглээнд нэвтрүүлж, дуудлага худалдааг цахимаар зохион байгуулдаг болсноор дуудлага худалдаанаас улсын төсөвт орох орлогын хэмжээ нэмэгдэж 2022 оны байдлаар дуудлага худалдааны орлого 42.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт


Улсын хэмжээнд 2022 онд Архангай, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд, Хэнтий аймагт 139 газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулнаас нийт зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалтаас 67 нь хүчинтэй болж, 356'440.1 га газрыг эзэмшүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулж үзвэл газар эзэмшүүлэх эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан тоо 2.3 дахин нэмэгдсэн байна. /Хүснэгт 1.8.2/.

Бусад аймаг, нийслэлд газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй.

Хүснэгт 1.8.2. 2022 оны газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын мэдээ

№	Аймаг, нийслэл	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо		Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээ /га/	
		2021 он	2022 он	2021 он	2022 он
1	Архангай	2	25	-	32.2
2	Дархан-Уул	12	-	72.78	-
3	Дорноговь	-	1	-	-
4	Дундговь	-	9	-	355'519.2
5	Завхан	5	-	31.32	-
6	Өвөрхангай	4	33	4.00	-
7	Өмнөговь	7	15	1.46	88.6
8	Төв	18	54	167.30	788.4
9	Увс	2	-	-	-
10	Ховд	-	1	-	0.5
11	Хөвсгөл	1	-	1.00	-
12	Хэнтий	2	1	20.89	11.2
13	Нийслэл	5	-	20.04	-
ДҮН		58	139	318.79	356'440.1

2022 онд 58 газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулснаас 15 удаагийн буюу 25.8 хувь нь төсөл ирээгүйн улмаас хүчингүй болжээ /Зураг 1.8.6/.




Зураг 1.8.6. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтын оролцогчийн эзлэх хувь

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлсэн хугацааны хувьд авч үзвэл ихэвчлэн 15 жилээр эзэмшүүлсэн байна.

1.9. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНД АШИГЛУУЛЖ БУЙ ГАЗРЫН ТАЙЛАН

Улсын хэмжээнд нийт Сууц өмчлөгчдийн 1216 холбоо үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 1062, орон нутагт 154 бүртгэгдсэн байна. 2009 оноос хойшхи СӨХ-ны бүртгэгдсэн байдлыг дараах зурагт харуулав /Зураг 1.9.1/.



Зураг 1.9.1. СӨХ-ны тоо

Хүснэгт 1.9.1. СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Улсын хэмжээнд/

Д/Д	Аймаг	Нийт СӨХ-ны тоо	Тооллогонд хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Аймаг, Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Захирамжаар баталгаажигдсан СӨХ-осс газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа Талбайн хэмжээ /м2/	Маргаантай болон судалж байгаа	Захирамж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ны тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ны тоо
1	Архангай	1	-	-	1	1	47,900.0	0	11	0	0
2	Баян-Өлгий	1	1	1	1		3,9610	1			
3	Булган	1	-	-	1	1	32,197.9				
4	Говь-Алтай	5	-	-	5	5	51,000.0	0	0	0	0
5	Говьсүмбэр	2	-	-	2	2	123,334.0	-	-	-	-
6	Дархан-Уул	41	39	6	33	21	577,706.0	3	1	4	37
7	Дорнод	24	24	8	8	8	239,134.0	-	-	-	-
8	Дорнговь	23	23	3	12	12	255,671.4	-	-	2	-

9	Дундговь	1		1			7,370.0				
10	Орхон	27	6	-	21	21	824,500.0	-	-	-	-
11	Өвөрхангай	4	0	0	0	4	33,415.0	-	-	-	-
12	Өмнөговь	2	2	2	2	2	14,618.7	-	-	-	-
13	Сүхбаатар	1	1	0	1	1	3,500.0	-	-	-	-
14	Сэлэнгэ	19	-	-	19	19	207,506.0	-	-	-	-
15	Хөвсгөл	3		3	2	3	58,784.5				
16	Нийслэл	1062	482	40	1062	794	1,394,771		15		
Нийт		1216	578	55	1170	894	3911019	4	27	6	37

Тайлант оны байдлаар Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 1216 СӨХ-ны 1170 нь орчны газраа ашиглах эрхээ аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж, 391.1 га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулсан байна.

1.10. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.10.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас авч нэгтгэлээ.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нийт 11 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Орхон аймгуудын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2022 онд хийгдэж дууссан, Архангай, Говь-Алтай, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Ховд аймгуудын ерөнхий төлөвлөгөө шинэчлэгдэн хийгдэж байна.

2022 онд хэрэгжсэн томоохон ажлуудаас дурьдвал салбарын хэмжээнд Газрын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн, мөн газрын удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагаа тогтвортжуулах, ундны болон ахуйн усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн хил зааг, дэглэм тогтоох, сумын төв, хөдөөгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх, цэвэрлэх байгууламж шинээр барих, ойжуулалт, ойн зурvas байгуулах зорилтын хэрэгжилт сайн байна.

Харин хөв цөөрөм байгуулах газрын судалгаа хийх, газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах, рашаан сувиллын газрыг тохижуулах, Халх голын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх, их дээд сургуулиудын хоткон байгуулах, нүүлгэн шилжүүлэх, усан цахилгаан станцуудыг байгуулах судалгааны ажлыг эхлүүлэх, усны эх орчмын газар, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, гүний усны тэжээгдлийн муж, ангийн бүс, тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн газруудтай давхцалтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газруудын давхцлыг арилгах зэрэг ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

2022 онд Дорноговь аймгийн Сайншанд суманд “Дезерт солар повер вуан” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар 30 МВт-ын хүчин чадалтай “Говь” нарны цахилгаан станц, Говьсүмбэр

аймгийн Сүмбэр суманд 15 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц, Архангай аймагт "Ашид бэхи" ХХК цагт 60 м3 зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай бетон зуурмагийн үйлдвэр, Хөвсгөл аймагт "Хүслэнт бүтээмж" ХХК, "Өсөх бетон" ХХК-иуд бетон зуурмагийн үйлдвэр, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд "Дэлхийн хүнс" ХХК өдөрт 15 тн мах боловсруулах хүчин чадал бүхий дулааны аргаар боловсруулалт хийх 4 шат дамжлагатай махны үйлдвэр, "Дээжийн өргөө" ХХК мал нядалгааны үйлдвэрийг тус тус шинээр ашиглалтад оруулсан байна.


Мөн Сүхбаатар аймаг нь "Махны үйлдвэр болон хорио цээрийн байгууламжийн цогцолбор" төслийн хүрээнд "Малын эрүүл бүс, хорио цээрийн байгууламж" баригдах газрыг Асгат сумын 3-р багийн нутагт 3114 га газрыг шийдвэрлэсэн, Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт "Талын таван өндөр" ХХК хоногт 100 бог, 60 бод төхөөрөх хүчин чадалтай мах боловсруулах, махыг чанах чиглэлийн үйлдвэр 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулан 20 хүнийг ажлын байраар хангаж, 1000 тн махыг Хятад улсад экспортолсон. Дундговь аймгийн Өндөршил сумын "Азтай маамнууд" ХХК мал төхөөрч, мах ангилах үйлдвэрийн байрыг ашиглалтад оруулж, 50 тн мах бэлтгэсэн байна.




"Монгол Улсын иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай" Засгийн газрын 121 дүгээр тогтоолын хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 121 дүгээр тогтоолоор Улсын хэмжээнд нийт **32392** иргэнд **3967.8** га газрыг өмчлүүлэхээр баталснаас **18448** иргэнд **2102.52** га газрыг өмчлүүлсэн байна. Үүнээс гэр булийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй нийт **4431** иргэнд эзэмшиж байгаа **319.52** га, **14009** иргэнд шинээр **1781.02** га, **8** иргэнд аж ахуйн зориулалтаар үнээр нь **1.98** га газрыг тус тус өмчлүүлсэн байна.

Нийслэлийн хэмжээнд нийт **3244** иргэнд эзэмшиж байгаа **179** га газрыг өмчлүүлсэн байна. Улсын хэмжээнд Засгийн газрын 121 дүгээр тогтоолын хэрэгжилт **52.9** хувьтай байна.



*Зураг 1.10.1.1. 2022 онд иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн болон
өмчлүүлсэн газрын хэрэгжилт, байршилаар*



*Зураг 1.10.1.2. 2022 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар болон
аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн газрын хэмжээ /га-аар/*

“Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай”
Засгийн газрын тогтооолын төсөл:

Монгол Улсын хэмжээнд **2022** онд нийт **29693** иргэнд **3593.20** га газрыг өмчлүүлэхээс **29679** иргэнд **3591.61** га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, **14** иргэнд **1.59** га газрыг аж ахуйн зориулалтаар тус тус өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэхээр төлөвлөсөн нийт **3591.61** га газрын 24 хувийг эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, 76 хувийг шинээр өмчлүүлэх газар тус

тус эзэлж байна.

Нийслэлийн хэмжээнд нийт **4386** иргэний эзэмшиж буй **255.23** га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.


1.10.2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилт, төлөвлөгөө боловсруулах чиглэлээр:

Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4-ын 4-т /Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Архангай, Ховд, Говь-Алтай/ нийт 8 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар тусгагдсан.

2021-2022 онд орон нутгийн төсвөөр нийслэл, Булган, Баянхонгор, Баян-Өлгий, Орхон аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэж оруулсан.

2022-2023 онд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Архангай, Говь-Алтай, Ховд буюу нийт 7 аймгийн ерөнхий төлөвлөгөө олон улсын төсөл, хөтөлбөр болон орон нутгийн санхүүжилтээр тус тус хийгдэж байна.

Цаашид Өвөрхангай, Говьсүмбэр, Дорноговь, Хөвсгөл, Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, тодотгох шаардлага тулгараад байна.



Зураг 1.10.2.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байдал

2022 оны байдлаар нийт 9 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөө нь хэрэгжиж байгаа тул хэрэгжилтийг нэгтгэж гаргаад байна.

Завхан аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 33 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд Хөдөө аж ахуйн газрын төлөвлөлтөд Бэлчээр усжуулалт, ХАА-н зориулалттай хөв цөөрөм, Бэлчээрийн газрыг сайжруулах, хамгаалах арга хэмжээ, бэлчээрийн даацад тохируулах, Эрчимжсэн мал аж ахуй, Хадлангийн газар, Хадлангийн сайжруулах, тариалангийн газрыг нэмэгдүүлэх, нөхөн сэргээлт, хамгаалах, сайжруулах арга хэмжээ, жимс, жимсгэний газрыг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурvas, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, газар ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэл, уул, уурхайн бүсийн төлөвлөлт, аялал жуулчлалын бүс, Усны сан бүхий газрын төлөвлөлтөд худаг, рашаан, гол нуур мөрний хамгаалалтын бүсийг тогтоох, Ойн сан бүхий газрын төлөвлөлтөд Шинээр ойжуулах бүс, ойн санг түймрээс хамгаалах, ойн хөнөөлт шавьж өвчинөөс, хамгаалах, ойн хөнөөлт шавьж, өвчинөөс хамгаалах, ойн ашиглалтыг сайжруулах, ойд цэвэрлэгээ хийх, ойн эзэмшлийн төлөвлөлт, ойн ашиглалтын төлөвлөлт, ойн дагалт баялгийг ашиглах, ан агнуурын төлөвлөлт, Зам шугам сүлжээний газрын төлөвлөлтөд төмөр зам тавих, хатуу хучилттай зам тавих, сайжруулсан шороон зам, шугам сүлжээний төлөвлөлт, холбооны шугам, Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлтөд улсын тусгай хамгаалалтад авах, аймгийн тусгай хамгаалалтад авах, орон нутгийн тусгай хамгаалалтад авах арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 3 зорилтот арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд Үйлдвэрийн бүсэд, Усны сан бүхий газарт, Хөдөө аж ахуйн газарт арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Дорноговь аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 7 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Бэлчээрийн газрын нөөц, нөхцлийн төлөвлөлтөд бэлчээрийн усан хангамжийн бэлчээрийг усжуулах, тариалангийн газрын ашиглалт, хамгаалалтын менежментийн төлөвлөгөөнд хүн амын төмс, ногооны хэрэгцээг хангахад төлөвлөлт, нийтийн зориулалттай орон сууцны бүс, уул уурхайн олбортос доройтсон газруудад газар сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээ, төмөр замын газрын барьсан, улсын чанартай авто зам аймгийн төвтэй холбосон, орон нутгийн авто, зам, улсын тусгай хамгаалалттай газар нийт 3 байршилд, усны сан бүхий газарт 2 арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Дундговь аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 25 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Хөдөө аж ахуйн газрын ангиллын бүсүүд түүний нөөц нөхцөлийн төлөвлөлт аймгийн хэмжээнд нийт 310 бэлчээр ашиглах хэсгийг байгуулсан, бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлэх 3366682.7 га, шинээр 110 гаргасан байна, нийт 61 худгийг засварласан, мал угаалгын 43 цэг, мал угаалгын 12 цэгийг засварласан, бэлчээр сайжруулах хамгаалах ажлын хүрээнд үлийн цагаан огтонтой тэмцэх арга хэмжээ, эрчимжсэн мал аж ахуй, функциональ бүс, үйлдвэрлэлийн бүс, хүнсний үйлдвэр 7, мал нядалгаа, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр 3, хөнгөн үйлдвэр, аялал жуулчлалын бүс, амралтын рашаан сувилал аялал жуулчлалын бааз 11 байршилд, уул уурхайн нөхөн сэргээлт 15 сум 609.6 га, Зам шугам, сүлжээний газрын төлөвлөлт 3 байршилд, уул уурхайн хөгжлийг дэмжих чиглэлээр авто замыг засварлах, шинээр гүүр барьсан, сэргээгдэх эрчим хүчний станц, холбоо мэдээлэл дамжуулах хүлээн авах станц, ойн сангийн төлөвлөлтөд

оин газрыг ойжуулах, хөв цөөрөм байгуулах 10 байршилд, булгийн эхийг хамгаалах, улсын тусгай хамгаалалтад 2 байршил, аймгийн тусгай хамгаалалтад 3 байршил, сумын тусгай хамгаалалтад 17 байршилд тус тус хэрэгжүүлсэн байна.

Төв аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 33 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Үүнд: Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан, сумдын төвийн суурьшлийн тэг гортигийг тэлэх арга хэмжээг зохион байгуулах, "Атрын III- IV аян"-ыг үргэлжлүүлэн тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, тогтвортой газар тариаланг хөгжүүлэх, тариалангийн газарт учирсан хохирлыг нөхөн сэргээх арга хэмжээ авах оин зурvas, тариалангийн атаршсан газрыг хөрс боловсруулалт, үр суулгалтын аргаар нөхөн сэргээх, Бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах, бэлчээрт учирсан хохирлыг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах, элсний нүүлтээс хамгаалах зорилгоор таримал бэлчээр бий болгох ажлыг судлаж хэрэгжүүлэх, бэлчээр усжуулалтыг гүний усны нөөцөд тулгуурлан нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах, хадлан, тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжүүлэх, цэвэр ба эрлийз үхрийн тоог нэмэгдүүлэх, тариалангийн бус нутагт цэвэр ба эрлийз үхрийн тоог нэмэгдүүлж, тариалангийн бүстэй хоршсон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, сумын төв, суурин газрын ойролцоо ногоон бус байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд газрын асуудлыг шийдвэрлэх, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд газрын асуудлыг шийдвэрлэх, Хөшгийн хөндийд хөнгөн үйлдвэрийн чөлөөт бус байгуулах, нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байдалд нийцсэн хөнгөн, хүнсний үйлдвэр байгуулах газар зохион байгуулалт хийх, Улсын болон орон нутгийн чанартай замын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах, Улсын болон орон нутгийн чанартай замын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах, Улсын болон орон нутгийн чанартай замын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах, ХАА-н хөгжлийг дэмжих чиглэлээр баригдах шаардлагатай авто замын трассыг тогтоон, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах, сумын төвийн автозам, дэд бүтцийг шинэчлэн сайжруулж, шинээр гудамж, зам талбай бий болгох, Улсын чанартай авто зам дагуу зорчигч, тээвэрчдийг ая тухтай байдлыг хангах авто тээврийн үйлчилгээний цогцолбор байгуулах, цахилгааны бие даасан эх үүсвэрүүдийг бий болгох цахилгаан станц байгуулах, шинээр бий болж буй суурьшуудад цахилгааны эх үүсвэр, өргөтгөл, шугам сүлжээг үе шаттайгаар байгуулах, сумын төвийн дэд бүтцийн шугам сүлжээг мэдээллийн санд бүрэн оруулах, шинээр хийгдэх цэвэрлэх байгууламжийн газрын асуудлыг шийдвэрлэх, сумын төвийн суурьшлын бусийн үерт өртөж болзошгүй газруудад хамгаалах арга хэмжээ авах, уул уурхайн ашиглалтын лицензийн талбайг мэдээллийн санд бүртгэх болон бусад үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх, аялал жуулчлал, амралт, рашаан сувилалын газруудыг шинээр байгуулах, ойжуулах, ойг хамгаалах, шинээр хөв цөөрөм байгуулах, Монгол орны экологийн бус нутгийн үнэлгээгээр сонгогдсон газруудыг аймаг, орон нутгийн хамгаалалтад авах арга хэмжээг зохион байгуулах ажлуудыг тус тус хэрэгжүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 9 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Үүнд: Доройтсон бэлчээрийн газарт авах арга хэмжээ, тариалангийн газрын ашиглалт хамгаалалтын төлөвлөгөө: хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах арга хэмжээ, хөрсийг

усны элэгдэл эвдрэлээс хамгаалах, тариалангийн талбайд тархсан хог ургамал, хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх, цэвэрлэх байгууламж, байгалийн аясаар болон зориудаар ойжуулж нөхөн сэргээх талбайн хэмжээ болон өөрийн хөрөнгөөр хийх ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ, цөлжилт, бэлчээрийн доройтолд ихээр өртөж буй сумдыг "Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр"-т хамруулна, үерээс хамгаалах далан, ү, ахуйн хэрэглээнд ус ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ, усны сан бүхий газрын талхагдал доройтлыг бууруулах, аймгийн хэмжээнд зохион байгуулж буй аялал жуулчлалын арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

Увс аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 6 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Үүнд: Аймгийн хэмжээнд гэр хорооллын газрыг 81.05 га-аар, барилгажсан хэсгийн талбайг 104.43 га, шинээр нэмэгдүүлэх 105.43га барилгажсан талбайн 17.046 га-г нь дуудлага худалдаа, аялал жуулчлалын бааз-амралтын газрын хосолмол хэлбэрээс гадна спорт, ан агнуурын болон жуулчлалын замналуудын зангилаа газруудад жуулчдыг тав тухтай амраах жуулчлалын бааз газрууд байгуулах, аймгийн хэмжээнд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, бэлчээрийн менежментийн бүсүүд, тэдгээрийн нөөц нөхцлийн төлөвлөлт, усны сангийн газрыг хамгаалах сайжруулах арга хэмжээ, ойн сангийн газрыг ашиглах, хамгаалах арга хэмжээ, аймгийн хэмжээнд байгалийн унаган төрх, тэнцвэрт байдлыг хадгалан, хамгаалах, арга хэмжээг аймгийн хэмжээнд байгалийн унаган төрх, тэнцвэрт байдлыг хадлалах, хамгаалах, арга хэмжээ төлөвлөн орон нутгийн тусгай хэрэгцээнд авах арга хэмжээг газар нутгийн сүлжээнд тус тус хэрэгжүүлсэн байна.

Өмнөговь аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 46 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Үүнд: Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө доройтсон бэлчээрийн газарт авах арга хэмжээ /245,2 мянган га бэлчээрийг малын хөлөөс чөлөөлөх, бэлчээр усжуулах, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн газрын ашиглалт хамгаалалтын төлөвлөгөөнд хөрсийг салхины элэгдэл эвдрэлээс хамгаалах, хөрсийг усны элэгдэл эвдрэлээс хамгаалах, тариалангийн талбайд тархсан хог ургамал, хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх, хүлэмжийн аж ахуй эрхлэх, хүн амын суурьшлын бүс нутгийн төлөвлөлтөд хүн амын суурьшлын бүс нутгийн төлөвлөлт, амралт зугаалгын бүс, цэвэрлэх байгууламж, суурьшлын буюу орон сууц, олон нийтийн бүс, үйлдвэрийн бүс, гудамж зам тээвэр, дэд бүтэцийн бүс, хогийн цэг, газар нөхөн сэргээх, өмчлүүлэх газар, онгоцны буудал, үерээс хамгаалах, далан, зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт 10 байршилд, төмөр замын газрын төлөвлөгөө 2 байршилд, шугам сүлжээний газрын төлөвлөлт, ойн сан бүхий газрын төлөвлөлт, усны сан бүхий газрын төлөвлөлт, аялал жуулчлал, амралт, зугаалгын бүс нутгийн төлөвлөлт 3 байршилд, тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжлийн төлөвлөлтөд цахилгаан станц барих, зэсийн баяжуулах үйлдвэр, бичил уурхайн газрыг тус тус хэрэгжүүлсэн байна.

Говьсүмбэр аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийт 6 зорилтот арга хэмжээг дараах байдлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Үүнд Тариалангийн зориулалтаар газар олгох асуудлыг зохион байгуулах, орон нутгийн малчид өөрсдийн хэрэгцээнд хадлан авах, сумдын малчдын бэлчээрийг чөлөөлөх, амраах ажлыг зохион байгуулна, аймаг, сумын төвд байгаа малыг эрчимжсэн мал аж ахуйн бүсэд нүүлгэх ажлыг зохион байгуулна, малчдад өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна, хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрийн бүсийн, амралт,

рашаан сувилал, аялал жуулчлалын газар, Баянтал, Шивээговь сумдын замыг төлөвлөх, мал тууврын замыг баталгаажуулах, эрчим хүчний шугамын зориулалтаар, гадаргын усыг хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулсан, булаг, шандын орчныг цэвэрлэж, тохижуулсан, орон нутгийн хамгаалалтанд газар авч, түүнийг газрыг нэгдсэн бүртгэлд оруулсан, сумдын төв суурин газар, бэлчээрийг хамгаалах ажлыг тус тус хэрэгжүүлсэн байна.

1.10.3. Газар зохион байгуулалтын 2022 оны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, 2023 оны төлөвлөгөө

Улсын хэмжээнд нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын нэгдмэл сангийн ангиллын газарт нийтдээ 99353 байршилд 4965.05 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 48424 байршилд 4258.89 мянган га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглаулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системээс 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэн үзэхэд Говьсүмбэр аймаг 90.82 хувь, Хэntий аймаг 80.19 хувь, Булган аймаг 71.08 хувь, Хөвсгөл аймаг 69.76 хувь, Дорноговь аймаг 69.31 хувь, Завхан аймаг 68.66 хувь, Дархан-Уул аймаг 67.2 хувь, Дундговь аймаг 67.07 хувь, Сэлэнгэ аймаг 66.84 хувь, Говь-Алтай аймаг 65.65 хувь, Увс аймаг 58.03 хувь, Орхон аймаг 52.41 хувьтайгаар төлөвлөсөн арга хэмжээгээ хэрэгжүүлсэн байна.

Харин Өмнөговь аймаг 18.13 хувь, Дорнод аймаг 26.23 хувь, Баян-Өлгий аймаг 28.09 хувь, Сүхбаатар аймаг 33.83, Архангай аймаг 37.67 хувь, Төв аймаг 42.85 хувь, Баянхонгор аймаг 44.22 хувь, Өвөрханай аймаг 44.44 хувь, Ховд аймаг 46.24 хувь, нийслэлийн хэмжээнд 48.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1.10.3.1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

Д/д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нэгж талбарын тоо	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	2870	2158.49	1081	1609.99	37.67
2	064: Баянхонгор	1798	2304988.69	795	2282085.58	44.22
3	083: Баян-Өлгий	4845	98032.15	1361	834.77	28.09
4	063: Булган	2669	65186.71	1897	64650.91	71.08
5	082: Говь-Алтай	1185	47,402.76	778	47,152.14	65.65
6	042: Говьсүмбэр	316	394.89	287	177.2	90.82
7	045: Дархан-Уул	186	744.22	125	150.03	67.20
8	044: Дорноговь	1235	16,825.11	856	12,917.61	69.31
9	021: Дорнод	4033	280,737.92	1058	14,517.14	26.23
10	048: Дундговь	2223	398,409.56	1491	396,937.17	67.07
11	081: Завхан	1972	12,664.91	1354	10,600.17	68.66
12	062: Өвөрханай	3020	232076.33	1342	169290.1	44.44
13	046: Өмнөговь	2880	437054.45	522	388178.12	18.13
14	061: Орхон	1143	209.76	599	73.5	52.41

15	022: Сүхбаатар	1667	418598.88	564	418444.3	33.83
16	043: Сэлэнгэ	3163	16,994.67	2114	12025.88	66.84
17	041: Төв	10317	296,148.23	4421	165052.42	42.85
18	085: Увс	1999	134,937.61	1160	126770.2	58.03
19	084: Ховд	2459	6052.75	1137	1574.36	46.24
20	067: Хөвсгөл	2679	80,441.28	1869	61311.47	69.76
21	023: Хэнтий	2797	102726.73	2243	82630.54	80.19
22	011: Улаанбаатар	43897	12,264.48	21370	1,906.54	48.7
Нийт		99353	4965050.6	48424	4258890.1	54.42




Зураг 1.10.3.1. Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг /төлөвлөлтийн бүс, арга хэмжээний төрлөөр/

Хүснэгт 1.10.3.2. Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт /арга хэмжээний төрлөөр/

Д/д	Арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн нэгж талбарын тоо	Хэрэгжсэн нэгж талбарын тоо	Хэрэгжилтийн хувь
1	Төсөл сонгон шалгаруулалт	211	73	34.6
2	Өргөдлийн дагуу олгох	91859	44877	48.9
3	Нөхөн сэргээх, хамгаалах	971	491	50.6
4	Нийтийн эдэлбэр газрын төлөвлөлт	2480	1215	49
5	Дуудлага худалдаагаар олгох	3277	1520	46.4
6	Газар чөлөөлөх	555	248	44.7
Нийт		99353	48424	54.4

*Хүснэгт 1.10.3.3. Сүүлийн 3 жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт
/хувиар харьцуулсан байдал/*

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	2020 он	2021 он	2022 он
1	Архангай	79.37	60.13	37.67
2	Баянхонгор	27.16	35.74	44.22
3	Баян-Өлгий	39.76	12.14	28.09
4	Булган	72.49	68.28	71.08
5	Говь-Алтай	58.22	59.16	65.65
6	Говьсүмбэр	80.49	78.38	90.82
7	Дархан-Уул	83.52	47.74	67.20
8	Дорнод	50.8	48.32	69.31
9	Дорноговь	50.29	50.04	26.23
10	Дундговь	51.52	58.46	67.07
11	Завхан	39.7	52.62	68.66
12	Орхон	42.79	49.47	44.44
13	Өвөрхангай	20.91	20.99	18.13
14	Өмнөговь	87.98	16.29	52.41
15	Сүхбаатар	32.85	30.74	33.83
16	Сэлэнгэ	13.11	28.45	66.84
17	Төв	37.15	20.54	42.85
18	Увс	48.15	42.05	58.03
19	Ховд	20.88	58.78	46.24
20	Хөвсгөл	37.82	60.79	69.76
21	Хэнтий	45.4	80.42	80.19
22	Улаанбаатар	95.4	61.53	48.7
Нийт		50.72	42.41	54.42



Зураг 1.10.3.2. Сүүлийн 3 жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт (хувиар):

Хот, тосгон, бусад суурины газар


Улсын хэмжээнд нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд хот, тосгон, бусад суурины ангиллын газарт нийт 82159 байршилд 139.01 мянган га газрыг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар нийт 39175 байршилд 107.83 мянган га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1.10.3.4. Хот, тосгон, бусад суурины газрын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт /аймаг, нийслэлээр/:


д/д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбарын тоо	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	2488	1425.55	851	1111.46	34.20
2	064: Баянхонгор	1361	2,535.71	524	2,082.38	38.50
3	083: Баян-Өлгий	1930	770.92	861	553.64	44.61
4	063: Булган	2057	2,417.37	1493	2,243.42	72.58
5	082: Говь-Алтай	635	965.68	300	772.13	47.24
6	042: Говьсүмбэр	301	393.83	278	176.57	92.36
7	045: Дархан-Уул	126	216.62	88	86.75	69.84
8	044: Дорнговь	900	16349.84	546	12512.13	60.67
9	021: Дорнод	2612	14896.95	614	4962.04	23.51
10	048: Дундговь	1806	2834.45	1174	2391.13	65.01
11	081: Завхан	932	318.76	717	261.94	76.93
12	062: Өвөрхангай	2276	2683.76	781	2252.61	34.31
13	046: Өмнөговь	2429	69176.11	337	68513.85	13.87
14	061: Орхон	1083	126.36	566	42.83	52.26
15	022: Сүхбаатар	1613	211.91	530	91.83	32.86
16	043: Сэлэнгэ	1562	2308	1069	1834.51	68.44
17	041: Төв	8878	4797.37	3670	2503.41	41.34
18	085: Увс	1056	2356.62	641	2065.56	60.70
19	084: Ховд	1587	1319.71	668	173.42	42.09
20	067: Хөвсгөл	1299	604.25	809	467.19	62.28
21	023: Хэнтий	2002	2061.76	1564	358.71	78.12
22	011: Улаанбаатар	43226	10239.16	21094	2372.85	48.8
Нийт		82159	139010.69	39175	107830.41	52.8

Дээрх хүснэгтээс үзэхэд Говьсүмбэр аймаг 92.36 хувь, Хэнтий аймаг 78.12 хувь, Завхан аймаг 76.93 хувь, Булган аймаг 72.58 хувь, Дархан-Уул аймаг 69.84 хувь, Сэлэнгэ аймаг 68.44 хувь, Дундговь аймаг 65.01 хувь, Хөвсгөл аймаг 62.28 хувь, Увс аймаг 60.7 хувь, Дорнговь аймаг 60.67 хувь, Орхон аймаг 52.26 хувиар газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөгөө хангалттай сайн биелүүлсэн байна.

Харин Өмнөговь аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тус ангиллын газар 13.87 хувьтай хэрэгжсэн байх бөгөөд гэр булийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх, гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшүүлэх газрын биелэлт хангалтгүй, Дорнод аймаг 23.51 хувьтай хэрэгжүүлсэн бөгөөд орон сууцны зориулалтаар олгох газар, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгох газар, ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булах арга хэмжээнүүд хэрэгжээгүй нь байна.



Зураг 1.10.3.3. Хот, тосгон, бусад суурины газрын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, /байршилын тоогоор/



Зураг 1.10.3.4. Хот, тосгон бусад суурины газрын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт /газрын хэмжээгээр, га-гаар/

Хөдөө аж ахуйн газар

Улсын хэмжээнд сумдын Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний хөдөө аж ахуйн ангиллын газарт нийт 15030 га байршил бүхий 2.8 сая га газрыг төлөвлөснөөс 8120 байршилд 2.2 сая га газрыг эзэмшүүлэх болон хамгаалах , нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1.10.3.5. Хөдөө аж ахуйн ангиллын газрын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал


д/д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	362	635.44	222	463.16	61.33
2	064: Баянхонгор	414	1,459,257.51	261	1,436,837.41	63.04
3	083: Баян-Өлгий	2890	97,136.96	495	279.03	17.13
4	063: Булган	428	61,558.64	284	61,394.64	66.36
5	082: Говь-Алтай	456	41,628.80	399	41,597.30	87.50
6	042: Говьсүмбэр	15	1.05	9	0.63	60.00
7	045: Дархан-Уул	41	48.11	26	26.26	63.41
8	044: Дорноговь	290	183.46	271	143.04	93.45
9	021: Дорнод	1333	261,460.33	437	9261.3	32.78
10	048: Дундговь	355	2,524.66	266	2,135.36	74.93
11	081: Завхан	991	12,269.84	613	10,305.55	61.86
12	062: Өвөрхангай	661	228904.21	510	166741.07	77.16
13	046: Өмнөговь	205	182.96	81	23.09	39.51
14	061: Орхон	57	76.42	32	25.68	56.14
15	022: Сүхбаатар	38	176.47	21	154.95	55.26
16	043: Сэлэнгэ	1309	13,843.74	867	9,929.39	66.23
17	041: Төв	1339	290,347.89	727	162,048.95	54.29
18	085: Увс	810	131,840.24	440	124,094.67	54.32
19	084: Ховд	691	4240.87	389	1158.38	56.30
20	067: Хөвсгөл	1299	79597.95	1010	60679.86	77.75
21	023: Хэнтий	734	100220.4	643	81866.26	87.60
22	011: Улаанбаатар	312	947.55	117	261.85	37.5
Нийт		15030	2787083.5	8120	2169427.83	61.08

Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөг хөдөө, аж ахуйн ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Дорноговь аймаг 93.45 хувь, Хэнтий аймаг 87.6 хувь, Говь-Алтай аймаг 87.5 хувь, Хөвсгөл аймаг 77.75 хувь, Өвөрхангай аймаг 77.16 хувь, Дундговь аймаг 74.93 хувь, Булган аймаг 66.36 хувь, Сэлэнгэ аймаг 66.23 хувь, Дархан-Уул аймаг 63.41 хувь, Баянхонгор аймаг 63.04 хувь, Завхан аймаг 61.86 хувь, Архангай аймаг 61.33 хувь, Говьсүмбэр 60 хувь, тус тус хангалттай сайн хэрэгжүүлэн ажилласан байна.

Баян-Өлгий аймаг хөдөө аж ахуйн газрын зориулалтаар нийт 2890 байршилд 97.14 га газар төлөвлөснөөс 495 байршилд 0.28 га газрыг эзэмшүүлж, ашиглуулж 17.13 хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд шинээр байгуулах өвөлжөө, өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх, жимс, жимсгэнэ тариалах газрын төлөвлөлт, усалгаатай тариалангийн газрын төлөвлөлтийг тооцоо, судалгаа дутуу хийгдсэнээс хэрэгжилт хангалтгүй гарсан байна. Иймд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа суурин болон хээрийн судалгааны ажлыг үнэн бодитойгоор хийж, төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна.


Улсын хэмжээнд хөдөө, аж ахуйн ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилт **61.08** хувьтай байна.



Зураг 1.10.3.5. Хөдөө аж ахуйн газрын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт /газрын хэмжээ, га-гаар/

Хүснэгт 1.10.3.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хөдөө,
аж ахуйн ангиллын газрын сүүлийн 3 жилийн хэрэгжилт /хувиар/

Д/Д	Аймаг, нийслэлийн нэр	2020 он	2021 он	2022 он
1	Архангай	87.64	1.59	61.33
2	Баянхонгор	44.43	45.63	63.04
3	Баян-Өлгий	49.19	15.13	17.13
4	Булган	74.16	75.10	66.36
5	Говь-Алтай	83.65	80.45	87.50
6	Говьсүмбэр	100.00	0.00	60.00
7	Дархан-Уул	92.21	73.91	63.41
8	Дорнод	69.33	51.53	93.45
9	Дорноговь	92.44	94.96	32.78
10	Дундговь	44.48	44.37	74.93
11	Завхан	68.17	33.00	61.86
12	Орхон	0.00	88.89	77.16
13	Өвөрхангай	89.49	55.91	39.51
14	Өмнөговь	69.96	53.17	56.14
15	Сүхбаатар	51.09	31.05	55.26
16	Сэлэнгэ	76.29	31.55	66.23
17	Төв	10.46	15.31	54.29
18	Увс	57.12	42.42	54.32
19	Ховд	6.18	59.40	56.30
20	Хөвсгөл	24.71	48.99	77.75
21	Хэнтий	86.99	78.89	87.60
22	Улаанбаатар	0.00	36.21	37.5
Нийт		58.09	50.28	61.08



Зураг 1.10.3.6. Хөдөө аж ахуйн газрын ангиллын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний сүүлийн 3 жилийн хэрэгжилт (хувиар)

Зам, шугам сүлжээний газар

Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд нийт 913 байршилд 122.99 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 527 байршилд 119.77 мянган га газрыг ашиглуулж, хамгаалснаар улсын хэмжээнд зам, шугам сүлжээний ангиллын газрын төлөвлөгөөний хэрэгжилт 57.12 хувтай байна.


Хүснэгт 1.10.3.7. Зам, шугам сүлжээний газрын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

д/д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	12	56.94	5	7.2	41.67
2	064: Баянхонгор	13	5.28	7	5.11	53.85
3	083: Баян-Өлгий	7	16.62	1	0.04	14.29
4	063: Булган	122	1110.71	93	953.75	76.23
5	082: Говь-Алтай	23	1465.77	19	1460.2	82.61
6	045: Дархан-Уул	5	0.72	2	0.01	40.00
7	044: Дорноговь	43	223.57	37	194.17	86.05
8	021: Дорнод	14	1319.13	4	293.72	28.57
9	048: Дундговь	45	115,004.51	39	114373.05	86.67
10	081: Завхан	6	0.25	5	0.2	83.33
11	062: Өвөрхангай	42	129.57	27	18.12	64.29
12	046: Өмнөговь	100	2278.79	58	1750.37	58.00
13	022: Сүхбаатар	8	6.8	7	4.8	87.50
14	043: Сэлэнгэ	80	400.57	31	125.1	38.75
15	041: Төв	49	700.94	15	439.23	30.61
16	085: Увс	31	55.38	18	53.64	58.06
17	084: Ховд	25	50.92	7	1.9	28.00
18	067: Хөвсгөл	58	13.32	38	12.79	65.52
19	023: Хэнтий	17	3.59	12	3.47	70.59
20	011: Улаанбаатар	213	150.88	102	70.3	47.89
Нийт		913	122994.29	527	119767.17	57.12

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зам, шугам сүлжээний ангиллын газарт Сүхбаатар аймаг 87.5 хувь, Дундговь аймаг 86.67 хувь, Дорноговь аймаг 86.05 хувь, Завхан аймаг 83.33 хувь, Говь-Алтай аймаг 82.61 хувь, Булган аймаг 76.23 хувь, Хэнтий аймаг 70.59 хувь, Хөвсгөл аймаг 65.52 хувь, Өвөрхангай аймаг 64.29 хувтайгаар хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Баян-Өлгий аймаг 14.29 хувийн хэрэгжилттэй байх бөгөөд агаарын тээврийн нисэх, буух зурvas, шинээр тавих эрчим хүчиний шугамын төлөвлөлт, Ховд аймаг 28 хувтай, сайжруулсан шороон зам, ердийн шороон зам, Агаарын тээврийн нисэх, буух зурvas, Дорнод

аймаг 28.57 хувьтай, сайжруулсан шороон зам, ердийн шороон зам, Тээвэр логистикийн төвийн төлөвлөлт, холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах станц тус тус төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.



Зураг 1.10.3.7. Зам, шугам сүлжээний зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2022 оны төлөвлөлөгөөний хэрэгжилт /газрын хэмжээ, га-гаар/

Ойн сан бүхий газар

Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд нийт 917 байршилд 11.83 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 428 байршилд 5.2 мянган га газрыг ашиглуулж, хамгаалснаар улсын хэмжээнд ойн сан бүхий газрын ангиллын төлөвлөгөөний хэрэгжилт **36.53** хувьтай байна.

*Хүснэгт 1.10.3.8. Ойн сан бүхий газрын 2022 оны газар зохион
байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал*


д/д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	3	12.27	0	0	0.00
2	064: Баянхонгор	4	29.08	0	0	0.00
3	083: Баян-Өлгий	18	107.66	4	2.05	22.22
4	063: Булган	28	47.75	4	11.64	14.29
5	082: Говь-Алтай	62	3,336.84	52	3,317.09	83.87
6	045: Дархан-Уул	13	86.65	9	37.01	69.23
7	021: Дорнод	8	3,000.00	0	0	0.00
8	048: Дундговь	12	47.23	7	38.88	58.33
9	081: Завхан	18	55.85	6	25.78	33.33
10	061: Орхон	3	7	1	5	33.33
11	062: Өвөрхангай	27	312.61	12	232.17	44.44
12	046: Өмнөговь	131	1909.56	37	288.11	28.24
13	022: Сүхбаатар	2	10.98	0	0	0.00
14	043: Сэлэнгэ	197	414.5	136	126.08	69.04
15	041: Төв	32	223.53	7	59.36	21.88
16	085: Увс	37	274.04	18	187.13	48.65
17	084: Ховд	156	441.23	73	240.66	46.79
18	067: Хөвсгөл	13	193.98	9	148.91	69.23
19	023: Хэнтий	11	407.55	6	390.3	54.55
20	011: Улаанбаатар	142	920.98	47	127.96	33.1
Нийт		917	11839.29	428	5238.13	36.53

2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ойн сан бүхий газрын ангиллын газарт дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Говь-Алтай аймаг 83.87 хувь, Дархан-Уул аймаг 69.23 хувь, Хөвсгөл аймаг 69.23 хувь, Сэлэнгэ аймаг 69.04 хувь, Дундговь аймаг 58.33 хувь, Хэнтий аймаг 54.55 хувь, хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Архангай аймаг 3 байршилд 12.27 га газарт мод үржүүлгийн газар, Баянхонгор аймаг 3 байршилд 28.59 га газарт мод үржүүлгийн газар, 1 байршилд 0.49 га газарт таримал ой бий болгох газар, Дорнод аймаг 8 байршлын 3.0 мянган га газарт өвчин, хортон шавжтай тэмцэх

ой бүхий газрыг хамгаалах, Сүхбаатар аймаг 2 байршилд 10.98 га газарт мод үржүүлгийн газар байгуулахаар тус тус төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

Говьсүмбэр аймаг, Дорноговь аймаг ойн сан бүхий газрын ангилалд арга хэмжээ төлөвлөөгүй байна.



Зураг 1.10.3.8. Ойн сан бүхий газрын зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт газрын хэмжээгээр /га-гаар/

Усны сан бүхий газар

Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд нийт 94 байршилд 1.0 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 53 байршилд 0.95 мянган га газарт хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлснээр улсын хэмжээнд усны сан бүхий газрын ангиллын төлөвлөгөөний хэрэгжилт 51.6 хувьтай байна.


Хүснэгт 1.10.3.9. Усны сан бүхий газрын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

д/д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	1	0.02	0	0	0
2	064: Баянхонгор	4	567.59	1	567.16	25
3	063: Булган	14	5.28	5	1.62	35.7143
4	082: Говь-Алтай	1	0.12	1	0.12	100
5	044: Дорноговь	1	64.3	1	64.3	100
6	021: Дорнод	5	0.5	3	0.09	60
7	062: Өвөрхангай	6	1.05	6	1.05	100
8	046: Өмнөговь	3	0.37	3	0.37	100
9	043: Сэлэнгэ	2	15.09	0	0	0
10	041: Төв	6	10.31	0	0	0
11	085: Увс	31	339.24	25	318.54	80.6452
12	067: Хөвсгөл	4	27.54	1	2.01	25
13	023: Хэнтий	16	14.62	7	0.02	43.75
Нийт		94	1046.03	53	955.28	51.6

2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний усны сан бүхий газрын ангилалд дараах аймгууд хангалттай сайн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь аймгууд 100 хувь, Увс аймаг 80.64 хувь, Дорнод аймаг 60 хувьтай, хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.

Харин Архангай аймаг 1 байршилд 0.02 га газрыг усны эх булаг, эрэг орчмын газрыг хашиж хамгаалах, Сэлэнгэ аймаг 1 байршилд 6.09 га газрыг усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авах, 2 байршилд хиймэл нуур, хөв, цөөрөм байгуулах газар, Төв аймаг 5 байршилд усан сан бүхий газрын хамгаалалтын бус дэх зөвшөөрөгдсөн газар ашиглалт, 1 байршилд усан сан бүхий газар болон усан орчинд амьдардаг биологийн төрөл зүйлийг хамгаалах, эрүүл ахуйн бүсийг тус тус төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.

Иймд тухайн жилийн төлөвлөгөө боловсруулахдаа суурин болон хээрийн судалгааны ажлыг оновчтой, үнэн, бодит төлөвлөх, хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэж, газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системд хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн гүйцэт оруулж хэвших шаардлагатай байна.



Зураг 1.10.3.9. Усны сан бүхий газрын зориулалтаар ашиглуулах, хамгаалах газрын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт газрын хэмжээгээр /га-гаар/

Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг газрын талбайн хэмжээгээр харуулсан зургаас үзэхэд Баянхонгор аймаг 4 байршилд 567.59 га газар төлөвлөснөөс 1 байршилд 567.16 га газарт усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг байгуулснаар талбайн хэмжээний биелэлт

хангалттай боловч төлөвлөгөөнд тусгагдсан 3 байршилд хамгаалах арга хэмжээ хийгдээгүй тул хэрэгжилт хангалтгүй үзүүлэлттэй гарч байна. Иймд төлөвлөгөөний төслийг боловсруулахад хээрийн судалгааны ажлыг аргачлалын дагуу гүйцэтгэх нь зүйтэй юм.

Тусгай хэрэгцээний газар


Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд нийт 241 байршилд 1903.34 мянган га газар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 113 байршилд 1856.87 мянган га газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлснээр улсын хэмжээнд тусгай хэрэгцээний газрын ангиллын төлөвлөгөөний хэрэгжилт 61.63 хувтай байна.

Хүснэгт 1.10.3.9. Тусгай хэрэгцээний газрын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал

Д/Д	Аймаг, нийслэл	2022 онд төлөвлөсөн		Төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн		Хэрэгжилтийн хувь
		Нийт нэгж талбар	Нийт талбайн хэмжээ /га/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	
1	065: Архангай	4	28.25	3	28.18	75.00
2	064: Баянхонгор	2	842,593.52	2	842,593.52	100.00
3	063: Булган	20	46.97	18	45.82	90.00
4	082: Говь-Алтай	8	5.55	7	5.3	87.50
5	045: Дархан-Уул	1	392.12	0	0	0.00
6	044: Дорноговь	1	3.98	1	3.98	100.00
7	021: Дорнод	61	61	0	0	0.00
8	048: Дундговь	5	277,998.73	5	277,998.73	100.00
9	081: Завхан	25	20.21	13	6.7	52.00
10	062: Өвөрхангай	8	45.14	6	45.08	75.00
11	046: Өмнөговь	13	363,775.25	7	317,870.95	53.85
12	022: Сүхбаатар	6	418,192.72	6	418,192.72	100.00
13	043: Сэлэнгэ	13	12.81	11	10.82	84.62
14	041: Төв	13	68.23	2	1.5	15.38
15	085: Увс	34	72.13	18	50.7	52.94
16	067: Хөвсгөл	6	4.22	2	0.72	33.33
17	023: Хэнтий	17	18.8	11	11.8	64.71
18	011: Улаанбаатар	4	5.9	1	1.5	25.00
Нийт		241	1903345.53	113	1856868.02	61.63

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний Тусгай хэрэгцээний газрын ангиллын газрын биелэлтийг авч үзэхэд Баянхонгор, Дорноговь, Дундговь, Сүхбаатар аймгууд 100 хувь, Булган аймаг 90 хувь, Говь-Алтай аймаг 87.5 хувь, Сэлэнгэ аймаг 84.62 хувь, Архангай аймаг 70 хувь, Өвөрхангай 75 хувь, Хэнтий аймаг 64.71 хувь, хангалттай сайн хэрэгжүүлсэн байна.


Харин Дархан-Уул аймаг 1 байршилд 392.12 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, Дорнод аймаг 61 байршилд 61 га газрыг байгалийн нөөц газарт зөвшөөрсөн газар ашиглалтаар төлөвлөсөн боловч хэрэгжээгүй байна.



Зураг 1.10.3.9. Тусгай хэрэгцээний газрын зориулалтаар эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлж, хамгаалсан арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт /газрын хэмжээгээр /га-гаар/

1.10.4. 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө

Улсын хэмжээнд нийт 330 сум, 9 дүүргээс 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээс тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулсан байдлыг үзэхэд төлөвлөгөөгөө баталсан 241 сум, баталгаажуулах шатанд 6, төсөл боловсруулах шатанд 91, илүү төсөл үүсгэсэн 31 сум, дүүрэг, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төсөл үүсгээгүй байна.




Зураг 1.10.4.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний явц

Хүснэгт 1.10.4.1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл үүсгэсэн байдал /аймаг, нийслэлээр/

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн тоо	Төлөвлөгөөний явц				Илүү төсөл үүсгэсэн	Баталсан
			Батлагдан	Баталгаажуулах	Төсөл боловсруулах	Төсөл үүсгэгүй		
1	Архангай	19	17	1	1	-	-	
2	Баян-Өлгий	13	6	-	7	-	1	Өлгий
3	Баянхонгор	20	15	-	5	-	1	Баянхонгор
4	Булган	16	16	-	-	-	-	
5	Говь-Алтай	18	15	1	2	-	2	Дэлгэр Хөхмөрт
6	Говьсүмбэр	3	3	-	-	-	-	
7	Дархан-Уул	4	-	-	4	-	2	Дархан Орхон
8	Дорноговь	14	14	-	-	-	-	
9	Дорнод	14	13	-	1	-	4	Баян-Уул Гурванзагал-2 Сэргэлэн
10	Дундговь	15	15	-	-	-	1	Асгат Дөрвөлжин Завханмандал
11	Завхан	24	24	-	-	-	7	Отгон Сонгино Цагаанчулут Яруу
12	Орхон	2	2	-	-	-	-	
13	Өвөрхангай	19	3	-	15	1	-	
14	Өмнөговь	15	15	-	-	-	2	Гурвантэс Мандал-Овоо
15	Сүхбаатар	13	13	-	-	-	-	
16	Сэлэнгэ	17	0	3	14	-	2	Зүүнбурэн Мандал
17	Төв	27	18	-	9	-	2	Архуст Баянчандмань
18	Увс	19	17	-	2	-	4	Бөхмөрөн Тэс-3

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

19	Ховд	17	2	-	15	-	1	Дуут	
20	Хөвсгөл	23	21	-	2	-	-		
21	Хэнтий	18	12	-	6	-	-		
22	Улаанбаатар	9	-	1 Бага-нуур	8	-	2	Баянзүрх Сонгино-хайрхан	
	Нийт	339	241	6	91	1	31		



Зураг 1.10.4.2. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг илүү үүсгэсэн сумд

Улсын хэмжээнд 2023 оны нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний баталсан болон боловсруулсан төслөөс үзэхэд газрын нэгдмэл сангийнгилалд нийт 97464 байршилд 5.5 сая га газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх, хамгаалах, нөхөн сэргээхээр төлөвлөсөн байна. Үүнээс хөдөө, аж ахуйн ангиллын газарт 15873 байршилд 4.7 сая га, хот, тосгон бусад суурины газарт 79054 байршилд 93.1 мянган га, зам, шугам сүлжээний газарт 355 байршилд 149.7 мянган га, ойн сан бүхий газарт 1729 байршилд 50.7 мянган га, усны сан бүхий газарт 98 байршилд 2.0 мянган га, тусгай хэрэгцээний газарт 355 байршилд 419.9 мянган га газрыг тус тус төлөвлөсөн байна.



Зураг 1.10.4.3. Газрын нэгдмэл сангийн ангиллаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харуулбал (нэгж талбарын тоогоор):

Дээрх зургаас харахад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хот, тосгон бусад суурины ангиллын газарт 81.11 хувь, хөдөө, аж ахуйн ангиллын газарт 16.29 хувь, ойн сан бүхий ангиллын газарт 1.77 хувь, зам шугам сүлжээний ангиллын газарт 0.36 хувь, тусгай хэрэгцээний ангиллын газарт 0.36, усны сан бүхий ангиллын газарт 0.1 хувиар газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчүүлэх, хамгаалах, нөхөн сэргээхээр тус тус төлөвлөсөн байна.

Хүснэгт 1.10.4.2. 2023 оны тухайн жилийн төлөвлөгөөгээ гарын нэгдмэл сангийн ангиллаар.

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Хөдөө, аж ахуйн газар		Хот, тосгон бусад суурины газар		Зам, шугам сүлжээний газар	
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар/	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га-гаар/
1	065: Архангай	868	65.8012	789	222.7094	2	3.1585
2	064: Баянхонгор	530	1546006.118	1472	12705.2218	12	350.9418
3	083: Баян-Өлгий	504	95599.7257	1753	54.1287	7	262.2942
4	063: Булган	515	76026.7576	3066	2368.7369	13	0.3457
5	082: Говь-Алтай	700	160084.3435	1072	172.2101	24	2040.2468
6	042: Говьсумбэр	31	10805.2844	336	292.6396		0
7	045: Дархан-Уул	123	140.1261	6147	982.112	23	4.6934
8	044: Дорноговь	161	1532853.029	1343	1538.117	60	458.3693
9	021: Дорнод	1537	378505.6908	1128	4296.055	3	1.2411
10	048: Дундговь	188	2029.74	943	4489.9112	14	144878.994
11	081: Завхан	668	307957.1916	985	169.7395	10	42.8013
12	062: Өвөрхангай	867	274681.0551	1375	2050.6634	22	177.2042
13	046: Өмнөговь	245	140.0902	1057	2177.4919	38	598.781
14	061: Орхон	100	58.1369	1621	571.0744		0
15	022: Сүхбаатар	476	5256.109	1711	1687.4882	4	0.04
16	043: Сэлэнгэ	1160	41154.7645	4714	601.1497	16	595.1249
17	041: Төв	1644	80391.8931	10245	49128.417	19	134.0523
18	085: Увс	874	68,953	1562	3,791	22	96
19	084: Ховд	891	1528.8536	1080	352.2041	10	36.0667
20	067: Хөвсгөл	1403	20317.0053	1381	2405.5574	17	0.1519

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

21	023: Хэнтий	1435	138513.2755	2355	288.7448	4	0.0489
22	011: Улаанбаатар	953	197	32919	2,784	35	12
Нийт		15873	4741265.664	79054	93128.8119	355	149693.348

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Ойн сан бүхий газар		Усны сан бүхий газар		Тусгай хэрэгцээний газар	
		Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ / га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ / га-гаар	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ / га-гаар
1	065: Архангай		0	1	0.02	1	1
2	064: Баянхонгор	10	18.6196	4	92.9537	8	48.7389
3	083: Баян-Өлгий	17	15.1717		0		0
4	063: Булган	32	42641.3488	12	91.4512	9	41.7151
5	082: Говь-Алтай	7	39.1885	1	0.3145	7	23960.7021
6	042: Говьсүмбэр		0		0		0
7	045: Дархан-Уул	1261	122.5663		0	2	1.9804
8	044: Дорноговь	4	26.1556		0	5	501.3127
9	021: Дорнод	19	1211.5708	4	0.5694	82	3450.3788
10	048: Дундговь	3	6.6691	1	126.2796	12	336000.257
11	081: Завхан	48	164.021	1	6.8577	33	38774.878
12	062: Өвөрхангай	15	26.95	7	0.2801	3	2.01
13	046: Өмнөговь	54	4850.2501		0	8	761.467
14	061: Орхон	2	43.1142		0		0
15	022: Сүхбаатар	4	113.9338	1	53.8881	15	15.7782
16	043: Сэлэнгэ	59	391.2076	3	19.743	9	67.3819
17	041: Төв	17	70.7451		0	26	7814.2735
18	085: Увс	23	166	42	365	117	6,325
19	084: Ховд	89	210.3516		0		0
20	067: Хөвсгөл	7	22.5672	1	1.9099	13	1040.1204
21	023: Хэнтий	12	383.2283	13	1265.8777	4	1135.0271
22	011: Улаанбаатар	46	193	7	9	1	1
Нийт		1729	50716.6653	98	2034.0214	355	419943.052

2

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 113567.1 мянган га буюу 72.6 хувь, хот, тосгон бусад суурины газар 1005.3 мянган га буюу 0.6 хувь, зам, шугам сүлжээний газар 836.0 мянган га буюу 0.5 хувь, ойн сан бүхий газар 14260.3 мянган га буюу 9.1 хувь, усны сан бүхий газар 660.9 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 26082.0 мянган га буюу 16.7 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тус бүрийн эзлэх хувь

Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайлангийн дүнг 2021 оны дунтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 412.9 мянган га-гаар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 49.1 мянган га, зам, шугам сүлжээний газар 358.8 мянган га, ойн сан бүхий газар 3.7 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 1.3 мянган га-гаар тус тус нэмэгдсэн байна. Усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна /Хүснэгт 2.1.1/.

Хүснэгт 2.1.1: Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товчоо /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2021	2022	Өөрчлөлт /мян га/
I	Хөдөө аж ахуйн газар	113980.0	113567.1	-412.9
1	Бэлчээрийн газар	109584.6	109151.3	-433.3
2	Хадлангийн талбай	1708.8	1709.1	0.3
3	Тариалангийн газар	1126.2	1139.9	13.7

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

4	Атаршсан газар	211.6	215.5	3.9
5	ХАА-н Барилга, байгууламжийн дэвсгэр газар	88.9	91.4	2.5
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.9	1259.9	0.0
II	Хот, тосгон бусад суурины газар	956.2	1005.3	49.1
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	81.2	83.5	2.3
8	Нийтийн эдэлбэр газар	321.4	317.7	-3.7
9	Үйлдвэрийн газар	46.3	47.3	1.0
10	Уурхайн газар	420.6	466.4	45.8
11	Гэр хорооллын газар	86.7	90.4	3.7
III	Зам, шугам сүлжээний газар	477.2	836.0	358.8
12	Авто замын газар	330.6	331.2	0.6
13	Төмөр замын газар	35.7	35.7	0.0
14	Агаарын тээврийн газар	9.6	9.7	0.1
15	Шугам сүлжээний газар	101.3	459.5	358.2
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
IV	Ойн сан бүхий газар	14256.6	14260.3	3.7
17	Ой modoор бүрхэгдсэн газар	12108.9	12108.9	0.0
18	Ой модыг нь отолсон газар	133.0	133.3	0.3
19	Мод үргүүлгийн газар	63.3	66.5	3.2
20	Ой тэлэн ургах нөөц газар	719.0	719.0	0.0
21	Ойн сангийн бусад газар	1232.4	1232.5	0.1
V	Усны сан бүхий газар	660.9	660.9	0.0
22	Гол мөрний эзлэх газар	221.3	221.3	0.0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	423.8	423.8	0.0
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	13.2	13.2	0.0
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	2.6	2.6	0.0
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	26080.7	26082.0	1.3
26	Улсын тусгай хамгаалалттай газар	21927.0	21927.0	0.0
27	Улсын хилийн зурvas газар	3110.3	3110.3	0.0
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.1	0.0
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	36.1	36.1	0.0
31	Аймаг дундын отрын бэлчээр	691.4	691.4	0.0
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Газрын тосны гэрээт талбай	24.5	24.5	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
35	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	54.2	55.5	1.3
36	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	0.0	0.0	0.0
НИЙТ ДҮН		156411.6	156411.6	0.0

2.1.1. Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газар 113567.1 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 72.6 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар 109151.3 мянган га буюу 96.1 хувь, хадлангийн газар 1709.1 мянган га буюу 1.5 хувь, тариалангийн газар 1139.9 мянган га буюу 1.0 хувь, атаршсан газар 215.5 мянган га буюу 0.2 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 91.4 мянган га буюу 0.1 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.9 мянган га буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангиалал	2021	2022	Өөрчлөлт /мян.га/
I	Хөдөө аж ахуйн газар	113980.0	113567.1	-412.9
1	Бэлчээрийн газар	109584.6	109151.3	-433.3
2	Хадлангийн талбай	1708.8	1709.1	0.3
3	Тариалангийн газар	1126.2	1139.9	13.7
4	Атаршсан газар	211.6	215.5	3.9
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	88.9	91.4	2.5
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1259.9	1259.9	0.0

Бэлчээрийн газар

Бэлчээрийн газар нь 2021 оны тайлангийн дүнтэй харьцуулахад Баянхонгор аймаг 8612.7 га, Дорнод аймаг 5725.0 га, Дорноговь аймаг 23886.31 га, Өмнөговь аймаг 4061.77 га, Сэлэнгэ аймаг 1329.3 га газруудыг уурхайн дэвсгэр газарт, Дундговь аймаг 354844.3 га, Өмнөговь аймаг 2169.6 га газруудыг шугам сүлжээний газарт, Өвөрхангай аймаг 8286.2 га, Төв аймаг 2500.0 га газруудыг атаршсан газарт, Увс аймаг 1689.0 га, Ховд аймаг 3412.4 га газруудыг тариалангийн газарт тус тус шилжүүлэн томоохон өөрчлөлт оруулсан байна.

Харин Увс аймаг 40.3 га, Өмнөговь аймаг 1573.6 га газрыг уурхайн газраас бэлчээрийн газарт шилжсэн байна.

Хадлангийн газар

Хадлангийн газар нийтдээ 305.4 га-гаар нэмэгдсэн байгаа нь Баян-Өлгий аймаг 18.7 га, Говь-Алтай аймаг 4 га, Завхан аймаг 2 га, Увс аймаг 261.7 га, Ховд аймаг 23 га газар хадлангийн газар нэмэгдсэн байна.

Тариалангийн газар

Тариалангийн газар нь 2021 оны тайллангийн дүнтэй харьцуулахад 13707.5 га-гаар нэмэгдсэн байна. Тариалангийн газрын хувьд Архангай аймаг 1906.8 га, Баянхонгор аймаг 10.9 га, Булган аймаг 538.0 га, Говь-Алтай аймаг 72.2 га, Дорнод аймаг 1735.6 га, Завхан аймаг 1860.0 га, Өвөрхангай аймаг 16.9 га, Сэлэнгэ аймаг 59.4 га, Ховд аймаг 117.4 га, Хэнтий аймаг 340.0 га, Улаанбаатар хот 36.9 га газрыг тус тус атаршсан газраас тариалангийн газарт эргүүлэн ашигласнаар Улсын хэмжээнд тариалангийн газар нэмэгдэж бүртгэгдсэн байна.

Ховд аймгийн Ховд сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/36 тоот захирамжаар 2137 га газрыг тэжээлийн ургамал тариалах зориулалтаар, 50 иргэнд 123,2 га газрыг тариалан эрхлэх зориулалтаар, Буйнт сумын Засаг даргын захирамжаар 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 7 аж ахуйн нэгж, байгууллагад 150 га, 92 иргэнд 296,1 га газрыг тариалангийн газрын зориулалтаар, Үенч сумын Засаг даргын захирамжаар 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төсөвт байгууллагад төмс хүнсний ногоо тариалангийн зориулалтаар 300 га, төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар 53 иргэнд 257 га газрыг тус тус бэлчээрийн газраас олгосон байна.

Увс аймгийн хэмжээнд 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баруунтуруун, Завхан, Зүүнговь, Зүүнхангай, Малчин, Өмнөговь, Өндөрхангай, Сагил, Тариалан, Түргэн, Ховд, Хяргас, Цагаанхайрхан зэрэг сумдын Засаг даргын шийдвэрээр нийт 1689,05 га газрыг үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал ургамал тариалах зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шинээр эзэмшүүлсэн байна.


Мөн Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд нийт 6884.6 га газрыг бэлчээрээс тариалангийн газарт тус тус нэмэгдэж бүртгэгдсэн байна /Хүснэгт 2.1.1.2/.

Хүснэгт 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /га/

№	Аймгийн нэр	2021	2022	Зөрүү
1	Архангай	29838.1	30220.4	382.32
2	Баянхонгор	2214.1	2341.8	127.72
3	Баян-Өлгий	2714.9	2797.4	82.51
4	Булган	90142.1	90699.6	557.49
5	Говь-Алтай	5604.8	5792.8	187.95
6	Говьсүмбэр	352	452.0	100.02
7	Дархан-Уул	34278.7	34411.0	132.28
8	Дорноговь	704.3	749.2	44.93
9	Дорнод	95698.3	97433.9	1735.64
10	Дундговь	806.6	838.3	31.69
11	Завхан	19078.5	20938.5	1860.02

12	Орхон	5113.6	5179.8	66.17
13	Өвөрхангай	26205.5	26733.5	528
14	Өмнөговь	720.8	733.1	12.34
15	Сүхбаатар	17239.8	17375.9	136.09
16	Сэлэнгэ	316813.6	317209.1	395.49
17	Төв	263569.2	265226.2	1656.99
18	Увс	81868.6	83557.7	1689.06
19	Ховд	11104.5	14634.2	3529.73
20	Хөвсгөл	33388	33477.1	89.07
21	Хэнтий	80708.3	81033.3	325.04
22	Нийслэл	8005	8042.0	36.97
Нийт дүн		1126169.5	1139876.8	13707.52

Тариалангийн газрын зориулалтаар 1990 оноос хойшхи хугацаанд ашиглагдаж буй талбайн Улсын хэмжээний дүнг дараах зурагт үзүүлэв /Зураг 2.1.1.2/.



Зураг 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар

Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар Улсын хэмжээнд нийтдээ 2.5 мянган га-гаар бэлчээрийн газар, атаршсан газар, нийтийн эдэлбэр газраас тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газарт тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

2.1.2. Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон бусад суурины газар 1005.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.6 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 83.5 мянган га буюу 8.7 хувийг, нийтийн эдэлбэр газар 317.7 мянган га буюу 33.2 хувийг, үйлдвэрийн газар 47.3 мянган га буюу 4.9 хувийг, уурхайн газар 466.4 мянган га буюу 48.8 хувийг, гэр хорооллын газар 90.4 мянган га буюу 9.5 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1/.



Зураг 2.1.2.1: Хот тосгон, бусад сууриин газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.2.1. Хот, тосгон, бусад сууриин газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2021	2022	Өөрчлөлт /мян га/
II	Хот, тосгон бусад суурины газар	956.2	1005.3	49.1
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	81.2	83.5	2.3
2	Нийтийн эдэлбэр газар	321.4	317.7	-3.7
3	Уйлдвэрийн газар	46.3	47.3	1.0
4	Уурхайн газар	420.6	466.4	45.8
5	Гэр хорооллын газар	86.7	90.4	3.7

Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайлангийн дүнгээр бэлчээрийн газраас 1742.4 га, тариалангийн газраас 2 га, нийтийн эдэлбэр газраас 692.2 га, үйлдвэрийн газраас 0.1 га, гэр хорооллын газраас 3 га газрууд тус тус барилга байгууламжийн дэвсгэр газарт нэмэгдэн бүртгэгдсэн байна.


Харин барилга, байгууламжийн дэвсгэрт газраас бэлчээрийн газарт 25.6 га, нийтийн эдэлбэр газарт 40.5 га газар шилжсэн байна.

Хот, тосгон бусад сууриин газарт орсон томоохон өөрчлөлт нь Баянхонгор аймаг 8612.8 га, Булган аймаг 1261.4 га, Дорнод аймаг 5725 га, Дорноговь аймаг 23886.3 га, Өмнөговь аймаг 4061.8 га, Сүхбаатар аймаг 1329.25 га газрыг бэлчээрийн газраас уурхайн дэвсгэр газарт шилжүүлсэн байна.

2.1.3. Зам, шугам сүлжээний газар

Зам, шугам сүлжээний газар 836.0 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.5 хувийг эзэлж байгаа бөгөөд 2021 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 358.8 га-аар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.1.3.1/.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар 331.2 мянган га буюу 39.6 хувийг, төмөр замын газар 35.7 мянган га буюу 4.3 хувийг, агаарын тээврийн газар 9.7 мянган га буюу 1.2 хувийг, шугам сүлжээний газар 459.5 мянган га буюу 55.0 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.3.1/.



Зураг 2.1.3.1: Зам, шугам сүлжээний газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.3.1: Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2021	2022	Өөрчлөлт /мян га/
III	Зам, шугам сүлжээний газар	477.2	836.0	358.8
1	Авто замын газар	330.6	331.2	0.6
2	Төмөр замын газар	35.7	35.7	0.0
3	Агаарын тээврийн газар	9.6	9.7	0.1
4	Шугам сүлжээний газар	101.3	459.5	358.2
5	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

Улсын хэмжээнд тайлант онд авто замын газар 559.5 га, төмөр замын газар 31.0 га, шугам, сүлжээний газар 358213.2 га-аар нэмэгдсэн байна.

Агаарын тээврийн газар нь Хөвсгөл аймагт 23.9 га, Сэлэнгэ аймагт 35.6 га, Баян-Өлгий аймагт 38.9 га-аар нэмэгдсэн байх бөгөөд тайлант онд шугам, сүлжээний газарт томоохон өөрчлөлт орсон нь Дундговь аймгийн Адаацаг, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн, Гурван сайхан сумдад “Ю Пи Си Мандалговь Энержи” ХХК салхин сэнсний зориулалтаар 354643.9 га газрыг ашиглах эрхээр олгон бүртгэсэн байна.

2.1.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газар 14260.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.1 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12108.9 мянган га буюу 84.9 хувийг, ой модыг нь отолсон газар 133.3 мянган га буюу 0.9 хувийг, мод үржүүлгийн газар 66.5 мянган га буюу 0.5 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 719.0 мянган га буюу 5.0 хувийг, ойн сангийн бусад газар 1232.5 мянган га буюу 8.6 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.4.1/.



Зураг 2.1.4.1: Ойн сан бүхий газрын эзлэх хувь

Хүснэгт 2.1.4.1: Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/


№	Газрын нэгдмэл сангийн ангиалал	2021	2022	Өөрчлөлт /мян.га/
IV	Ойн сан бүхий газар	14256.6	14260.3	3.7
1	Ой modoор бүрхэгдсэн газар	12108.9	12108.9	0.0
2	Ой модыг нь отолсон газар	133.0	133.3	0.3
3	Мод үржүүлгийн газар	63.3	66.5	3.2
4	Ой тэлэн ургах нөөц газар	719.0	719.0	0.0
5	Ойн сангийн бусад газар	1232.4	1232.5	0.1

Тайлант онд Баянхонгор аймаг 59.9 га, Баян-Өлгий аймаг 698.6 га, Булган аймаг 15.5 га, Дархан-Уул аймаг 52.3 га, Дорноговь аймаг 32.5 га, Дундговь аймаг 93 га, Завхан аймаг 16 га, Орхон аймаг 48.7 га, Өвөрхангай аймаг 74.4 га, Өмнөговь аймаг 1707.4 га, Сүхбаатар аймаг 5 га, Сэлэнгэ аймаг 183.4 га, Төв аймаг 217 га, Увс аймаг 6.5 га, Ховд аймаг 337.6 га, Хэнтий аймаг 1.5 га, Улаанбаатар хот 37 га газрыг тус тус бэлчээрийн газар болон нийтийн эдэлбэрийн газраас шилжүүлэн нэмж бүртгэсэн байна.

2.1.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газар 660.9 мянган га буюу нийт газар нутгийн 0.4 хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 221.3 мянган га буюу 33.5 хувийг, нуур, цөөрөм 423.8 мянган га буюу 64.1 хувийг, горхи, булаг, шанд 13.2 мянган га буюу 2.0 хувийг, мөнх цас, мөсөн гол 2.6 мянган га буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.5.1/.



Зураг 2.1.5.1: Усны сан бүхий газрын эзлэх хувь


Хүснэгт 2.1.5.1: Усны сан бүхий газрын өөрчлөлт /мян.га./

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2021	2022	Өөрчлөлт /мян га/
V	Усны сан бүхий газар	660.9	660.9	0.0
1	Гол мөрний эзлэх газар	221.3	221.3	0.0
2	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	423.8	423.8	0.0
3	Горхи, булаг, шандны эзлэх газар	13.2	13.2	0.0
4	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	2.6	2.6	0.0

Усны сан бүхий газрын хэмжээнд 2022 онд өөрчлөлт ороогүй байна.

2.2. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/

Улсын тусгай хэрэгцээний газрын нийт хэмжээ 2022 оны байдлаар **26082.0 мянган га** талбай буюу Улсын нийт нутаг дэвсгэрийн **16.67** хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 0.01 хувиар өссөн байна.



Зураг 2.2.1. Улсын тусгай хэрэгцээний газрын эзлэх хувь

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 21927.0 мянган га буюу 84.07 хувийг, улсын хилийн зурvas газар 3110.3 мянган га буюу 11.92 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124.1 мянган га буюу 0.47 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0.04 мянган га буюу 0.0001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 36.1 мянган га буюу 0.13 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 691.4 мянган га буюу 2.65 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.9 мянган га буюу 0.42 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24.4 мянган га буюу 0.09 хувийг, чөлөөт бүсийн газар 2.1 мянган га буюу 0.008 хувийг, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар 55.4 мянган га буюу 0.2 хувийг, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар 0.04 мянган га буюу 0.0001 хувийг тус тус эзэлж байна.


Тайлант онд Улсын хэмжээнд 1335.9 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 171 дугаар тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын нутаг дэвсгэрийн 1217.4 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар;
- Засгийн газрын 2022 оны 282 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг 98.5 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар;
- Засгийн газрын 2022 оны 377 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 20 га газрыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих зориулалтаар тус тус Улсын тусгай хэрэгцээнд авсан байна.

Хүснэгт 2.2.1. Улсын тусгай хэрэгцээний газрын өөрчлөлт /га-гаар/

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	2021	2022	Зөрүү
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	26080703.87	26082039.58	1335.9
1	Улсын тусгай хамгаалалттай газар, бүгд	21926998.72	21926998.72	0.0
а	дархан цаазат газар	10919403.00	10919403.00	0.0
б	байгалийн цогцолборт газар	8883939.10	8883939.10	0.0
в	байгалийн нөөц газар	2044351.62	2044351.62	0.0
г	дурсгалт газар	79305.00	79305.00	0.0
2	Улсын хилийн зурvas газар	3110340.89	3110340.89	0.0
3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	124097.61	124097.61	0.0
4	Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	37.62	37.62	0.0
5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	36125.64	36125.64	0.0
6	Аймаг дундын отрын бэлчээр	691413.80	691413.80	0.0
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	110940.00	110940.00	0.0

8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	24470.00	24470.00	0.0
9	Эдийн засгийн чөлөөт бусийн газар	2108.40	2108.40	0.0
10	Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	54149.01	55464.90	1315.9
11	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	22.00	42.00	20.0



Зураг 2.2.2. Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га/


Энэхүү өөрчлөлтөөр хөдөө аж ахуйн газраас 289.1 га, хот тосгон, бусад суурины газраас 1046.8 га газар тус тус Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн байна.

Хүснэгт 2.2.2. Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд шилжсэн газрууд /га/

Газрын нэгдмэл сангийн ангилал		Талбайн хэмжээ /га/
Хөдөө аж ахуйн газар	Бүгд	289.1
	Бэлчээр	289.1
	Хадлан	-
	Тариалан	-
	Атаршсан газар	-
	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	-
Хот тосгон, бусад суурины газар	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	-
	Бүгд	1046.8
	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	-
	Уурхайн газар	871.4
	Нийтийн эдэлбэрийн газар	175.4
Зам, шугам сүлжээний газар	Гэр хорооллын газар	-
	Бүгд	-
	Авто зам	-
	Төмөр зам	-
	Агаарын тээвэр	-
Ойн сан бүхий газар	Шугам сүлжээний газар	-
	Бүгд	-
	Ойгоор бүрхэгдсэн газар	-
	Ой модыг нь оттолсон газар	-
	Мод үргүүлгийн газар	-
Нийт дүн		1335.9


2.3. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт **8496.9** мянган га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс **70.1** мянган га газрыг өмчилж, **7676.2** мянган га газрыг эзэмшиж, **722.8** мянган га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага **27.8** мянган га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.3.1/.




Зураг 2.3.1: 2021 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /хувиар/

Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2021 онтой харьцуулбал **428.2** мянган га-гаар өссөн байна /Зураг 2.3.2/.




Зураг 2.3.2: Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтанд буй газрыг урьд оны дунтэй харьцуулсан байдал /мян.га-гаар/


Газрын эрхийн төрлөөр 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн газар **70.1** мянган га болж **2.0** мянган га-гаар /Зураг 2.3.3/, иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж буй газар **7676.2** мянган га болж **40.2** мянган га-гаар /Зураг 2.3.4, иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газар **722.8** мянган га болж **385.7** мянган га-гаар /Зураг 2.3.6/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар **27.8** мянган га болж **0.3** мянган га-гаар тус тус өссөн дунтэй байна /Зураг 2.3.5/.




Зураг 2.3.3: Өмчлүүлсэн газар /га-гаар/



Зураг 2.3.4: Эзэмшүүлсэн газар /га-гаар/



Зураг 2.3.5: Бусдад ашиглуулж буй



Зураг 2.3.6: Ашиглуулсан газар /га-гаар/ эзэмшлийн газар /га-гаар/

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт **1366.4** мянган га, хот тосгон, бусад суурины газарт **710.8** мянган га, зам, шугам сүлжээний газарт **550.5** мянган га, ойн сан бүхий газарт **681.7** мянган га, усны сан бүхий газарт **83.3** мянган га, улсын тусгай хэрэгцээний газарт **5106.3** мянган га газар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна /Зураг 2.3.7/.

Хүснэгт 2.3.1: Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эрхийн төрлийн өөрчлөлт /мян.га-аар/


д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2021 он	2022 он	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	0.1	0.1	0
		эзэмшигч	1328.0	1350.6	22.6
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7.0	7.1	0.1
		ашиглагч	10.0	8.5	-1.5
		НИЙТ	1345.1	1366.4	21.3

		өмчлөгч	67.7	69.7	2.0
		эзэмшигч	371.0	387.6	16.6
2	Хот, тосгон, бусад суурины газар	бусдын эзэмшил газрыг ашиглагч	16.7	16.8	0.1
		ашиглагч	204.3	236.6	32.3
		нийт	659.8	709.6	49.8
		өмчлөгч	0.2	0.2	0.0
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	162.4	164.0	1.6
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	3.4	3.4	0.0
		ашиглагч	28.1	383.1	355
		нийт	194.2	550.8	356.6
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	674.8	675.7	0.9
		ашиглагч	6.0	6.0	0.0
		нийт	680.7	681.7	1
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	83.3	83.3	0.0
		ашиглагч	0.00	0.00	0.0
		нийт	83.3	83.3	0.0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	5016.6	5017.4	0.8
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	0.3	0.3	0.0
		ашиглагч	88.6	88.6	0.0
		нийт	5105.5	5106.3	0.8



Зураг 2.3.7: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /хувиар/

Тайлант онд зам, шугам сүлжээний газар ашиглагч 356.6 га талбайгаар нэмэгдсэн байгаа нь Дундговь аймгийн Адаацаг, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн, Гурван сайхан сумдад “Ю Пи Си Мандалговь Энержи” ХХК-нд салхин сэнсний зориулалтаар 354643.9 га газрыг ашиглах эрхээр олгосон байна.




Зураг 2.3.8: Нийт газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрын хэмжээг
21 аймгийн хэмжээнд үзүүлсэн байдал /га-аар/

Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах, онцгой чиг үүргийн байгууллагуудын тээврийн хэрэгслийг чөлөөтэй нэвтрэх, тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бурдүүлэх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт 188 байршилд 81.4 га газрыг чөлөөлсөн байна.

Уг чөлөөлсөн талбайгаас 71.4 га газарт тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.


2.4. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт **1198241** газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ **46765**-аар нэмэгдсэн байна /Зураг 2.4.1/.




Зураг 2.4.1: Нийт өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /тоогоор/

Тайлант онд газар өмчлөгч **680797**, эзэмшигч **515072**, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага **839**, газар ашиглагч **1533** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.4.2/.




Зураг 2.4.2: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын хувь


Газрын эрхийн төрлөөр 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад газар өмчлөгчийн тоо 680797 болж 17652-аар /Зураг 2.4.3/, газар эзэмшигчийн тоо 515072 болж 28973-өөр /Зураг 2.4.4/, газар ашиглагчийн тоо 1533 болж 122-аар /Зураг 2.4.5/, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 839 болж 18-аар /Зураг 2.4.6/ тус тус өссөн дүнтэй байна.




Зураг 2.4.3: Газар өмчлөгч /тоогоор/



Зураг 2.4.4: Газар эзэмшигч /тоогоор/



Зураг 2.4.5: Газар ашиглагч /тоогоор/



Зураг 2.4.6: Бусдын эзэмшил газрыг ашиглагч


Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт **184807**, хот тосгон, бусад суурины газарт **998677**, зам, шугам сүлжээний газарт **7688**, ойн сан бүхий газарт **5414**, усны сан бүхий газарт **70**, улсын тусгай хэрэгцээний газарт **1585** иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.4.7/.



Зураг 2.4.7: Газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /эзлэх хувь/


Хүснэгт 2.4.1: Газар эзэмшигч, ашиглагчдын өөрчлөлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2021	2022	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	133	99	-34
		эзэмшигч	181219	184474	3255
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	187	188	1
		ашиглагч	17	46	29
		нийт	181586	184807	3221
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	658912	676598	17686
		эзэмшигч	296099	320806	24707
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	216	220	4
		ашиглагч	1000	1053	53
		нийт	956227	998677	42450
3	Зам, шугам шүлжээний газар	өмчлөгч	4100	4100	0
		эзэмшигч	2896	3141	245
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	30	43	13
		ашиглагч	334	404	70
		нийт	7360	7688	328
4	Ойн сан бухий газар	эзэмшигч	4645	5405	760
		ашиглагч	9	9	0
		нийт	4654	5414	760
5	Усны сан бухий газар	эзэмшигч	70	70	0
		ашиглагч	0	0	0
		нийт	70	70	0
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	1170	1176	6
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	388	388	0
		ашиглагч	21	21	0
		нийт	1579	1585	6



Зураг 2.4.8: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын тоог

21 аймгийн хэмжээнд үзүүлсэн байдал /тоогоор/




Зураг 2.4.9: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын тооны өсөлтийг

2003 оноос хойш үзүүлсэн байдал /тоогоор/

2.5. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/

Нийслэл болон 21 аймгаас ирүүлсэн “Газарт учруулсан хохирлын тайлан”-г газрын нэгдмэл сангийн тайлангийн ГТ-6 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

Улсын хэмжээнд 2022 онд нийт 4'844'764.2 га газарт хохирол учирсан байгаа бөгөөд өмнөх оны дунгээс 1'462'590.2 га талбайгаар бага байна. Үүнийг ангилан үзвэл тариалангийн 81'450.2 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 4'681'503 га, хот тосгон, бусад суурин газрын 10'520.8 га, ойн сан бүхий газрын 56'832.6 га, усны сан бүхий газрын 195.5 га газарт тус тус хохирол учирсан бол 14'262.2 га газар ухагдаж эвдэрсэн байна /Зураг 2.5.1/



Зураг 2.5.1. Газарт учруулсан хохирлын хэмжээ.


2.5.1. Тариалангийн газар

Тариалангийн газрын хохирлын тайланг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шим буурсан, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химиийн бодисоор бохирдсон, бусад гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 81'450.2 га тариалангийн талбайд хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 1.68 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 31'089.5 га талбайгаар буурсан байна.

Тариалангийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөө 53'129.3 га (тариалангийн газрын ангиллын 65.23%), үржил шимиийн бууралттай 23.06 га (23%) байна.

Хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл химиийн бодисоор бохирдсон 7'542.1 га, салхины эвдрэлд орсон 3'838.4 га, усны эвдрэлд орсон 619.8 га, усны эвдрэлд орсон 619.8 га, онц аюултай ургамалд нэрвэгдсэн 206.6 га гэсэн дараалтай байна /Зураг 2.5.1.1/.



Зураг 2.5.1.1. Тариалангийн газарт учирсан хохирол, га-аар.


2.5.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газрын хохирлын тайланг талхлагдсан, салхи, усны эвдрэлд орсон, намагжсан, элсний нүүлтэд орсон, мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн, цөлжсөн, ашигт малтмалын олборлолтод өртсөн, газрын тосны олборлолтоос бохирдсон гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 4'681'503 га бэлчээрт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 93.6 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1'225'637.2 га талбайгаар буурсан байна.

Бэлчээрийн газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйл бол мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд нэрвэгдсэн байна. Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 56.91 хувь буюу 2'664'411 га талбай мэрэгчид, хортон шавьжийн нөлөөнд өртсөн байна.

Бусад хохирол учирсан бэлчээрийн газрыг ангилж үзвэл цөлжсөн 1'160'881 га (24.8%), талхлагдсан 603'426 га (12.89%), элсний нүүлтэд орсон 140'490.3 га (3%), салхи, усны эвдрэлд орсон 111'917 га (бэлчээрийн газрын ангиллын 2.39%), ашигт малтмалын олборлолтод өртсөн 375 га (0.01%) байна /Зураг 2.5.2.1/.



Зураг 2.5.2.1. Бэлчээрт учирсан хохирол, га-аар.

2.5.3. Хот тосгон, бусад суурин газар


Хот тосгон, бусад суурин газрын хохирлын тайланг ургамлан бүрхэвчгүй болсон, элсний нүүлтэд орсон, химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон, бусад гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 10'520.8 га хот суурины газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.2 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 33'981 га талбайгаар буурсан байна.

Хот тосгон, бусад суурин газрын бохирдолд нөлөөлсөн гол хүчин зүйл нь ахуйн хог хаягдлаар бохирдсон, элсний нүүлтэд орсон байна.

Өөрөөр хэлбэл нийт хохирол учирсан талбайн 90 орчим хувь буюу 9'571.1 га газар ахуйн хог хаягдлаар бохирдсон, 6.4 хувь буюу 677.5 га газар элсний нүүлтэд орсон байна.

Бусад хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл бусад 251.8 га (2.3%), үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 15.5 га (0.1%) гэсэн үзүүлэлттэй байна /Зураг 2.5.3.1/.




Зураг 2.5.3. Хот, тосгон бусад суурины газарт учирсан хохирол, га-аар.

2.5.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрын хохирлын тайланг түймэрт нэрвэгдсэн, өвчин, хортон шавьжинд идэгдсэн, мод бут, сөөг, загийг устгасан, ашигт малтмалын олборлолтод өртсөн, бусад гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 56'832.5 га ойн сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 1.17 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 17'2290.3 га талбайгаар буурсан байна.

Ойн сан бүхий газарт хамгийн их хохирол учруулсан хүчин зүйлийг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл өвчин хортон шавьжид идэгдсэн 51'741 га (ойн сангийн ангиллын газрын 91%), түймэрт нэрвэгдсэн 3282.8 га буюу 5.7%, мод бут, сөөг, загийг устгасан 1'808 га (3.1%) талбай байна /Зураг 2.5.4.1/.




Зураг 2.5.4.1. Ойн сан бүхий газарт учирсан хохирол, га-аар.

2.5.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрын хохирлын тайланг гадаргын болон гүний ус бохирдсон, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, бусад гэсэн 4 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 195.5 га усны сан бүхий газарт хохирол учирсан нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайн 0.03 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1'170 га талбайгаар буурсан байна.

Усны сан бүхий газрын хамгийн их хохирол учирсан талбайд гадаргын болон гүний ус бохирдсон 85.15 га буюу тухайн усан сангийн ангиллын газрын 43%, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн 30 га буюу 15%, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар 5.7 га талбай буюу 2.9%, бусад үйл ажиллагаанд хохирол учруулсан 74.6 га буюу 38.1% байна /Зураг 2.5.5.1/



Зураг 2.5.5. Усны сан бүхий газарт учирсан хохирол, га-аар.


2.5.6. Ухагдаж эвдэрсэн газар

Ухагдаж эвдэрсэн газрыг геологийн эрэл хайгуулын ажлаас, ашигт малтмалын олборлолтоос, батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас, зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 14'262.17 га газар ухагдаж эвдэрсэн нь нийт хохирол учирсан талбайн 0.29 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1'577.7 га талбайгаар нэмэгдсэн байна.

Ашигт малтмалын олборлолтын улмаас хамгийн их талбай ухагдаж эвдэрсэн байна. Өөрөөр хэлбэл ухагдаж эвдэрсэн газрын 79.8 хувь буюу 11'389.5 га газар ашигт малтмалын олборлолтод өртсөн байна.

Бусад хохирол учирсан талбайг ихээс бага руу эрэмбэлэн үзвэл зам тээвэр холбооны барилга засвар, үйлчилгээний ажлаас 2'327.5 га (16.3%), геологийн эрэл хайгуулын ажлаас 536.8 га (3.7%), барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас 8.5 га (0.05%) гэсэн үзүүлэлттэй байна /Зураг 2.5.6.1/




Зураг 2.5.6.1. Ухагдаж эвдэрсэн газар, га-аар.

2022 оны мэдээгээр Сэлэнгэ, Өмнөговь, Говь-Алтай, Төв аймгуудад хамгийн их ухагдаж эвдэрсэн байдалтай байна.

2.6. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ГТ-7/

Нийслэл, 21 аймгаас ирүүлсэн 2022 оны “Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан”-г ГТ-7 маягтаар хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв. 2022 онд улсын хэмжээнд нийт 1'546'483 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан бөгөөд өмнө оны дүнгээс 1'711'032.1 га талбайгаар бага байна. Үүнийг дотор нь ангилан үзвэл тариалангийн 106'258.1 га, бэлчээр ба бусад өвслөг ургамал газрын 1'351'896.8 га, хот тосгон, бусад суурин газрын 15'685.8 га, ойн сан бүхий газрын 55'773.2 га, усны сан бүхий газрын 14'841.3 га газарт хамгаалах арга хэмжээг авсан бол 2'027.8 га газрыг уурхайн эдэлбэр газарт нөхөн сэргээх арга хэмжээг авсан байна /Зураг 2.6.1/




Зураг 2.6.1. Газар хамгаалах арга хэмжээ.

2.6.1 Тариалангийн газар

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг олон наст ургамал тарьсан, зурvasлан тариалсан, ойн зурvasаар хамгаалагдсан, химиин бордоогоор бордсон, шим ба эрдэс бордоогоор бордсон, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн гэсэн 6 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 106'258.1 га тариалангийн талбайд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 6.87 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 25'028 га талбайгаар бага байна.

Тариалангийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг шим ба эрдэс бордоогоор бордсон талбай 43'458.9 га буюу 40.9%, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай 43'227.3 га буюу тариалангийн газрын ангиллын 40.68%, химиин бордоогоор бордсон талбай 12'554.4 га буюу 11.4%-ийг тус тус эзэлж байна /Зураг 2.6.1.1/




Зураг 2.6.1.1. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан тариалангийн газар, га-аар.

2.6.2. Бэлчээрийн газар

Бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг элсний нүүлтээс хамгаалсан, тордон сайжруулсан, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн, хог хаягдлаас цэвэрлэсэн, даацыг зохицуулсан, ашиглалтаас чөлөөлсөн, сэлгэж ашигласан гэсэн 7 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 1'351'896.8 га бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 87.4 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 1'387'784.3 га талбайгаар буурсан байна.

Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг сэлгэж ашигласан талбай 705'634.8 га буюу бэлчээрийн газрын ангиллын 52.2%, хортон шавьж, мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн талбай 245'734.1 га буюу 18.8%, даацыг тохируулсан 210'521 га буюу 15.5%, хог хаягдлаас цэвэрлэсэн 86'081 га буюу 6.3%-ийг тус тус эзэлж байна /Зураг 2.6.2.1/




Зураг 2.6.2.1. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан бэлчээрийн газар, га-аар.

2.6.3. Хот тосгон, бусад суурины газар

Хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг хөрсжүүлж зүлэгжүүлсэн, мод бут сөөг тарьсан, далан хаалтаар хамгаалсан, нүх, гуу жалгыг тэгшилж янзалсан, ахуйн хог хаягдаас цэвэрлэсэн, үйлдвэрийн хог хаягдаас цэвэрлэсэн, элсний нүүлтээс хамгаалсан, химийн болон цацраг идэвхт бодисоос цэвэрлэсэн гэсэн 8 үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 15'685.8 га хот, тосгон, бусад суурины газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 1.9 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 14'317.1 га талбайгаар бага байна.

Хот, тосгон, бусад суурины газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг ахуйн хог хаягдлыг цэвэрлэсэн талбай 14'320.4 га буюу хот тосгоны ангиллын газрын 91.3%, мод бут, сөөг тарьсан талбай 781 га буюу 4.98%, нүх, гуу жалгыг тэгшилж янзалсан 563.8 га буюу 3.59 %-ийг тус тус эзэлж байна. /Зураг 2.6.3.1/



Зураг 2.6.3.1. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан хот тосгон, суурин газар, га-аар.

2.6.4. Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг ойн цэвэрлэгээ хийсэн, өвчин хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авсан, мод бут сөөг шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн гэсэн З үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 55'773.2 га ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 3.61 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 5'735.8 га талбайгаар бага байна.

Ойн сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг өвчин, хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авсан талбай 47'304 га буюу ойн сангийн ангиллын 84.8%, мод, бут, сөөг, шинээр тарьсан, нөхөн суулгалт хийсэн талбай 6'495.6 га буюу эзэлж 11.6 %, ойн цэвэрлэгээ хийсэн талбай 1'973 га буюу 3.5%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 2.6.4.1/



Зураг 2.6.4.1. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан ойн сан бүхий газар, га-аар.

2.6.5. Усны сан бүхий газар

Усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайланг ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан, усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан, усны үер, эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авсан гэсэн З үзүүлэлтээр гаргадаг.

Улсын хэмжээнд нийт 14'841.3 га усны сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан нь нийт талбайн 3.7 хувийг эзэлж байна. Энэ нь урьд оныхоос 43'759.3 га талбайгаар буурсан байна.


Усны сан бүхий газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газрын дийлэнх хэсгийг усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэх, хамгаалах арга хэмжээ авсан 14'404.9 га буюу усан сангийн ангиллын газрын 97%, ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээ авсан талбай 434.6 га буюу 2.9%, усны үер, эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авсан 1.8 га буюу 0.01%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 2.6.5.1/



Зураг 2.6.5.1 Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан усны сан бухий газар, га-аар.

2.6.6. Уурхайн эдэлбэр газар

Уул уурхайн ашиглалтын явцад ухагдаж эвдэрсэн 2'027.8 га газарт хамгаалалтын арга хэмжээ авснаас ухагдаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж булсан 1'629.6 га талбай, дарж булсан талбайг хөрсжүүлж ургамалжуулсан /биологийн нөхөн сэргээлт хийсэн/ 397.4 га, эвдрэлд өртсөн голын эрэг хавийн газрыг сэргээсэн /гольдролыг буцааж хэвэнд нь оруулсан/ 0.8 га талбай байна /Зураг 2.6.6.1/



Зураг 2.6.6.1. Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан уурхайн эдэлбэр газар, га-аар.

2022 оны мэдээгээр Төв, Дорноговь, Булган, Баянхонгор, Өмнөговь, Дархан-Уул аймгууд уурхайн эдэлбэр газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хамгийн их авч ажилласан байна.

2.7. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-8/

Газрын тухай хуулийн дагуу Монгол Улсын иргэн, хуулийн этгээд болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьялалгүй хүний эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу Улсын хэмжээнд ногдуулж, орлогыг бүрдүүлдэг бөгөөд 2022 онд Татварын ерөнхий газартай хамтран Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар” 187 дугаар тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Татварын ерөнхий газартай хамтарсан 2019 оны 173/178 тоот “Мэдээлэл солилцох журам”, “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ” 2019/09-01/32 дугаар гэрээний дагуу газрын төлбөрийг дундын мэдээллийн сангаар дамжуулан ногдуулж, төвлөрүүлж байна.

Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос **990 тэрбум 617 сая** төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс өссөн дүнгээр нийт **956 тэрбум 781 сая** төгрөгийг төвлөрүүлсэн байна /Хүснэгт 2.7.1/.


Хүснэгт 2.7.1. Газрын төлбөрийн гүйцэтгэл /он тус бүрээр/

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Гүйцэтгэл %/
1998	1,919.6	1,524.5	80
1999	2,678.6	1,764.2	66
2000	3,221.5	2,895.0	90
2001	4,673.6	5,401.9	116
2002	5,570.7	6,163.1	110
2003	7,303.4	7,962.0	109
2004	11,1840	11,795.2	99
2005	13,867.6	14,045.2	101
2006	14,323.0	15,780.7	110
2007	19,786.8	20,093.7	102
2008	24,790.4	25,543.4	102
2009	28,006.6	29,472.4	105
2010	29,311.7	30,448.6	104
2011	31,280.7	33,556.8	107
2012	39,031.3	43,623.2	112
2013	37,912.0	43,185.1	114
2014	42,326.9	44,950.9	106
2015	45,712.6	44,556.2	97
2016	47,002.6	46,940.4	99.9
2017	47,683.4	49,361.9	103.5
2018	48,875.9	51,616.9	105.6
2019	76,426.8	88,070.9	115.2
2020	125,070.0	107,413.3	86.4
2021	158,960.0	112,691.3	70.9

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

2022	154,322.02	117,924.24	76.4
Нийт	990,617.02	956,781.04	96.6

Улсын хэмжээнд 2022 онд газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт нийт 154 тэрбум 322 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 156 тэрбум 594 сая төгрөгийн ногдуулалт хийж, нийт 117 тэрбум 924 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 76.4 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна /Хүснэгт 2.7.2, Зураг 2.7.1/.




Зураг 2.7.1. Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /он тус бүрээр/

Газрын төлбөрийн 2022 оны батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэл тус бүрээр авч үзэхэд Архангай, Дархан-Уул, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл зэрэг аймгууд 100-150 хувийн гүйцэтгэлтэйгээр төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна /Хүснэгт 2.7.2, Зураг 2.7.2/.

Хүснэгт 2.7.2. Аймаг, нийслэлийн 2022 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт


№	Аймаг, нийслэл	Төлөвлөгөө (мян.төг)	Гүйцэтгэл (мян.төг)	Гүйцэтгэл (Хувь)
1	Архангай	267,603.0	270,432.0	101.1
2	Баянхонгор	460,000.0	390,225.0	84.8
3	Баян-Өлгий	320,000.0	197,443.7	61.7
4	Булган	898,266.9	843,172.1	93.9
5	Говь-Алтай	439,812.6	384,257.0	87.4
6	Говьсүмбэр	360,000.0	277,383.7	77.1
7	Дархан-Уул	1,500,000.0	1,759,126.1	117.3
8	Дорнод	1,593,335.6	1,430,133.8	89.8

9	Дорнговь	7,831,167.2	7,412,487.4	94.7
10	Дундговь	362,000.0	533,534.0	147.4
11	Завхан	560,000.0	589,690.0	105.3
12	Орхон	21,000,000.0	23,107,571.8	110.0
13	Өвөрхангай	721,776.6	752,774.0	104.3
14	Өмнөговь	13,124,500.0	11,753,119.1	89.6
15	Сүхбаатар	538,198.3	294,569.4	54.7
16	Сэлэнгэ	1,806,418.3	1,367,683.7	75.7
17	Төв	3,981,162.5	2,438,826.1	61.3
18	Увс	750,000.0	444,881.5	59.3
19	Ховд	706,076.6	821,810.0	116.4
20	Хөвсгөл	442,299.5	502,821.0	113.7
21	Хэнтий	782,500.0	779,944.8	99.7
22	Улаанбаатар	95,876,899.7	61,572,355.3	64.2
ДҮН		154,322,016.9	117,924,241.5	76.4




Зураг 2.7.2. Тайлант оны газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь

2019 онд Газрын төлбөр, татварын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, Татварын ерөнхий газартай хамтарсан дундын мэдээллийн сангаар дамжуулан газрын төлбөрийн нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээдэд илгээдэг болсноор цахим систем /Egazar.gov.mn, Ebarimt/, бүх банкны интернэт банк болон гар утасны аплликэйшн ашиглан түргэн шуурхай газрын төлбөрийн мэдээлэл авах, нэхэмжлэхээр төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлснээр газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт тогтмол нэмэгдэж байна /Зураг 2.7.3/.



Зураг 2.7.3. Газрын төлбөрийн орлого /1998-2022 он/

Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 5 тэрбум 232 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд сууринласан Газрын төлбөр, татварын системээр эрхэзүйн харилцаа үүссэн бүртгэлтэй нэгж талбар бүрт ногдуулалт хийж, Татварын системд илгээсэн бөгөөд цаашид Уул уурхайн ашиглалтын лиценз бүхий газар, Улсын тусгай хамгаалалтай газарт олгогдсон газруудыг тус системд бүрэн бүртгэж баталгаажуулснаар газрын төлбөрийн орлого өсөж цаашид нэмэгдэх хандлагатай байна.



Зураг 2.7.4. Тайлант оны газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл /хувиар/

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн аймгийн хувьд хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэгж талбар бүрд ногдуулж, хураан барагдуулах ажлыг батлагдсан журам, зааврын дагуу хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн 2022 онд газрын төлбөрийг ногдуулалт, нэхэмжлэх үүсгэх ажилд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түргэн шуурхай, нээлттэй ил тод, чирэгдэлгүй хүргэх үүднээс цахим систем /egazar.gov.mn, e-mongolia.mn/-ийг ашиглан газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.
- Иргэнд зориулсан цахим систем /Egazar.gov.mn, Ebarimt/, гар утасны аппликацийн /Egazar/, ашиглан түргэн шуурхай газрын төлбөрийн мэдээлэл авах, нэхэмжлэхээр төлбөрөө төлөх боломжийг хангах зорилгоор цахим шилжилтийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд иргэд, олон нийт уг төлбөрийн цахим системүүдээр газрын төлбөрийг төлж хэвшсэн байна.
- Салбартай аж ахуй нэгжүүдийн газрын төлбөрийн ногдуулалтыг төв салбарын татвар төлөгчийн дугаар дээр үүсгэх ажлыг зохион байгуулан ажилласан.
- 2020 оноос өмнөх газрын төлбөрийн үлдэгдлийг барагдуулах ажил нь Газрын албаны үйл ажиллагаанд хамаарч байсан тул тус ногдуулалтын барагдуулалтыг Газрын алба хариуцан гүйцэтгэсэн.

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй аймгуудын хувьд:

- Хадлан, бэлчээр, түр барилга байгууламж буюу жил болгон гэрээгээр ашигладаг газруудад төлбөр ногдуулж Татварын системд илгээх боломжгүй байсан.
- Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоож төсөв хөрөнгө байхгүй шалтгаанаар газрын төлбөр төлөхгүй байх;
- Газрын төлбөр төлөгч нь Татвар төлөгч байх ёстой бөгөөд татвар төлөгчөөр бүртгүүлээгүй иргэнийн газрын төлбөрийн ногдуулалт Татварын системд илгээгдэх боломжгүй байна.

2022 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт оруулсан орлогыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл хамгийн их хувийг хот тосгон, бусад суурины газар болон тусгай хэрэгцээний газар бөгөөд хамгийн бага хувийг усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газрын төлбөр эзэлж байна. Энэ нь хот суурин газарт эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тоо бусад ангиллын эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбарын тооноос харьцангуй их байгаатай холбоотой юм /Хүснэгт 2.7.3/.

Хүснэгт 2.7.3. Газрын төлбөрийн орлого төвлөрүүлэлт /Газрын нэгдмэл сангийн ангиллаар/

№	Аймаг, нийслэл	Газрын нэгдмэл сангийн ангилал					
		Хөдөө аж ахуйн эдэлбэр газар /мян. төгрөг/	Хот, тосгон, бусад суурины газар /мян. төгрөг/	Ойн сан бүхий газар /мян. төгрөг/	Усны сан бүхий газар /мян. төгрөг/	Зам шугам сүлжээний газар /мян.төгрөг/	Тусгай хэрэгцээний газар /мян. төгрөг/
1	Архангай	25,292.7	229,166.4	-	-	2,904.4	13,068.5
2	Баянхонгор	49,555.9	337,218.5	-	-	-	3,450.6

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

3	Баян-Өлгий	3,895.3	191,548.4	-	-	-	2,000.0
4	Булган	133,177.1	661,992.6	7,252.5	-	4,619.0	36,130.9
5	Говь-Алтай	54,982.7	325,958.5	-	-	-	3,315.7
6	Говьсүмбэр	862.6	275,676.6	-	-	-	844.5
7	Дархан-Уул	91,864.4	1,639,615.6	8,573.7	19,067.8	-	4.5
8	Дорнод	175,812.8	1,248,738.8	-	-	-	5,582.2
9	Дорнговь	30,356.7	7,293,837.3	-	-	86,858.8	1,434.6
10	Дундговь	29,114.5	483,018.1	928.1	-	16,388.2	4,085.1
11	Завхан	46,604.0	525,080.0	669.0	-	984.0	16,353.0
12	Орхон	24,954.9	23,050,593.6	9,044.0	-	21,640.5	1,338.8
13	Өвөрхангай	70,817.8	595,117.2	-	-	-	86,839.1
14	Өмнөговь	46,434.0	11,258,278.9	106,534.1	-	121,183.7	220,688.4
15	Сүхбаатар	75,626.0	216,345.4	291.8	-	-	2,306.2
16	Сэлэнгэ	345,778.3	998,510.9	-	-	-	23,394.5
17	Төв	342,248.1	1,398,392.3	-	-	59,645.3	638,540.4
18	Увс	58,507.9	354,142.3	-	-	-	32,231.3
19	Ховд	26,267.9	774,611.1	2,200.0	1,821.0	-	16,910.0
20	Хөвсгөл	78,466.1	344,662.8	180.0	-	-	79,512.1
21	Хэнтий	115,572.4	622,059.6	918.5	-	2,474.7	38,919.6
22	Улаанбаатар	539,206.8	36,700,337.9	216,165.1	-	868,177.8	23,248,467.7
Дүн		2,365,398.9	89,524,902.6	352,756.7	20,888.8	1,184,876.5	24,475,417.9
Хувь		2.0	75.8	0.3	0.1	1.0	20.8

Гэр бүлийн хэрэгцээнээс 1 тэрбум 426 сая төгрөг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс 2 тэрбум 365 сая төгрөг, улсын тусгай хамгаалалттай газраас 24 тэрбум 475 сая төгрөг, уул уурхайгаас 31 тэрбум 763 сая төгрөг, хот тосгон, бусад суурины газраас 56 тэрбум 335 сая төгрөг тус тус төвлөрүүлсэн бөгөөд ойн болон усны сан бүхий газар, зам шугам сүлжээний газруудаас бусад төлбөрийн орлогыг төвлөрүүлээд байна.

Газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын голлох хувийг улсын тусгай хамгаалалттай газар, уул уурхайн газар, хот тосгон, бусад суурины газрын төлбөрийн орлого бүрдүүлж байна.

2022 оны газрын төлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор хот тосгон бусад суурин газрын төлбөрийн итгэлцүүрийн тоон утга, бүсийн хил заагийг аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Газрын үнэлгээ зэрэглэл /бүс/-ийн зааг хязгаар, газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Шинэчлэн батлагдсан тогтоолын дагуу Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэн баталгаажуулж газрын төлбөрийг шинэчлэн бодуулж 2022 оны газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг цахимаар иргэн хуулийн этгээдэд хүргүүлсэн.

Газрын төлбөр, татварын системээр дамжуулан Татварын удирдлагын системд ногдуулалт илгээж байгаатай холбоотойгоор сум, дүүрэг тус бүрийн газрын төлбөрийг тодорхой гаргаж, төлбөрийг нэгж талбар тус бүрээр ногдуулж барагдуулах, газар эзэмшигчийн газрын төлбөрийн давхардлыг арилгах, алдааг засварлах, хянах, зорилгоор 7 хоног бүр ногдуулалт, нэхэмжлэх үүсгэх ажлын явцыг танилцуулж харилцан мэдээлэл солилцож, ажлын уялдааг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Татварын алба нь урьд оны дутуу төлөлтийг төвлөрүүлэх, газрын төлбөрийг барагдуулах, төлбөрийн гүйцэтгэлийг хангахын тулд тухайн Газрын албанд урьд оны газрын төлбөрөөр тооцоо нийлэн нэхэмжлэх үүсгэж өгөх ба барагдуулах ажлыг хамтран зохион байгуулж ажиллаж байна.

Ингэснээр гар утас, цахим хаяг /email/, и-баримт зэргээр газрын төлбөр төлөгч бүрд нэхэмжлэхийг шуурхай хүргэж, газрын төлбөр төлөгчийг мэдээллээр хангаж ажиллаж байна.

21 аймаг, нийслэлийн хэмжээнд Газрын татвар, төлбөрийн системээр дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- 2022 онд Газрын татвар, төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэлтэй нэгж талбар тус бүрд төлбөр ногдуулах, татварын удирдлагын системд илгээх ажлыг зохион байгуулах;
- Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсантай холбоотойгоор мөн Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу 330 сум, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулах;
- Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан тогтоолыг системд баталгаажуулж, газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх хил зааг, итгэлцүүрийг газар ашиглалтын зориулалт тус бүрээр оруулж баталгаажуулан газрын төлбөрийг шинэчлэн бодуулж, ногдуулалт, нэхэмжлэлийг үүсгэх;
- Үйлчилгээний хураамж, үнэт цаасны орлогыг Татварын удирдлагын систем болон Газрын төлбөр, татварын системээр төлбөрийн даалгавар үүсгэн, төлөх боломжийг хангах;
- Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран дундын мэдээллийн санг байгуулж ашиглалтын лиценз бүхий газруудыг Газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэж баталгаажуулж түүнд төлбөр ногдуулах;
- Газрын татвар, төлбөрийн урьд оны илүү, дутуу аймаг тус бүр нийт дүнгээр үүсгэсэн нэхэмжлэхийн төлөлтийг барагдуулж дуусгах;
- Иргэн хуулийн этгээдийн газрын төлбөрийн тооцоо нийлсэн актыг цахимаар авах хүсэлтийг баталгаажуулан шийдвэрлэж цахим хариуг илгээх;

Ингэснээр иргэн, хуулийн этгээд нь газартай холбоотой ямар нэгэн эрх зүйн харилцаанд ороход тухайн жил /улирал/-д газрын төлбөрийн үлдэгдэлгүй байх шаардлагатай тул цахимаар тус лавлагааг авснаар цаг хугацаа хэмнэх, түргэн шуурхай үйлчилгээ авах гэх мэт давууд үүсэх чухал ач холбогдолтой юм.

2.8. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-9/

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт **680797** иргэний **70.1 мянган** га газрын өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.



Зураг 2.8.1. 2003-2021 онуудын газар өмчлөлийн байдлыг иргэдийн тоотой харьцуулсан байдал

Хүснэгт 2.8.1. Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи газар өмчлөлийн байдал

№	Он	МУ-ын нийт хүн амын тоо	Газар өмчилсөн нийт иргэдийн тоо	Хувь
1	2003	2495091	21879	0.9
2	2004	2521733	63867	2.5
3	2005	2551081	135077	5.3
4	2006	2583254	152164	5.9
5	2007	2620446	174016	6.6
6	2008	2665955	222094	8.3
7	2009	2716275	203043	7.5
8	2010	2760968	255749	9.3
9	2011	2811666	255747	9.1
10	2012	2867744	330240	11.5
11	2013	2930277	371978	12.7
12	2014	2995949	418671	14.0
13	2015	3057778	446004	14.6
14	2016	3119935	537321	17.2
15	2017	3119935	570771	18.3
16	2018	3177899	615454	19.4
17	2019	3238479	637501	19.7
18	2020	3296866	647664	19.6

19	2021	3357542	663145	19.8
20	2022	3409939	680797	20.0

Тайлбар: 2022 оны байдлаар Монгол Улсын хүн амын тоо аймаг, нийслэлийн хэмжээнд нэгтгэгдэж, албан ёсоор гараагүй тул өмнөх оны /2021/ тоон мэдээг ашигласан болно.

Монгол Улсын нийт хүн амын тоотой газар өмчилсөн иргэдийн тоог харьцуулахад 20.0 хувь байх бөгөөд өмнөх оны хувьтай харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй өмчилсөн 69.3 мянган га газрыг 670574 иргэнд, аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж, 145.8 га газрыг 320 иргэнд, аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар 1.6 га газрыг 50 иргэнд, газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдаж 60.7 га газрыг 61 иргэнд худалдаж тус тус өмчлүүлээд байна.

Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийн тоог засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр харьцуулж, хүснэгт 2.8.2-т үзүүлэв.

Хүснэгт 2.8.2. Үнэгүй газар өмчилж авсан иргэдийг хүн амын тоотой харьцуулсан байдал

№	Аймаг	Хүн амын тоо	Өмчилсөн иргэдийн тоо	Хүн амын газар өмчилсөн байдал /хувиар/
1	Архангай	94205	17400	18.5
2	Баян-Өлгий	112836	13870	12.3
3	Баянхонгор	89043	12111	13.6
4	Булган	61943	16438	26.5
5	Говь-Алтай	57818	8040	13.9
6	Говьсүмбэр	18150	10075	55.5
7	Дархан-Уул	107751	14858	13.8
8	Дорноговь	71457	20880	29.2
9	Дорнод	83757	40565	48.4
10	Дундговь	46920	18230	38.9
11	Завхан	72731	9662	13.3
12	Орхон	108713	21098	19.4
13	Өвөрхангай	115732	26814	23.2
14	Өмнөговь	71720	42657	59.5
15	Сүхбаатар	64662	11301	17.5
16	Сэлэнгэ	108878	49500	45.5
17	Төв	93468	74940	80.2
18	Увс	84095	11088	13.2
19	Ховд	91127	13617	14.9
20	Хөвсгөл	136794	15168	11.1
21	Хэнтий	78967	24862	31.5
22	Улаанбаатар	1639172	207623	12.7
Улсын дүн		3409939	680797	20.0

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчилсөн иргэдийн тоог аймгийн хүн амын тоотой харьцуулахад Төв аймаг 78.1, Өмнөговь аймаг 58.8, Говьсүмбэр аймаг 54.9 хувиар хамгийн их хувьтай байгаа бол хамгийн бага хувьтай нь Баян-Өлгий аймаг 12.4 байна.

3 ДҮГНЭЛТ

Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 113567.1 мянган га буюу 72.6 хувь, хот, тосгон бусад суурины газар 1005.3 мянган га буюу 0.6 хувь, зам, шугам сүлжээний газар 836.0 мянган га буюу 0.5 хувь, ойн сан бүхий газар 14260.3 мянган га буюу 9.1 хувь, усны сан бүхий газар 660.9 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 26082.0 мянган га буюу 16.7 хувийг тус тус эзэлж байна. Газрын нэгдмэл сангийн 2022 оны тайлангийн дүнг 2021 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 412.9 мянган га-гаар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 49.1 мянган га, зам, шугам сүлжээний газар 358.8 мянган га, ойн сан бүхий газар 3.7 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 1.3 мянган га-гаар тус тус нэмэгдсэн байна. Усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна

Монгол Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн тооллогыг шинэчлэн хийж, газрын нэгдмэл сангийн мэдээллийн сангийн өгөгдлийг шинэчилж, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг цахимжуулан, салбар хоорондын болон төрийн өмчийн газрын мэдээллийн санг байгуулснаар газрын нэгдмэл сангийн тайланг цахим системээс гарган тайлагнах нөхцлийг бурдүүлэхээр ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт **1198241** газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ **46765**-аар нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт **8496.9** мянган га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс **70.1** мянган га-г өмчилж, **7676.2** мянган га-г эзэмшиж, **722.8** мянган га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага **27.8** мянган га газрыг тус тус ашиглаж байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт **680797** иргэний **70.1 мянган** га газрын өмчлөх эрхийг баталгаажуулсан байна.

“Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн Газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах” ажлын үр дүнгээр улсын хэмжээнд нийт 558955 зөрчилтэй нь тогтоогдсон бөгөөд зөрчил арилгах ажлын хүрээнд 375953 нэгж талбарыг Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүртгэж, 5387 зөрчлийг Засаг даргын захирамж шинэчлэн гаргаж, 4598 зөрчлийг тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, 515 зөрчлийн харьяалах нутаг дэвсгэрийн гадна олгосон зөрчлийг зөвлөмжийн дагуу арилгаж, 247 зөрчлийг газар чөлөөлөх арга хэмжээг авч тус тус шийдвэрлэн, зөрчлийг 69.2 хувиар арилгасан байна.

Цаашид зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг 100 хувь арилгахаар тухайн ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2022 онд нийт 4'844'764.2 га газарт хохирол учирсан байгаа бөгөөд өмнөх оны дүнгээс 1'462'590.2 га талбайгаар буурсан бөгөөд тухайн онд 1'546'483 га газарт хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авсан бөгөөд өмнө оны дүнгээс 1'711'032.1 га талбайгаар буурсан байна.

Улсын тусгай хэрэгцээний газар нь Улсын хэмжээнд нийт газар нутгийн 16.67 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оны газрын нэгдмэл сангийн тайлангаас 0.01 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын тусгай хэрэгцээний газрын хамгийн их буюу 87.07 хувийг улсын тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байгаа бөгөөд хамгийн бага буюу 0.0001 хувийг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газрууд тус тус эзэлж байна. Харин үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар 0.2 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газраас улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах зэрэг томоохон бодлогуудыг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газар цаашид ч нэмэгдэх боломжтой юм.

Тайлант онд Засгийн газрын 171, 282, 377 дугаар тогтоолуудаар үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зориулалтаар нийт 1315.9 га талбайг, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих зориулалтаар 20.0 га талбайг тус тус Улсын тусгай хэрэгцээнд авсан байна. Харин газар нутгийг Улсын тусгай хэрэгцээнд авах талаар Улсын Их Хурлын тогтоол, шийдвэр гараагүй.

Цаашид газар нутгийг Улсын тусгай хэрэгцээнд авах тухай УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр гарсан тухай бүрд нь газрын нэгдмэл сангийн цахим системийг ашиглан газрын нэгдмэл сангийн өөрчлөлтүүдийг тусгаж байх шаардлагатай байна.

Тайлант оны газрын төлбөрийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 5 тэрбум 232 сая төгрөгөөр өссөн дүнтэй байгаа нь Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд суурилсан Газрын төлбөр, татварын системээр эрхэзүйн харилцаа үүссэн бүртгэлтэй нэгж талбар бүрт ногдуулалт хийж, Татварын системд илгээсэн бөгөөд цаашид Уул уурхайн ашиглалтын лиценз бүхий газар, Улсын тусгай хамгаалалттай газарт олгогдсон газруудыг тус системд бүрэн бүртгэж баталгаажуулснаар газрын төлбөрийн орлого өсөж цаашид нэмэгдэх хандлагатай байна.

ХАВСРАЛТУУД



Жил бүр сүм, дүүргийн Засаг дарга 12-р сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дараа оны 01-р сарын 15-ны дотор Газрын асуудал эхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гарчнаа.

Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛЛЫН 2022 ОНЫ ТАЙЛАН

Маяцт ГТ-1

/Га-Гаар/

Д/д	АНМЛНИН НЭД	БҮГД	ҮННЭС	ХӨДӨӨ АЖАХҮҮН ГАЗАР																		
				Ү	Ү	Н	Э	Э	С	Ү	Ү	Н	Э									
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	
1	Архангай	5531382.0	3849454.6	3737445.2	2240741.9	1496703.4	53910.0	30220.4	27875.0	1319.9	197.2	128.4	700.0	0.0	26976.2	902.7	711.6	682.6	2.0	189.1	0.0	
2	Баян-Улсын нийслэлийн төслийн тогтолцоогоор	11597680.2	8837738.0	8812453.8	4248646.6	4563807.2	10662.8	2341.8	0.0	1035.6	6416	26.8	6.0	390.1	10125.4	1963.6	1875.2	1875.2	88.4	190.15	190.15	
3	Баян-Өлгий	4570589.1	3539292.3	3522048.0	1698974.2	1823073.8	11532.5	2797.4	257.3	654.0	528.9	38.1	0.0	1319.2	383.4	2409.5	634.8	634.8	0.0	1774.7	121.15	
4	Булган	4873300.0	2729302.4	2482675.3	1172901.4	1309723.9	111940.1	90699.6	39281.6	763.7	12396.5	156.0	33585.0	4516.8	25596.3	4043.5	3844.3	3844.3	3845.2	100.3	99.0	16397.6
5	Төв-Алтай	14144767.0	8614077.9	8601085.7	3503858.3	5097227.4	2678.1	5792.8	2013.7	1247.8	561.2	1644.3	325.8	458.5	4062.9	2983.2	2983.2	2983.2	1049.9	29.8		
6	Төв-Овхорон	554180.0	484815.8	472383.4	189325.9	283057.4	7810.0	452.0	175.0	5.0	272.0					77.5	61.9	61.9	15.6	4092.8		
7	Дархан-Улсын нийслэлийн тогтолцоогоор	327500.0	221029.4	174763.0	78681.6	95081.5	9072.5	34411.0	96095.5	2133.9	866.0	535.5	15791.2	5474.9	103.7	2679.2	1635.4	411.0	48.1	995.6	0.0	
8	Дорноговь	10947230.0	949625.7	9062627.2	5415079.9	3647547.2	112.0	749.2	200.3	490.4	25.0	21.0	3.0	9.5	329.3	6475.8	6421.8	5232.7	47.9	6.1	420332.2	
9	Дорнод	12359743.0	9627078.9	8650239.2	4202103.7	4448135.5	839294.1	97433.9	40925.0	489.0	1661.0	55.0	27074.0	27229.9	27229.9	12840.8	11134.8	11134.8	33.2	1672.8	0.0	
10	Дундговь	7469032.0	67894009.7	6789677.3	3303454.8	3448222.5	838.3		227.8	390.5	220.0					3481.1	2558.0	2558.0	2558.0	2558.0	923.1	13.0
11	Завхан	8245566.5	6578836.7	6515321.1	3649641.6	2855730.6	6495.5	20938.5	2741.7	1035.8	14613.1	97.3	1869.0	581.6	371785.2	4295.3	4284.7	4161.4	0.0	10.7	0.0	
12	Орхон	844000.5	45601.2	38614.8	11792.8	26822.0	1404.2	5179.8	3147.0	843.4	46.1	27.6	1023.4	92.3	253.1	149.4	80.8	83.1	38.4	30.1	0.0	
13	Өвөрхийн нийслэлийн тогтолцоогоор	6289533.0	5739543.8	567943.9	2835224.6	2844209.3	6587.7	26733.5	20242.5	1366.7	2756.2	2368.1	0.0	0.0	21603.0	5196.6	3390.7	3390.7	48.8	175.1	0.0	
14	Өмнөговь	16538047.0	11780576.6	11419417.7	4764723.6	6654694.1	30.0	733.1	0.0	527.3	182.5	20.4	0.0	3.0	26.8	3374.0	3200.4	3200.4	1.0	172.6	356995.0	
15	Сүхбаатар	8228715.6	7746676.1	7668339.7	3001998.2	44489.0	17375.9	500.0	10116.5	6734.5	24.9	0.0	0.0	0.0	13933.1	2478.4	2315.8	2315.8	0.7	162.0	0.0	
16	Сэлэнгэ	4115263.0	2051848.3	1604241.5	641794.3	962447.2	123201.5	317209.1	157087.8	5857.5	34294.0	459.6	93832.4	25677.8	2819.6	4369.2	3689.5	3233.1	626.1	46.2	7.4	
17	Төв	7404237.0	5540333.4	5157056.0	2386863.3	2770192.8	63109.5	265226.2	85366.0	12443.7	33752.1	416.3	85419.4	47828.6	35374.9	4674.1	2800.6	1286.8	765.4	1108.1	14892.7	
18	Увс	6958539.0	4666485.1	4106980.2	1614236.1	2492744.1	22714.5	83557.7	22276.5	522.8	1849.4	10012	6278.0	51629.8	1840.7	4706.1	4018.8	3416.1	591.3	96.1	446686.0	
19	Хөвд	7606038.0	5097239.0	5033421.3	3125266.8	1928154.5	18155.0	14634.2	1678.9	5140.8	477.4	75.9	0.0	2381.1	2165.4	3340.5	2952.4	2952.4	30.0	358.1	7.6	
20	Хөвсгөл	10062832.0	4479246.9	4384615.2	2060444.9	2324170.3	44359.7	33477.1	17541.1	2119.1	1680.7	314.8	11297.2	524.1	7765.1	8907.1	8080.4	8080.4	8080.4	0.0	827.3	122.2
21	Хантий	8032506.0	5429453.0	5007593.0	18666057.3	3141535.7	325988.8	81033.3	19991.0	580.7	8373.4	476.9	2347.0	28140.4	5910.6	8719.5	7811.1	7811.1	87.4	821.0	0.0	
22	Нийслэл	470444.0	229496.5	210807.7	81546.2	129261.5	5582.0	8042.0	0.0	6138.6	400.8	1358.1	0.0	144.5	2733.8	2281.1	1927.0	1927.0	72.9	22.7	331.3	
